

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2023 оны 12 дугаар сарын 25 өдөр

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая, төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
НЭГ.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
1.1 ЭРҮҮЛ МЭНД:							
1.1 Хүн амын халдварт болон халдварт бус өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх “Эрүүл Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.							
1.1.1	“Эрүүл Чингэлтэй-2024” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж, дүүргийн ИТХ-д хагас бүтэн жилээр тайлагнан ажиллах	300.0 Дүүргийн н төсвийн хөрөнгө	Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80%	100%	Эрүүл Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээний хүрээнд 2023 онд 4 зорилт 25 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажилласан. Тус арга хэмжээний үйл ажиллагааны хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр дүүргийн ИТХ-ын нийгэм, цахим бодлогын хороонд тайлагнаж, холбогдох санал, зөвлөмж, дүгнэлтийг авч хэрэгжүүлж ажиллаж байна.	70
1.1.2	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг хамрагдалтыг сайжруулах		Эрт илрүүлэг, үзлэгт хамрагдалт, хувиар	40%	100%	Халдварт бус өвчний эрт илрүүлэг, үзлэг 2023 оны 11 дүгээр сарын байдлаар: Артерийн гипертенз эрт илрүүлэгт хамрагдвал зохих 93903 иргэдээс 45193 иргэн буюу 47,10% нь хамрагдсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт хамрагдвал зохих 59125 иргэдээс 37709 буюу 59,70% нь хамрагдсан байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт 12719 хүн хамрагдахаас 7745 хүн буюу 64,40 хувь нь хамрагдсан байна.	70

						Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт 10799 хүн хамрагдахаас 3794 хүн буюу 35,1 хувь хамрагдалтай байна. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт 39957 хүн хамрагдахаас 11024 хүн буюу 28,8 хувь хамрагдсан байна. 2023 оны байдлаар Эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд 44079 хүн хамрагдаж хамрагдалтын хувь 30.46% байна. Дүүргийн 0-17 насны хүүхдийн хамрагдалт: 47064 хүүхэд хамрагдахаас 30511 буюу 64.82 %-тай Дүүргийн 18-аас дээш насны хүн амын хамрагдалт: 97108 хүн хамрагдахаас 13568 буюу 13,97 % тай байна.	
1.1.3	Товлолд болон товлонд бус дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчний тандалтыг бэхжүүлнэ.	30.0 Улс, орон нутгийн төсөв	Хамрагдсан хувь	85%	100%	Дүүргийн 1-24 хорооны 16 өрхийн эрүүл мэндийн төвийн дархлаажуулалтын 16, ЭМТ-ийн 1 буюу дархлаажуулалтын нийт 17 нэгжээр дархлаажуулалтыг гүйцэтгэж байна. - Дархлаажуулалтын нэгжүүдийн хөргөгчийн ажиллагаа болон хэмийн хяналт хэвийн, хүйтэн хэлхээ, вакцин найруулах уусмалын хадгалалтын горимд алдаа гараагүй. - ХӨСҮТ-ээс 10 удаагийн татан авалтаар 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 44730 хүн/тун вакцин, тариур дагалдах хэрэгслийг татан авч дархлаажуулалтын байнгын болон түр цэгүүдээр дамжуулан дархлаажуулалтыг хэвийн гүйцэтгэсэн. Товлолын дархлаажуулалтад 2023 оны байдлаар нийт давхардсан тоогоор нийт 12100 хүүхэд хамрагдахаас 11744 хүүхэд хамрагдан, хамрагдалт 97 хувьтай байна.	90

						Улаан бурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтад 10 сараас 8 насны 17700 хүүхэд хамрагдахаас 13819 хүүхэд хамрагдан 78 хувьтай байна. - Улирлын томуугийн эсрэг 2023 оны 10 сараас эхэлсэн вакцинд эрсдэлт бүлгийн 12460 хүн хамрагдахаас 9137 хүн хамрагдсан буюу 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар 73.3% хамрагдсан байна.	
1.1.4	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дүүргийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн гэрээг хагас бүтэн жилээр дүгнэх ажлыг зохион байгуулж, үр дүнг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх	- Дүүргийн төсөв	Зохион байгуулсан ажлын тоо	2	2	2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг үнэлж, урамшуулал олгох тухай" А/275 дугаар захирамжаар бүрэн хангалттай үнэлгээгээр 10 өрхийн эрүүл мэндийн төв, хангалттай үнэлгээгээр 6 өрхийн эмнэлэг дүгнэгдэн зохих урамшууллыг олгосон. Жилийн эцсийн гүйцэтгэлийн гэрээг НЭМГ-ын даргын 2023 оны А/66 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын А/199 дүгээр захирамжаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн үндсэн 2 чиглэл нийт 135 оноо шалгуураар мэдээ тайлан статистик үзүүлэлт болон бусад холбогдох баримт бичиг тайлбарт үндэслэн гэрээг дүгнэн ажилласан.13 өрхийн эрүүл мэндийн төв бүрэн хангалттай, 3 өрхийн эрүүл мэндийн төв хангалттай үнэлгээгээр дүгнэгдсэн.	100
1.1.5	Азийн Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалтаар баригдах дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлүүлэх	Азийн хөгжлийн банк	Хяналт тавьсан ажлын тоо	2	3	Шинээр баригдах эмнэлэгт шаардлагатай техникийн нөхцөл хүссэн ачааллыг ХУД-т баригдах эмнэлгийн барилгын архитектур төлөвлөлтийн ажилд шалгарсан ВТ ХХК-тай хамтран боловсруулсан саналыг харгалзан тус компаниар гаргуулж НЗДТГ-аас 300,0 сая төгрөгийн төсөв бүхий тендерийн	30

						ажлыг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан зарласан. Тендерт Ричвел интернейшнл ХХК-д шалгарсан ба одоогоор дэд бүтцийн зураг төслийн ажил бүрэн боловсруулагдаж дуусаагүй байна.	
1.1.6	Эрүүл мэндийн мобайл технологийн иж бүрдэлтэй ӨЭМТ-үүдийн тоог нэмэгдүүлэх	70.0 Дүүргийн төсөв	ӨЭМТ-ийн тоо	6	7	Чингэлтэй дүүргийн 11, 12, 13, 17, 18, 19 дүгээр хорооны ӨЭМТ-дэд өмнөх жилүүдэд олгосон мобайл харилцан адилгүй байдлаар ашиглагдаж байна. Дүүргийн 9, 16 дугаар хорооны 2 ӨЭМТ-д ЭМЯ, ДЭМБ-ын хөрөнгө оруулалтаар мобайл технологийн иж бүрдлийг 2023 онд шинээр олгосон. Мобайл тоног төхөөрөмжийн үзлэгт 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар 3489 хүнийг хамруулсан. Уг ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд ЧДИТХ-ын дэмжлэгтэйгээр 20 сая төгрөгийн үнэ бүхий 5 төрлийн түргэвчилсэн сорилын худалдан авалтыг хийж эрсдэлт бүлгийн, эрүүл мэндийн даатгалгүй 1600 иргэнийг 2023 оны 10-11 дүгээр сард эрт илрүүлэгт хамруулж ажилласан.	90
1.1.7	Дүүргийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл”-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	5.0 Дүүргийн төсвийн хөрөнгө	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	30%	35%	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ЧДЭМТ-ийн Хайлааст хүүхдийн салбарт 14 хоног тутамд хуралдсан. Тус хурлын үйл ажиллагааны хүрээнд 2023 онд нийт 218 хүүхэд байнгын асаргаа тогтоогдсон. Мөн төрөлжсөн мэргэжлийн багийн дүгнэлтээр 1 хүүхдэд байнгын асаргааг тогтоосон байна.	70

1.1.8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулах арга хэмжээ зохион байгуулах		Үйл ажиллагааны тоо	2	3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжих сар"-ын аяны хүрээнд 1-24 дүгээр хороодын гэрийн эргэлт, гэрийн сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг хэвтрийн өвчтэй нийт 250 иргэдэд үзүүлсэн. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч нийт 684 хүнд багц шинжилгээг хийж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж өдрийн эмчилгээ хийсэн. - Цус харвалт болон ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдийн алдагдсан үйл ажиллагаа, хөдөлгөөний чадварыг боломжийн хэмжээнд хүртэл сэргээж, тогтворжуулах урт хугацааны сэргээн засах эмчилгээнд 85 хүн хамрагдсан. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээг хангасан бие засах өрөө 2 өрөө тохижуулсан. - Хүүхдийн амбулаторийн сэргээн засах кабинтад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгайлан зориулсан Адель, Атлант эмчилгээнд хамрагдсан тогтмол 8 хүүхэд хамрагдсан ба зөвлөгөө мэдээлэлд давхардсан тоогоор 320 хүүхэд хамрагдсан байна. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг витаминаар хангах ажлыг хороодын ӨЭМТ-үүд зохион байгуулж 120 хүүхдэд витамин С 1000 мг, витамин Д 1000 ед тарааж өгсөн.	90
1.1.9	“Хотын хөгжлийн индекс”-ийн 2022 оны маягтуудыг http://happycity.mn/ програмд шивэлт	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	70%	100%	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Аргачлал шинэчлэн батлах тухай” 20 дугаар тогтоол, Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны “Хотын хөгжлийн индекс тооцох аргачлал	70

	хийж, холбогдох дээд байгууллагад хүргэн ажиллах					батлах тухай” А/77 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 1-24 дүгээр хороодын хотын хөгжлийн индексийн анхан шатны мэдээллийн бодит байдал, чанарт үнэлгээ хийж дүгнэлт гаргах, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөн туслах үүрэг бүхий Мониторингийн ажлын хэсэг 2023 оны 5 дугаар сард батлагдсан хуваарийн дагуу зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Дүүргийн 1-24 дүгээр хороодын "Хотын хөгжлийн индекс"-ийн үзүүлэлтүүдийн анхан шатны мэдээллийг 2023 оны жилийн эцсийн байдлаар http://happycity.mn/ программд шивэх чиглэлийг өгч, хяналт тавьж ажилласан. Индексийн холбогдох маягтуудыг баталгаажуулан авч шалгасан.	
--	--	--	--	--	--	--	--

1.2 БИЕИЙН ТАМИР, СПОРТ

1.2 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилго бүхий “Чингэлтэй лиг” олон төрөлт уралдаан тэмцээнийг жил бүр зохион байгуулна.

1.2.1	Ахмад, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд дүүргийн аварга шалгаруулах спортын тэмцээн уралдааныг зохион байгуулах	Улсын төсөв 11.160	Зохион байгуулагдсан тэмцээний тоо, хамрагдсан иргэдийн тоо	12/1030	12/1050	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын 7 төрөлт тэмцээнийг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 34 байгууллагын 1290 тамирчныг хамрууллаа. Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аварга шалгаруулах 3 төрөлт тэмцээнийг 2023 оны 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, 10 байгууллагын 80 гаруй тамирчныг оролцуулан зохион байгуулсан.	100
1.2.2	Дүүргийн залуучууд аварга шалгаруулах 5 төрөлт Лигийн тэмцээнийг зохион	12.040 Орон нутгийн төсөв	Зохион байгуулагдсан тэмцээний тоо,	3/800	3/900	Дүүргийн залуучуудын аварга шалгаруулах Лигийн тэмцээнийг дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран зохион	100

	байгуулж, иргэдийг идэвхтэй хамруулах		хамрагдсан иргэдийн тоо			байгуулж, нийт 21 багийн 1470 гаруй тамирчин оролцсон.	
1.2.3	“Нийслэлийн иргэдийн спортын их наадам”-д дүүргийн иргэдийг оролцуулах	20.0 Улсын төсөв	Зохион байгуулагдсан тэмцээн, тамирчдын тоо	8/500	9/600	Нийслэлийн Иргэдийн спортын XI их наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 9 төрлөөр зохион байгуулж 24 байгууллагын 2710 иргэн хамрагдсан.	100
1.2.4	“Улаанбаатар марафон” олон улсын гүйлтийн тэмцээнд ажилтан, албан хаагч, иргэдийг оролцуулах	2.0 Улсын төсөв	Хамрагдсан иргэдийн тоо	3500	3800	Дүүргийн иргэдийг биеийн тамир, спортоор хичээллүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар марафонд нэгдэцгээе” олон улсын гүйлтийн тэмцээнийг 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, Төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтан, албан хаагчид, иргэд, сурагчдаас бүрдсэн нийт 82 байгууллагын 4538 хүнийг хамруулсан. Энэ арга хэмжээний хүрээнд дүүргийн хуваарьт зам талбайд /Тусгаар тогтнолын талбай, Урт цагааны гудамж, Самбуугийн гудамж, Анкарагийн гудамж/ соёл урлагийн арга хэмжээ, Эрүүл мэндийн төвийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэж, 23 аж ахуй нэгж байгууллага худалдаа үйлчилгээ, street food үйлчилгээг зохион байгуулсан.	100
1.2.5	“Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг”-аар ББХЧТТ Сорил авах, ажилтан, албан хаагчдыг хамруулах	8.0 УТөсөв 1.0 ОНТөсө в	Хамрагдсан иргэдийн тоо	13.800	14,000	Ерөнхийлөгчийн зарлигаар “Бие бялдрын түвшин тогтоох сорил авах ажил”-ыг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж зэрэг нийт 76 байгууллагын 17,680 албан хаагчид, иргэд, сурагчид хамрагдлаа. Сорилд хамрагдсан иргэдийн 65 хувь нь А, В, С үнэлгээтэй үнэлэгдсэн.	100

1.2.6	Төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах	30.0 ОНТөсө в 10.34 УТөсөв	Зохион байгуулагдсан тэмцээний тоо, хамрагдсан тамирчдын тоо	21/2000	21/2100	Дүүргийн Биеийн тамир, спортын хорооноос нийтийн биеийн тамирын арга хэмжээг 23 төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 466 байгууллагын 48,461 албан хаагчид болон иргэдийг хамрууллаа. Үүнд: Дүүргийн хэмжээнд 8 заал, 14 танхимд өглөө бүр 06:30-07:30 цагийн хооронд иргэдийг үнэ төлбөргүй, дасгал хөдөлгөөн хийх нөхцөлөөр хангаж ажиллаж, 14-73 насны нийт 6000 иргэнийг хамруулан ажилласан. “Эртэч Чингэлтэйчүүд” аяныг 2023 оны 04 дүгээр сарын 15-наас 2023 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хооронд нийслэлийн 4 хайрхны чиглэлд зохион байгуулж, 150 байгууллагын 3500 албан хаагчид, иргэдийг хамрууллаа. Дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ажилтан албан хаагчдын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Засаг даргын нэрэмжит “Спорт наадам 2023” тэмцээнийг 03 дугаар сарын 31-нээс 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулж, 38 цэцэрлэгийн 456 баг тамирчид оролцлоо. Засаг даргын нэрэмжит “Спорт наадам-2023” тэмцээнийг 03 дугаар сарын 27-ноос 03 дугаар сарын 29-ний өдрүүдэд зохион байгуулж 18 сургуулийн 924 тамирчин 42 багц медалийн төлөө оролцсон. Дүүргийн 1-24 дүгээр хороодын ажилтан, албан хаагчдын дунд спортын 3 төрөлт тэмцээнийг 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, нийт 24	100
-------	--	--	--	---------	---------	--	-----

						хорооны 276 албан хаагчийг хамруулсан. Дүүргийн Засаг даргын нэрэмжит аж ахуйн нэгж, байгууллагуудын дундах Спорт тэмцээнийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, нийт 24 багийн 168 ажилтан, албан хаагч оролцсон.	
1.2.7	Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлж иргэдийг биеийн тамир спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэн, оролцоог нэмэгдүүлэн ажиллах	-	Зохион байгуулах арга хэмжээ, оролцогчдын тоо	1500	1550	Дүүргийн хэмжээнд хоккей, тэшүүрийн өсвөрийн шигшээ баг тогтмол бэлтгэл сургуулилтад хамрагдаж байна. Мөн өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлэх иргэдийн биеийн тамир спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр 17 арга хэмжээг зохион байгуулж 461 байгууллагын 46832 хүн давхардсан тоогоор хамрагдсан байна.	100
1.2.8	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг уралдаан тэмцээнд оролцох нөхцөлөөр ханган, дэмжиж ажиллах	132.960 Орон нутгийн төсөв	Авсан медалийн тоо	184	250	Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2022 оны А/39 дүгээр захирамжаар “Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөл”-ийг байгуулсан. Спортын 14 төрөлд 453 тамирчин 2023 онд хамрагдаж тэмцээний болон техникийн 2506 цагийн бэлтгэл сургуулилт явууллаа. Дасгалжуулагч нартай хамтран ажиллах гэрээ байгуулж, өдөр тутамд хяналт тавин ажиллаж байгаа ба Өсвөрийн шигшээ багийн тамирчид улс, нийслэл, олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс нийт 122 медаль хүртсэн амжилттай байна. Өсвөрийн шигшээ багийн 1 дасгалжуулагчийг олон улсын дасгалжуулагчийн сургалтад хамруулж, дасгалжуулагч нарын цалин,	70

						урамшууллыг гүйцэтгэл, үр дүнгээр нь үнэлэн хяналт тавин олгож байна. Япон улсын Яйзү хотын хамтын ажиллагааны хүрээнд Чөлөөт бөхийн 2 дасгалжуулагч 2023 оны 05 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд онол практикийн хосолсон сургалтыг зохион байгууллаа. Яйзү хотын Боловсролын хорооны дарга Ханэда Акио тэргүүтэй Боловсролын хороо, Нийтийн биеийн тамирын мэргэжилтнүүд, Сагсан бөмбөгийн баг биеийн тамир спортын хорооны үйл ажиллагаатай танилцсан ба Яйзү хотын Сагсан бөмбөгийн тамирчид, дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг хоорондын нөхөрсөг тоглолтыг 2023 оны 08 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд зохион байгуулсан.	
1.3 БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН							
1.3 Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын хичээлийн чанарыг ахиулах, сэтгэлгээний өндөр хурдтай иргэнийг төлөвшүүлэх зорилгоор “Оюунлаг Чингэлтэйчүүд” төслийг хэрэгжүүлнэ.							
1.3.1	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Оюунлаг Чингэлтэй” уралдааныг үе шаттай зохион байгуулах	-	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	2	3	“Оюунлаг Чингэлтэйчүүд” уралдааныг дүүргийн Математикийн багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих багтай хамтран 4 үе шаттай зохион байгуулсан ба 13 сургуулийн дунд ангийн 260 бүлгийн 10,150 суралцагч оролцож, Шилдэг багшаар 5, 23, 39 дүгээр сургуулийн багш нар, дүүргийн шилдэг сургууль”-аар 5 дугаар сургууль шалгарсан. Ерөнхий боловсролын сургуульд 2-5 жил ажиллаж байгаа багш нарын дунд “Залуу багш-манлайлал” ур авьяасын тэмцээнийг зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн 16 сургуулийн 30 багш оролцлоо.	100

1.3.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтыг үе шаттай зохион байгуулах	-	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	2	4	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах хүрээнд ЕБС-ийн дунд ангийн багш нарт “ХБХ-тэй хүүхэдтэй ажиллах арга зүйг түгээн дэлгэрүүлэх” 6 удаагийн сургалтад дүүргийн 15 сургуулийн 200 багшийг хамруулсан. "Гэрээр айлчлах" хөтөлбөрийн сайн дурын ажилтнууд болон 92 багшид "Хүүхэд хамгаалал"-ын сургалтыг 4 удаа зохион байгуулсан. “Дээрэлхэгч биш-Дэмжигч байя” аянд 17 сургууль төлөвлөгөө гарган ажиллаж, өсвөрийн 30 сургагч багш бэлтгэн ажиллаж байна. “Шийтгэл бол шийдэл биш” аяны хүрээнд 17 сургуулийн 3500 эцэг эх, багш сурагчдад “Багш, хүүхэд, эцэг эхчүүд хамтдаа” сургалтыг зохион байгуулсан. “Сургуультай танилцах өдөрлөг”-ийг хамран сургах тойргийн 24 хороо, цэцэрлэгүүдтэй хамтран зохион байгуулж 2023-2024 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид элсэн суралцах хөгжлийн бэрхшээлтэй 39 хүүхдийн судалгааг авсан. Дунд ангийн багш нарт зориулсан ХБХ-тэй ажиллах арга зүйг сургалтад 15 сургуулийн 30 багшийг хамруулсан. “Ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүй сургалтад 8 эрхлэгч арга зүйч сургагч багшаар бэлтгэгдэн 246 цэцэрлэгийн эрхлэгч Я.Саранчимэг Өвөрхангай аймгийн 250 багшид сургалт хийсэн.	90
-------	---	---	---------------------------------------	---	---	--	----

						Хичээлээс гадуурх сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөө боловсруулах, анги удирдсан багшаар дамжуулан эцэг эхийн боловсролыг дэмжих арга зүйд тулгуурласан сургалтыг 17 сургуулийн нийгмийн ажилтнуудад 2 удаа зохион байгуулсан. Хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж сургалтад 120 багш хамрагдаж, СӨББ-ын 3 сургагч багштай болсон. Тэгш хамруулан сургах сургагч багш бэлтгэх сургалтад хүүхэд хөгжил хамгааллын мэргэжилтэн 117, 37 дугаар сургуулийн сургалтын менежерүүд сургагч багшаар бэлтгэгдэн Увс, Сүхбаатар аймгийн багш нарт сургалт зохион байгуулсан. Японы хүүхдийг ивээх сангийн Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрөөс “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөлд 17, 50 дугаар сургуулиуд хамрагдаж 2 удаагийн сургалтад ажлын хэсгийн багаар хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо хамтран зохион байгуулж байгаа “Тэгш оролцоот хүртээмжтэй нийгэм” сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн хэлтсийн мэргэжилтэнүүд хамрагдаж ажилласан.	
1.3.3	Сургууль, цэцэрлэгийн гадна орчны аюулгүй байдлыг хангах	-	Зохион байгуулсан үйл	3	4	“КОИКА”-аас сургуулийн аюулгүйн бүс байгуулах, "Хүүхдэд ээлтэй аюулгүй Улаанбаатар" хамтран ажиллах төсөлд дүүргийн Ерөнхий боловсролын 39, 117	70

	чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах		ажиллагааны тоо			дугаар сургуулиуд сонгогдож, судалгааны ажлаа эхлүүлсэн. Нийслэлийн Засаг даргын А/110 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2020- 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд "Сургуулийн автобус" төсөлд 5, 23, 24, 72, 139, 149 дүгээр сургуулиуд хамрагдаж, 37, 49, 72, 117, 140, 149 дүгээр сургуулиудад шинээр 7 автобусыг хүлээлгэн өгч, 12 чиглэлд 10100 сурагчийг тээвэрлэсэн. Ерөнхий боловсролын 39, 57 дугаар сургуулийн фасад шинэчлэх, цонх бүрэн солих засвар үйлчилгээг төслийн шугамаар шийдвэрлэсэн.	
1.3.4	Боловсролын байгууллагын багш, ажилчдын ур чадварыг хөгжүүлэх сургалт зохион байгуулах	4.0 сая Дүүрэг, ОНТөсө в	Хамрагдсан багш, ажилчдын тоо	1200	1250	Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын Ерөнхий газраас “Элф хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байгаа ба уг хөтөлбөрт дүүргийн 33 дугаар цэцэрлэг сонгогдсон. Уг хөтөлбөрийн хүрээнд 33 дугаар цэцэрлэгийн багш 7 удаагийн модуль хичээл, сургалтад нийт 136 багш давхардсан тоогоор хамрагдсан. Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулж буй бүх шатны боловсролын багш ажилчдад зориулсан “English reading teachers-2023” сургалтад дүүргийн 500 багш, ажилчид хамрагдсан. Боловсролын байгууллагад 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын үндсэн сургалтад СӨББ 265 багш, эрхлэгч, 28 арга зүйч, ЕБС-ийн 241 багш хамрагдсан. Бага боловсролын 55 залуу багшид Ерөнхий боловсролын 49, 149 дүгээр сургуулийн бага боловсролын 20 сургалтын менежер сургалтад хамрагдсан. Сургуулийн менежментийг	90

						сайжруулах төслийг МУ-ын гавьяат багш С.Март, Ж.Чимэдрэгзэн нартай хамтран Ерөнхий боловсролын 23, 24, 37, 39, 57, 112, 139, 145 дугаар сургуулиуд ажлын төлөвлөлт гарган хэрэгжүүлж, нийт 18 удирдлагууд хамрагдсан. Сургууль цэцэрлэгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд Ерөнхий боловсролын 37 дугаар сургууль, 103 дугаар цэцэрлэгийн 50 багш харилцан туршлага солилцох хамтран ажиллах гэрээ байгуулан "Спорт өрөлт", "Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь" туршлагыг түгээн дэлгэрүүлж байна. Нийслэлийн бага боловсролын эрэгтэй багш нарын "Бага боловсрол дахь эрчүүдийн манлайлал - 2023" өдөрлөгт 39, 23 дугаар сургуулийн сургалтын менежерүүд, 117, 145 дугаар сургуулийн 10 багш нар оролцож, туршлагаа түгээн дэлгэрүүлсэн. - А plus 6 модуль сургалтад СӨББ-ийн 38 удирдлага хамрагдсан. "Монгол боловсрол ба хүний хөгжил" үндэсний чуулганд 60 нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эцэг эх асран хамгаалагч хамрагдсан. "Хорт зуршил ба сэтгэц нөлөөт эм, бодисын донтолтоос сэргийлэх нь" сургалтад 2000 багш, ажилтан, эцэг эх, сурагчдын төлөөлөл хамрагдсан. ЕБС-ийн орчинд Хүүхдийн эрх хамгаалагч" бэлтгэх 1, 2 дугаар шатны сургалтад төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн 24 нийгмийн ажилтан хамрагдсан.	
--	--	--	--	--	--	--	--

					"Сурагчдын сурч хөгжих үйл явцыг эрхэд суурилсан хандлагаар дэмжих нь Сургагч багш" бэлтгэх сургалтад 24, 57,17 сургуулийн 45 захирал, нийгмийн ажилтан, багш нар хамрагдсан. Сургалтын байгууллагын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах мэргэшсэн "Шинжээч сургагч багш" бэлтгэх сургалтад 11 багш хамрагдсан. ЕБС-ийн сэтгэл зүйчдийг "Боловсролын сэтгэл зүйч"-ээр мэргэшүүлэх сургалтад 3 сэтгэл зүйчийг хамруулсан. Алсын хараа 2050 сургалтад ЕБС-ийн 650 багш, СӨБ-ын 75 багш хамрагдлаа. НБГ-аас "Цагийн удирдлага", "Харилцааг зохицуулах нь", "Оновчтой шийдвэрлэх нь", "Мэдээллийг цахимжуулах нь" цахим сургалтуудад төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн 82 удирдлага хамрагдсан. А plus модуль сургалтаас- СӨББ-ийн 38 удирдлага "Монгол бичгийн зөв бичих дүрэм түүнийг заах арга зүй", "Боловсролын хувирган өөрчлөлт, удирдах ажилтны хөгжлийн шинэ хэрэгцээ" СӨББ-ийн багш "Сэтгэл хөдлөлийн мэдрэмжээ удирдах нь", "Багш ажлын байрандаа бие даан хөгжих арга зүй", "Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, түүний аргууд", "Багшийн болон хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх үнэлэх аргууд" зэрэг 1 кредит сургалтуудад хамрагдсан. Боловсролын байгууллагад 2, 3, 4 дэх жилдээ ажиллаж байгаа багш нарын сургалтад СӨББ-82 багш, ЕБС-ийн 241 багш хамрагдсан.	
--	--	--	--	--	---	--

1.3.5	Интерактив цахим хичээл явуулах боломж бүрдүүлсэн анги, танхимын тоог нэмэгдүүлэх	-	Анги, танхимын тоог нэмэгдүүлэх	10	12	Дүүргийн Ерөнхий боловсролын 18 сургууль, 7 цэцэрлэгт Интерактив цахим хичээл явуулах танхим байгуулан шаардлагатай таблет, смарт ТВ, нөүтбүүк, принтерийг сургалтдаа ашиглаж байна. Цахим платформуудыг ашиглан боловсролын чанарыг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, Ерөнхий боловсролын 117 дугаар сургуульд цахим сургалтын Жишиг анги байгуулсан. Монголын анхны цахим сургууль болох Medle.mn цахим платформ дүүргийн 5, 17, 23, 24, 50, 149 сургуулиуд 9 судлагдахууны хүрээнд 27 цахим хичээл байршуулан давхардуулсан тоогоор 658 хандалт авсан. E-Content цахим даалгаврын сан бүрдүүлэх цахим платформд 149 дүгээр сургуулийн ТНУ багш М.Пүрэвсүх, МХУЗ-ын багш н.Доржпагма нар хамтран цахим хичээл, даалгаврын санг бүрдүүлж байна.	100
1.3.6	“Чадварлаг багш-арга 2024” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	-	Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80%	85%	"Багшаас-багш суралцахуй" хөтөлбөрийг хэрэгжүүлж МУ-ын Зөвлөх багш Б.Эмдоромтой хамтран бага боловсролын 55 залуу багшид "Багшийн ёс зүй, харилцаа хандлага" "Анги удирдах урлаг" "Хүүхэд хамгааллын бодлого" хэрэгжүүлэх арга зүйн сургалтуудыг зохион байгуулсан. Боловсролын хэлтсийн пэйжийн "Тэргүүлэх багшийн тэргүүн туршлага", "Зөвлөх багш зөвлөж байна", "Тоглонгоо суралцъя" булангуудаараа 80 багшийн шилдэг арга зүй сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлж ажилласан. Бага боловсролын багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих багтай	90

						хамтран Бага ангийн 4 зөвлөх багш 55 байгаа залуу багшид “Гэрээс сургууль хүрэх зам” сэдвээр интеграци хичээл зааж хэлэлцүүлэг зохион байгуулсан. Боловсролын чанарын шинэчлэл төсөл "Унших (EGRA), тоо бодох (EGMA) чадварыг хөгжүүлэх арга зүйн харилцан туршлага судлах бүсийн зөвлөгөөн"-д бага боловсролын 15 сургалтын менежер, 30 багш оролцож, Нийслэлийн зөвлөгөөнд 72, 117, 149 дүгээр сургуулийн багш нар туршлагаа хэлэлцүүлснээс “Нийслэлийн шилдэг 5 туршлага”-д 149 дүгээр сургууль шалгарсан. “Эх хэлээрээ зөв сайхан бичицгээе” уралдаанд нийслэлийн 2491 бүлгээс 3 дугаар шатанд 5, 24, 50 дугаар сургуулийн 5 багш шалгарч, Өргөмжлөл, Батламж авсан. “Бүтээлч багачууд шилдэг арга зүй” улсын уралдаанд 72 дугаар сургуулийн бага боловсролын багш В.Даваабал улсын шилдэг арга зүйтэй 10 багшийн нэгээр шалгарч Тусгай байр эзэллээ. БШУЯ-ны Сайдын А/70 тушаалаар МУ-ын “Зөвлөх” багш 3-аар нэмэгдсэн. "Боловсрол дахь ёс зүйн асуудал шийдэл" шилдэг илтгэл шалгаруулах улсын уралдаанд 23 дугаар сургуулийн багш нар амжилттай оролцсон. Хичээлийн судалгааны 10 жилийн ой “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй-суралцагч төвтэй хичээл, үйл ажиллагаа” VIII бага хуралд 50 дугаар сургуулийн бага боловсролын сургалтын менежер Б.Ганцэцэг илтгэлээ хэлэлцүүлсэн.	
--	--	--	--	--	--	--	--

						Бага боловсролын залуу багш нарын дүүргийн ур чадварын уралдаан 2 үе шаттай зохион байгуулагдаж нийслэлийн уралдаанд 24, 149 дүгээр сургуулийн багш нар амжилттай оролцсон. СӨББ-ын багш удирдлагуудын "Шийтгэл бол шийдэл биш" эрдэм шинжилгээний хуралд 5 бүсээс шалгарсан 10 илтгэл 2 дугаар шатанд оролцож 37, 43, 174, 222, 298 дугаар цэцэрлэг шалгарлаа. СӨБ-ын туслах багш нарын үзүүлэх ажлыг 275, 31 дүгээр цэцэрлэгүүд зохион байгуулж 150 гаруй зочин багш нар хамрагдсан. Дүүргийн 9 цэцэрлэгийн эрхлэгч нар Япон улсын Токио хотын Боловсролын салбар, цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцсон. Дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын дунд "Шилдэг менежменттэй" байгууллагыг шалгаруулах удирдамжийн дагуу хэрэгжилтийг хангаж ажилласан.	
1.3.7	Боловсролын байгууллагын удирдлага, багш, ажилчдын дунд илтгэл, ур чадвар, урлаг, спортын тэмцээн зохион байгуулах	100.0 сая Дүүрэг, орон нутгийн төсөв	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	3	4	Нийслэлийн СӨББ-ийн спорт тэмцээнд хөгжим биеийн тамирын багш нар гар бөмбөгийн төрөлд хос "Хүрэл", сагсан бөмбөгийн төрөлд 350 багш оролцож эмэгтэй баг "Алтан" медаль, Удирдах ажилтнуудын "Бид хамтдаа" спортын 3 төрөлт тэмцээнд 23, 17, 50 дугаар сургуулийн баг тамирчид шалгарч, Засаг даргын нэрэмжит "Спорт наадам 2023" спортын 5 төрөлт тэмцээнд 18 сургуулийн 924 баг тамирчид оролцож нийлбэр дүнгээр 5, 50, 24 дүгээр сургуулиуд шалгарсан.	100

						Нийслэлийн 9 дүүргийн бага ангийн багш нарын “Тамирчин багш-23” спортын 5 төрөлт тэмцээнд Сургалтын менежерүүд “Шилдэг хөгжөөн дэмжигч баг”, Ширээний теннис “Алтан” медаль, Гар бөмбөг “Хүрэл” медаль, Дартс “Алтан” медаль хүртэж багийн нийлбэр дүнгээр “Дэд” байр эзэллээ. Нийслэлийн сургалтын менежерүүдийн “Эв нэгдэл идэвхтэй хөдөлгөөн” 5 төрөлт спорт наадмын 3х3 сагсан бөмбөг эрэгтэйчүүд “Алтан” медаль, эрэгтэй гар бөмбөг “Хүрэл” медаль, эрэгтэй шатар, “Хүрэл” медаль, гар бөмбөгийн “Тэгш тоглогч”-оор, дүүргийн ҮЭ-ийн зөвлөлийн “Бид хамтдаа” спортын 3 төрөлт тэмцээнд 13 сургуулийн 364 тамирчин өрсөлдөж багийн нийлбэр дүнгээр 5, 24, 39 дугаар сургуулийн багууд, МҮЭ-ийн холбооны нэрэмжит сагсан бөмбөгийн “Эв нэгдэл” тэмцээний “Шилдэг тоглогч”, “Алтан” медалийг 23 дугаар сургууль авсан. Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн 82 удирдлагад 5 удаагийн сургалт зохион байгуулсан. Нийслэлийн СӨББ-ийн спорт тэмцээнд дүүргийн хөгжмийн багш, биеийн тамирын багш нар оролцож гар бөмбөгийн тэмцээнд хос хүрэл медаль, сагсан бөмбөгийн тэмцээнд эмэгтэй баг алтан медаль авч амжилттай оролцлоо.	
1.3.8	Дүүргийн шилдэг багш, ажилтан, сургууль цэцэрлэгийг шалгаруулж урамшуулал олгох	-	Урамшуулал авсан байгууллага, хүний тоо	8	10	Дүүргийн Засаг даргын “Хүндэт тэмдэг”-ээр СӨББ-ын 65, ЕБС-ийн 83, “Хөдөлмөрийн алдар” медалиар СӨББ-ын 67, ЕБС-ийн 96 багш, ажилтан албан хаагчдыг шагнаж, урамшуулсан. Нийслэлийн Үйлдвэрчний эвлэлийн	100

						шилдэг цэцэрлэгээр 246 дугаар цэцэрлэг шалгарсан. Дүүргийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар тогтоолоор Ерөнхий боловсролын сургуулийн 400 багшийг зөөврийн компьютерээр хангаж дэмжлэг үзүүлсэн.	
1.3.9	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Ерөнхий боловсролын сургуульд олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх	-	Хамрагдсан байгууллагын тоо	18	33	Ерөнхий боловсролын 18 сургуулийн бага боловсролын сурагчдад олон улсын Steam хөтөлбөр хэрэгжсэн. БШУЯ, Финляндын Eduten математикийн платформыг турших багаар УБ хот, аймгийн төв, сумын төвийн нийт 9 сургуулийн 15 бүлгийн 520 сурагч, багш, удирдлага хамрагдсанаас Ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн 4 дүгээр ангийн 2 бүлгийн 67 сурагч 17 нэгж хичээлийг судлан төслийг хэрэгжүүлж тайлан хамгаалсан. Дүүргийн Ерөнхий боловсролын 117 дугаар сургууль улсын хөрөнгө оруулалтаар иж бүрэн дижитал ангийг нээж, Олон улсын Pearson English англи хэлний сургалтын цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар сурагчдын инженер техник, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор 39 ширхэг Микролион роботыг 16 сургуульд хуваарилан өгч, 3 сургуулийн мэдээлэл зүйн 6 багшийг сургагч багшаар бэлдэж байна. Ерөнхий боловсролын 50 дугаар сургууль Монгол дахь Гёте институтын хөрөнгө оруулалтаар 3795 еврогийн үнэ бүхий герман хэлний ном сурах бичигтэй Герман хэлний номын сан, уншлагын буланг байгуулж, сурагчид өргөнөөр хамрагдаж байна. Оросын холбоот	90

						улсын Саха якут дахь олон улсын хэл Хуурын төв, дэлхийн ард түмний хэл хуурын багш нар цахимаар болон танхимаар уулзалт зохион байгуулан дүүргийн орон нутгийн хөрөнгөөр “Монгол хэл хуурын музей”-г 61 дүгээр сургууль дээр нээсэн. Хэл хуурын дугуйланд 1, 2 дугаар шатны 30 хүүхэд хамрагдаж байна. - Дүүргийн Засаг даргын тамгын газрын захиалгаар дүүргийн 18 цэцэрлэгт “Олон улсын ШИМТ-STEAM хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж үр дүнтэй ажиллаж байна. - Финланд улсын “Eduten” математикийн сургалтыг дэмжих платформ 61 дүгээр сургуулийн 4 дүгээр ангийн багш, удирдлага амжилттай хэрэгжүүллээ. - Төрийн өмчийн 38 цэцэрлэг Олон улсын “STEAM”, “IM BRICK”, “Монтесорри” хөтөлбөр хэрэгжүүлсэн. - 293 дугаар цэцэрлэг нэмэлтээр 2 бүлэг тоглоом, хэрэглэгдэхүүн бүрдүүлж бүрэн Монтесорри сургалттай цэцэрлэг болж байна. - “Байгалийн ухааны цахим сургалт” туршилтын төслийг 5, 37, 39, 61, 72, 117, 139, 149 дүгээр сургуулиуд амжилттай хэрэгжүүлсэн. Дэлхийн банкны “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд “Тоглонгоо суралцъя” төслийг 37, 61, 117, 138 дугаар сургуулиуд амжилттай хэрэгжүүлсэн. - Зохистой хооллолт ба эрүүл мэнд аяны хүрээнд төрийн өмчийн 17 сургуулийн 2-12 дугаар ангийн сурагчдын дунд үргэлжлэн явагдаж байна.	
--	--	--	--	--	--	---	--

						- Үдийн хоол хөтөлбөрт 25 сургуулийн 14, 129 сурагч, СӨББ-ийн төрийн өмчийн 39 цэцэрлэг, төрийн бус өмчийн 15 цэцэрлэгт нийт 10,084 хүүхэд үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна. - Бие даан хоол үйлдвэрлэлээ явуулдаг 5 сургууль, гал тогоогоо түрээслэн үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлдэг 12 сургууль байна. - Сургуулиуд үдийн хоол үйлдвэрлэлээ өөрсдөө хариуцан ажилладаг 139,138,140,145,149 дүгээр сургуулиуд суралцагчдыг шим тэжээллэг хоол хүнсээр хангаж буй сайн туршлага, хүний нөөцөө хэрхэн шийдэх, тогооч болон туслах ажилчдыг тогтвор сууршилтай ажиллуулах талаар мэдээ мэдээллээ солилцож түрээсийн гал тогоо ажиллуулдаг 12 сургуулийн захирлуудад хуваалцлаа. -Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээнд хяналт тавих журмыг танилцуулах сургалтыг Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн Б.Өлзийбаяр, Боловсролын хэлтсийн мэргэжилтэн Г.Отгонтуяа нар зохион байгуулж сургалтад дүүргийн төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн 19 захирал, эрхлэгч оролцсон. - Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд цахим бүртгэл, төлөвлөлт хийх боломж бүхий хоолны газрын бүх хэрэгцээг хангах вебд суурилсан, мэдээллийн Арта системд программд дүүргийн 139 дүгээр сургууль хамрагдахаар гэрээ байгуулан хамтын ажиллагаагаа эхлүүлсэн.	
--	--	--	--	--	--	--	--

1.3.10	Багш, сурагчдын дунд гадаад хэлний олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах	-	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	0	1	Англи хэлний судлагдахууны олимпиадын II даваа 9, 12 дугаар анги, гүнзгий болон ердийн анги, багшийн чиглэлээр 5 төрлөөр зохион байгуулагдаж, 15 сургуулийн 9, 12 дугаар анги энгийн ангийн төрөлд 162 сурагч, 9, 12 дугаар ангийн гүнзгий ангийн төрөлд 32 сурагч 12 багш, дүүргийн гадаад хэлний мэргэжлийн хөгжлийг дэмжих багаас Англи хэлний илтгэлийн "Best presenter" уралдааныг ахлах ангийн сурагчдын дунд 3 дахь жилдээ зохион байгуулж хувийн үзүүлэлтээр Ерөнхий боловсролын 17, 24, 50 дугаар сургуулиуд, багийн үзүүлэлтээр 5, 17, 24 дүгээр сургуулиуд тус тус шалгарсан. "Великом Чайны Пути" буюу Монгол Орос Хятад улсын "Агуу их цайны зам" олон улсын хүүхдийн 10 дугаар их наадамд 57 дугаар сургууль "Хамтлаг дуу" төрөлд "Алт", "Мөнгө", "Хүрэл" медаль, "Гоцлол дуу" төрөлд "Алт", "Мөнгө", "Хүрэл" медаль, ардын дуу төрөлд "Уухай" хамтлаг "Хүрэл" медаль, 49 дүгээр сургууль хамтлаг бүжиг төрөлд "Тэргүүн" байр, "Жүжигчилсэн тоглолт" төрөлд "Дэд" байр 23 дугаар сургууль илтгэлийн төрөлд "Хүрэл" медаль хүртсэн. PEARSON англи хэлний цогц хөтөлбөр 5-12 дугаар ангид Pearson English Connect дэвшилтэт дижитал интерактив сургалтын платформ ашиглаж, хамгийн сүүлийн үеийн сурах бичиг, видео болон аудио контентоор дамжуулан англи хэлний мэдлэгээ сайжруулах хөтөлбөрт	90
--------	--	---	---------------------------------------	---	---	--	----

						Ерөнхий боловсролын 117 дугаар сургууль хамрагдсан. Нийслэлийн Ерөнхий боловсролын Лаборатори 23 дугаар сургуулийн Орос хэлний багш М.Назым Оросын аугаа их зохиолч Александр Сергеевич Пушкиний нэрэмжит олон улсын эсээ бичлэгийн уралдаанд “Тэргүүн” байранд шалгарч, ОХУ-ын нийслэл Москва хотод ОХУ-ын зардлаар 7 хоног аялах эрхийн бичгээр шагнуулсан.Дүүргийн ЕБС-иудын гадаад хэлний олимпиад хуваарийн дагуу явагдаж Нийслэлийн олимпиадад амжилттай оролцсон байна. НБГ-аас “Цагийн удирдлага”, “Харилцааг зохицуулах нь”, “Оновчтой шийдвэрлэх нь”, “Мэдээллийг цахимжуулах нь” цахим сургалтуудад төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн 82 удирдлага хамрагдсан.	
--	--	--	--	--	--	---	--

1.4 ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ, ДААТГАЛ

1.4 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэн хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлнэ.

1.4.1	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хэрэгжилтийг хангах, зохион байгуулах	-	Нэвтрүүлсэн үйлчилгээний тоо	72-үйлчилгээ-нээс 64 нэвтэрсэн	2023 онд ehalamj.mn системд 72 төрлийн үйлчилгээнээс 64 үйлчилгээг бүрэн нэвтрүүлнэ	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангах үйлчилгээний хүрээнд 500 иргэнд хөдөлмөр эрхлэлт, мэргэжил сонголтын талаар зөвлөгөө сургалтыг зохион байгуулсан. Сул чөлөөтэй байгаа ажлын байрны захиалга 200, ажил идэвхтэй хайж буй 315 иргэнийг бүртгэж, ажил олгогчийн шаардлага, иргэдийн хүсэл сонирхлыг харгалзан 125 иргэнийг тохирч тэнцэх ажлын байранд зуучлан, 130 шинэ ажлын байрыг бүртгэсэн. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд “LMIS” программын шинэчлэлд	90
-------	--	---	------------------------------	--------------------------------	--	--	----

						хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг сайжруулах талаарх саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн ба тус программ E-Job программд нэвтрэх, ажил хайгч иргэд, ажил олгогч байгууллага, ажлын байрны зар, зөвлөгөө мэдээлэл өгсөн иргэд, ажилд зуучлагдсан, төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн мэдээллийг программд оруулах сургалтыг амжилттай зохион байгуулсан. Тус платформуос ажил олгогч ажил хайгчдад зориулсан онлайн портал, гар утасны аппликейшн ашиглах, ажил олгогч байгууллагуудын нээлттэй ажлын зар мэдээллийг 3500 иргэнд хүргэсэн.	
1.4.2	Хүн амын бүлгийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	25,8 сая төгрөг	Хамрагдсан иргэний тоо	344	360	Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоол, ХНХЯ-ны сайдын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/16 дугаар тушаалын дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл зарлан нийт 202 иргэний төслийг хүлээн авч, ажлын хэсгийн гишүүд ажлын байрыг үзэх ажлыг зохион байгуулсан. Нийтийг хамарсан ажлын хүрээнд 1, 2 дугаар хорооны 279 иргэн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд бүтээн байгуулалт хийх, сайжруулах, тохижилт хийх, хог хаягдалгүй байлгах, байгаль орчныг хамгаалах, ой цэвэрлэх, голын ой сав, үер усны даланг цэвэрлэх ажлыг 2 удаа зохион байгуулж, зөвлөмж хүргэж ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй	90

						хүний эрхийг хамгаалахад чиглэсэн төрөөс хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, хэрэгжилт, халамжийн болон бусад үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал хүсэлтийг сонсох зорилгоор дүүргийн “ХАМТДАА ОРОЛЦЪЁ -ХАМТДАА ХӨГЖЬЕ-2” уулзалт хэлэлцүүлэгт 1-24 дүгээр хороодын 150 иргэнийг хамруулж, зорилтот бүлгийн 1500 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулсан. Сул чөлөөтэй ажлын байрны захиалга 660, ажил идэвхтэй хайж байгаа 800 иргэнийг бүртгэж, ажил олгогчийн шаардлага, иргэдийн хүсэл сонирхлыг харгалзан 470 иргэнийг тохирч тэнцэх ажлын байранд зуучилсан. “Шинэ иргэншил” МСҮТ-ийн 39 оюутан 4 өдөр мод тарих арга хэмжээнд оролцож цагийн ажилд зуучлагдсан. Хугацаат цэргийн албаа хаасан, халагдаж ирсэн 100 гаруй хугацаат цэргийн албан хаагч, залуучуудад 40 гаруй байгууллагын 250 гаруй нээлттэй ажлын байрыг санал болгож, ажил олгогчийн төлөөлөл “Долоон болдог” ХХК, Петровис ХХК үйл ажиллагаанд оролцож, 3 иргэнийг цагийн ажилд зуучилсан. Улсын хэмжээнд шинэ технологи, инновац шингээсэн гарааны бизнес эрхэлж буй залуучуудад санхүүжилт олгох “СТАРТАП-2023” Улсын аварга шалгаруулах уралдаанд 30 иргэн бүртгүүлж, 17 багаас Ган Айро Майнд,	
--	--	--	--	--	--	---	--

						Үүсэл багууд шалгарч, тус бүр 10 сая төгрөгийн санхүүжилт авсан.	
1.4.3	“Бүтээлч Чингэлтэйчүүд-2024” хөтөлбөр арга хэмжээг хамтран зохион байгуулах	-	Арга хэмжээ, хамрагдсан иргэний тоо	4 зорилт 12 хэмжээ 898 хүн хамрагдсан	4 зорилт 12 арга хэмжээнд - 900 хүн	Дүүргийн 1500 иргэнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөр эрхлэлтийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч, сул чөлөөтэй ажлын байрны захиалга 660, ажил идэвхтэй хайж байгаа 800 иргэнийг бүртгэж, ажил олгогчийн шаардлага, иргэдийн хүсэл сонирхлыг харгалзан 470 иргэнийг тохирч тэнцэх ажлын байранд зуучилсан. Дүүргийн 17, 57, 39 дүгээр сургуулийн 9 дүгээр ангийн зорилтот 45 сурагчид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдлэг, арга зүйгээр хангах, мэргэжил сонголтоо зөв хийхэд нь туслах зорилгоор “М-Си-Эс Кока-Кола” ХХК-ийн үйлдвэртэй танилцах аялал зохион байгуулж, Шинэ иргэншил МСҮТ-ийн “Мэргэжил сурталчлах өдөрлөг”-т оролцож зөвлөгөө мэдээлэл өгсөн. 2023 оныг “Үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан жижиг зээлийн мэдээллийг 1-24 дүгээр хорооны 1000 гаруй иргэнд хүргэсэн. Улсын хэмжээнд шинэ технологи, инновац шингээсэн гарааны бизнес эрхэлж буй залуучуудад санхүүжилт олгох “СТАРТАП-2023” Улсын аварга шалгаруулах уралдаанд 30 иргэн бүртгүүлж, 17 багаас Ган Айро Майнд, Үүсэл багууд шалгарч, тус бүр 10 сая төгрөгийн санхүүжилт авсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлд хамрагдах хүсэлтэй 80	90

						иргэнд зөвлөгөө өгч, 41 иргэн зээлийн өмнөх сургалтад хамрагдсан. Бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх "Бэст" хөтөлбөрөөс зохион байгуулсан "Энтрепренер эмэгтэйчүүд" арга хэмжээнд төсөл хөтөлбөрт хамрагдаж, амжилттай үйлдвэрлэл эрхэлж байгаа 3 иргэнийг оролцуулж туршлага солилцох, борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 сарын 03-ны өдрийн 01-р тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 02 сарын 06-ны өдрийн А/16 тушаалын дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд 202 иргэний төслийг хүлээн авч, ажлын байрыг үзэх ажлыг зохион байгуулсан. Арилжааны банкаар дамжуулан бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй 80 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч 10 иргэн, аж ахуй нэгжид 424 сая төгрөгийн зээл гарсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан 70 гаруй иргэний бараа бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүйгээр борлуулах, тэдгээрийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр "Чингэлтэйд үйлдвэрлэв-3" борлуулалтын төвийн 2 салбарт нийт 9 сая төгрөгийн, үүнээс ХБИргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс 1.8 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. Технож БИТ, Өвөр Монголын "Монголд үйлдвэрлэв" төвтэй хамтын	
--	--	--	--	--	--	--	--

						ажиллагааны хүрээнд төсөл хөтөлбөрт хамрагдсан 2 иргэний 30 бүтээгдэхүүнийг борлуулсан. "ХӨДӨЛМӨР, "ХҮНИЙ ХӨГЖИЛ-НИЙГМИЙН ХӨГЖИЛ" Нийслэлийн нийгмийн салбарын нэгдсэн өдөрлөгт оролцож нийт 100 орчим иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн бүлгийн төсөлд хамрагдсан 5 иргэн бараа бүтээгдэхүүнээ танилцуулж, 150,000 төгрөгийн борлуулалт хийсэн. Төсөл хөтөлбөрт хамрагдаж санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн бараа бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүй борлуулах "Дэм дэмэндээ" аяныг үе шаттай зохион байгуулж, "Чингэлтэйд үйлдвэрлэв-3" борлуулалтын төвд 70 иргэний бараа бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүй борлуулж байна. "Чингэлтэйд үйлдвэрлэв-3" борлуулалтын төвүүдэд 26 хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлдвэрлэсэн 3 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг борлуулсан.	
1.4.4	"Үйлдвэрлэлийг дэмжих жил" арга хэмжээг хамтран зохион байгуулах	-	Арга хэмжээ, хамрагдсан иргэний тоо	-	5 арга хэмжээнд 70 хүн	Зорилтот жилийн хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн арилжааны банкаар олгох жижиг зээлд хамрагдах хүсэлтэй 80 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч, "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран зохион байгуулсан зээлийн өмнөх сургалтад 41 иргэн хамрагдсан. Сургалтад хамрагдсан 41 иргэн ажлын хэсэгт төслөө танилцуулж, төслийг	90

						дэмжсэн тухай албан бичиг, ажлын хэсгийн үнэлгээг гарган банканд хүргүүлсэн. 2. “Цахим ур чадвар олгох, харилцааны ур чадвар эзэмшүүлэх” сургалтад ажилгүй 50 иргэнийг хамруулахаар Хөгжлийн шийдэл, Жи Си Эй Эс сургалтын байгууллагатай гэрээ байгуулсан. 3. Бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх "Бэст" хөтөлбөрөөс зохион байгуулсан "Энтрепренер эмэгтэйчүүд" арга хэмжээнд төсөл хөтөлбөрт хамрагдаж, амжилттай үйлдвэрлэл эрхэлж байгаа 3 иргэнийг оролцуулж туршлага солилцох, борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлж үзэсгэлэнд оролцсон. Арилжааны банкаар дамжуулан бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй 80 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, жижиг зээлийн сургалтад 56 иргэн хамрагдаж, 24 сарын хугацаатай, жилийн 11 хувийн хүүтэйгээр 19 иргэн, аж ахуй нэгжид 700 сая төгрөгийн зээл гарсан. 2023 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 202 иргэний төслийг хүлээн авч 87 иргэний төсөл дэмжигдсэн. Үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлийн өмнөх дараах сургалтыг зохион байгуулж, 3 удаагийн өдөрлөг, яармагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээрээ үзэсгэлэн гарган 2.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн арилжааны банкаар олгох жижиг зээлд хамрагдах	
--	--	--	--	--	--	---	--

						хүсэлтэй 80 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч, 41 иргэн зээлийн өмнөх сургалтад хамрагдсан. “Цахим ур чадвар олгох, харилцааны ур чадвар эзэмшүүлэх” сургалтын хүрээнд Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд аж ахуй эрхлэх, бизнес удирдлагын анхан шатны ойлголтууд, хувь хүний хөгжил, харилцааны ур чадвар болон цахим ур чадварыг эзэмшүүлэх, Астра залуус ХХК-тай хамтран нярав, нягтлангийн богино хугацааны ур чадвар олгох, Жи Си Эй Эс сургалтын байгууллагатай хамтран онлайн бизнес эрхлэх ур чадвар олгох сургалтад нийт 50 эмэгтэй хамрагдсан.	
1.5 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах							
1.5.1	Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах	-	Нэвтрүүлсэн үйлчилгээний тоо	72-үйлчилгээн ээс 64 нэвтэрсэн	2023 онд ehalamj.mn системд 72 төрлийн үйлчилгээн ээс 64 үйлчилгээг бүрэн нэвтрүүлнэ	Дүүргийн “Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл”-ийн 2023 оны анхдугаар хуралдааныг 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, салбар зөвлөлийн 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. Нийгмийн халамжийн 72 үйлчилгээний 64 үйлчилгээг www.ehalamj.mn системд нэвтрүүлсэн ба системийн талаарх мэдээг хэлтсийн вэб сайт, пэйж хуудсаар мэдээлж ажиллалаа. Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системд И-Жоб программд нэвтрэх, ажил хайгч иргэд, ажил олгогч байгууллага, ажлын байрны зар, зөвлөгөө мэдээлэл өгсөн иргэд, ажилд зуучлагдсан, төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн мэдээллийг программд оруулах сургалтыг амжилттай зохион байгуулсан. И-Жоб платформуос ажил олгогч, ажил	100

						хайгчдад зориулсан онлайн портал, гар утасны аппликейшн ашиглах, ажил олгогч байгууллагуудын нээлттэй ажлын зар мэдээллийг 3000 иргэнд хүргэсэн байна.	
1.6 Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүн амд үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай хүргэн, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.							
1.6.1	Нийгмийн даатгалын архивын үйлчилгээг иж бүрэн цахимжуулах, хиймэл оюун ухаанд суурилсан автоматжуулалтын системийн нэвтрүүлэх	Дүүргийн төсөв 70,6 сая төг	Цахимаар лавлагаа олгосон иргэдийн тоогоор	-	НД-ын архивын лавлагааг 1000 иргэнд олгоно	Дүүргийн иргэд даатгуулагчдын тэтгэврийн хувийн хэргийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын найдвартай, аюулгүй байдлыг хангах зорилгоор архивыг бүрэн цахимжуулах зорилт тавин, архивыг бүрэн цахимжуулах ажлын санхүүжилтийг тусгасан боловч санхүүжилтгүйн улмаас хиймэл оюун ухаанд суурилсан автоматжуулалтын системийн нэвтрүүлэх ажил хийгдээгүй байна.	30
1.6.2	Тоон гарын үсэг ашиглан тайлан илгээдэг аж ахуй нэгжийг тоог нэмэгдүүлэх	-	Тоон гарын үсэг ашиглан тайлан илгээж байгаа байгууллагын тоогоор	1698 ажил олгогч тоон гарын үсэг ашиглаж байна.	Нийт ажил олгогчдын 50-иас дээш хувийг хамруулна.	“Нью компас” ХХК-тай хамтран ажил олгогчдод тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулсан ба 2023 оны байдлаар нийт 1750 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тоон гарын үсгээр хүлээн авч ажиллаж байна. Шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудаас сонгон, танхимаар нийт 4000 байгууллагын захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудыг хамруулсан. “Тоон гарын үсгийн хэрэглээ заавар зөвлөмж” сэдвээр 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан Ажил олгогчдын зөвлөгөөнд “Нью компас” ХХК-ийг оролцуулж, мэдээлэл олгосон	90
1.6.3	Иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах талаар	-	Шинээр бүртгүүлсэн аж ахуйн	547/3501	600/3800	Иргэд даатгуулагч, ажил олгогч нарт нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг цахимаар түргэн	90

	сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, заавал даатгуулагч болон ажил олгогчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх		нэгж, байгууллагын тоо, даатгуулагчд ын тоо			шуурхай хүргэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор Нийгмийн даатгалын хэлтсийн албан ёсны Facebook цахим хаягаар дамжуулан шууд Live хийж, иргэдэд зөвлөгөө мэдээллийг цахимаар хүргэн ажиллаж байна. 2023 онд нийт 12 удаа шууд Live хийж, цахимаар зөвлөгөө мэдээлэл өгч, 16,400 гаруй иргэд даатгуулагчид үзсэн хандалттай байна. Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2023 оны 02 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд дүүргийн хороодтой хамтран “ЗӨВЛӨӨ, ТУСАЛЪЯ” явуулын үйлчилгээг зохион байгуулж, дүүргийн 6- 9 дүгээр хорооны иргэд даатгуулагчдад Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулж, 2023 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх нь үүсэж буй нийт 200 гаруй иргэд даатгуулагчдад тэтгэвэр тогтоолгох талаарх сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Нийслэлийн Ерөнхий боловсролын 138 дугаар сургууль, 220 дугаар цэцэрлэг, 21 дүгээр хорооны иргэдэд “Даатгалтай ирээдүй”, “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж”, “Эрүүл мэндийн даатгал” сургалт өдөрлөгийг 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, тус сургуулийн 10а, 10г ангийн нийт 60 сурагчид мөн албан хаагчид 38 нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулж, мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилгоор тус хэлтэс нь 2023 оны 03 дугаар сарын	
--	--	--	---	--	--	---	--

						15-ны өдөр дүүргийн хороодтой хамтран “ЗӨВЛӨӨ, ТУСАЛЪЯ” явуулын үйлчилгээг зохион байгуулж, дүүргийн 1-3 дугаар хорооны иргэд даатгуулагчдад Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулж, 2022, 2023 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх нь үүсэж буй нийт 200 гаруй иргэд даатгуулагчдад тэтгэвэр тогтоолгох талаарх сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Нийслэлийн Иргэний бүртгэлийн газар хороод хариуцсан мэргэжилтэн болон хэлтсийн бүртгэгч ажилтан, нягтлан бодогч, албан хаагчдыг хамруулан танхимын болон цахим сургалт зохион байгуулж, нийт 67 гаруй нягтлан бодогч, албан хаагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Засгийн газрын авто бааз, Очир ундраа групп, Цээб ХХК, ШШГЕГ-ын харьяа мэргэжил сургалт үйлдвэрлэлийн газар, Улаанбаатар смарт карт ХХК-ийн албан хаагчдыг хамруулан Нийгмийн даатгалын хууль тогтоомж шинэчилсэн найруулга, тэтгэвэр тэтгэмжийн тухай ойлголт сургалт зохион байгуулж, нийт 311 гаруй нягтлан бодогч, албан хаагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Ажил олгогч захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудын сургалт, зөвлөгөөнийг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр танхимаар зохион байгуулж, сургалтад	
--	--	--	--	--	--	--	--

						их хэмжээний шимтгэлийн өр үүсгэсэн болон шинээр байгуулагдсан аж ахуй нэгж байгууллагуудаас сонгон, нийт 4000 байгууллагын захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудыг хамруулсан.	
1.6.4	Иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах талаар сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх	-	Шинээр даатгалд хамрагдсан иргэдийн тоо, хувиар	4369 иргэн хамруулан ажилласан.	4500-аас доошгүй, 10 хувиар нэмэгдүүлнэ	Дүүргийн хэмжээнд нийт 25 ажил олгогчийн регистрийн дугаар, нэр, код, ажил мэргэжлийн ангилал зэрэг мэдээллийг улсын бүртгэлийн мэдээлэлд тулгалт хийж бүртгэл мэдээллийг засварлаж, 88 даатгуулагчийн регистрийн дугаар, овог нэр, даатгуулагчийн нэр, даатгуулагчийн ажил мэргэжлийн ангилал зэрэг мэдээллийг улсын бүртгэлийг зөв болгож мэдээллийн баазыг үнэн зөв бүрдүүлэхэд анхаарч ажиллалаа. 2023 онд шинээр 1329 сайн дурын даатгуулагч хамрагдаж, Нийгмийн даатгалын санд 5387.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 4200.6 сая төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 81.0 хувиар биелүүлсэн. 2023 онд “Сайн дураар даатгуулах тухай гэрээ” байгуулсан боловч хуулийн хугацаанд шимтгэлээ төлөөгүй хугацаа хожимдуулан төлсөн 630 даатгуулагчид нийт 12,5 сая төгрөгийн алданги ногдуулж, алдангийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн. НДЕГ-ын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27 өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/11 дүгээр тушаал, 2020 оны “Шийдвэр хүргүүлэх тухай” 3/175 дугаар тоот албан бичгийн дагуу 0-3 нас хүртэлх хүүхэдтэй эхчүүдийн шимтгэлийн 50 хувийг улсаас төлүүлж, 50 хувийг өөрөө төлөх заалтын дагуу	90

						нийт 170 эхчүүдийг шинээр сайн дурын даатгалд хамруулах гэрээ байгуулж ажилласан. Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран 0-3 хүртэлх насны 921 даатгуулагч эхийн судалгааг авч холбогдон сайн дурын даатгалын ач холбогдлыг танилцуулан зөвлөгөө мэдээлэл өгснөөр 472 даатгуулагч эх огт шимтгэл төлдөггүйг нэг бүрчлэн ярьж 30 даатгуулагч эхийг сайн дурын даатгалд хамруулсан.	
1.7 ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД							
1.7 Гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн “Гэр бүл-2024” арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.							
1.7.1	“Гэр бүл-2024” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж, дүүргийн ИТХ-д хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллах	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	70%	100%	Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Гэр бүл-2024” арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж, арга хэмжээний хүрээнд 2023 онд 49 сургалт, 42 арга хэмжээг зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 7500 гаруй хүнийг хамрууллаа.	90
1.7.2	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, зорилтод бүлгийн иргэдийг сэтгэл зүйн болон нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах	4.0 Улсын төсөв	Хамрагдсан иргэдийн тоо	280	400	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18, 19 дүгээр зүйл, 2017 оны А/173, А/251, А/380 дугаар тушаалын дагуу хүүхэд хамгааллын Хамтарсан багийг шинэчлэн байгуулахад дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 1/294 албан бичгээр санал хүргүүлсэн бөгөөд “Хамтарсан баг байгуулах тухай” 2023 оны 06 дугаар тогтоол батлагдсаныг дүүргийн 24 хороодод 2023 оны 04	90

						дүгээр сарын 21-ний өдрийн 3/1005 албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, зорилтот бүлгийн иргэдийг сэтгэл зүйн болон нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах чиглэлээр 219 хүнд үйлчилгээ үзүүлсэн. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хороодын хамтарсан багийн гишүүдийн хуулийн мэдлэгийг дээшлүүлэх, кейс менежментийг үр дүнтэй үзүүлэх чадавхыг сайжруулах, сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, арга зүйгээр ханган ажилласан.	
1.7.3	Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагааг зохион байгуулан салбар дундын уялдаа холбоог сайжруулж, дэмжин ажиллах	3.0 Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	4	6	Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хороодын хамтарсан багийн гишүүдийн хуулийн мэдлэгийг дээшлүүлэх, кейс менежментийг үр дүнтэй үзүүлэх чадавхыг сайжруулах, Шилдэг хамтарсан багийг шалгаруулж, сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор удирдамж батлуулан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, арга зүйгээр ханган ажиллаж Шилдэг хамтарсан багийг шалгаруулсан. Хамтарсан багийн гишүүдийн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний үр дүнг сайжруулахад нь мэргэжил арга зүйн	90

						дэмжлэг үзүүлэх зорилгоор 2 өдрийн кейс хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хүүхдийг ивээх сангийн НҮБ-ын Итгэлцлийн Сангийн санхүүжилттэй хэрэгжүүлж буй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран дүүргийн 5 хороодын хамтарсан багийн гишүүдийг хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр чадавхжуулах 11 багц модулийн 3 удаагийн 4 өдрийн сургалтад хамтарсан багийн нийт 25 гишүүдийг хамруулсан.	
1.7.4	Дүүргийн “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80%	100%	Дүүргийн Хүүхдийн төлөө зөвлөлийг 2 удаа хуралдуулж, 2023 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлж 3 зорилт, 24 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөгөөг батлуулан, холбогдох хэлтэст хүргүүлж, хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллалаа. Нийт төлөвлөсөн арга хэмжээний хүрээнд 2023 оны байдлаар 29 сургалт арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 8100 орчим хүнийг хамруулсан.	90
1.7.5	Дүүргийн “Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл”, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80%	100%	Дүүргийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг дүүргийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/60 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан. Салбар зөвлөлийг 2 удаа хуралдуулж, 2023 онд нийт 5 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар батлуулж, холбогдох хэлтэст хүргүүлж, хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажилласан.	90

						Дүүргийн залуучуудыг хөгжүүлэх, идэвхжүүлэх, дэмжих, хөгжил оролцоог хангах чиглэлээр “Шинэ сэргэлт-Чингэлтэй” залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг батлуулж Шилдэг шинэ эрин төрийн бус байгууллагатай хамтран 2023 оны 05 дугаар сараас 09 дүгээр сар хүртэлх хугацаанд хөтөлбөрийг үе шаттай зохион байгуулсан. Дүүргийн залуучуудын хувь хүний хөгжил, боловсрол, соёл урлаг, спорт, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх зорилгын дор “Чингэлтэйн залуус бид хамтдаа” чуулга уулзалтыг 2023 оны 09 дүгээр сард дүүргийн Хайрхан хөгжлийн төвд зохион байгуулж, 1300 орчим залуучуудыг хамруулсан.	
1.7.6	Дүүргийн “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-ны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	-	Хяналт тавьсан тоо	1	2	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог хуралдуулж, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Европын холбооны санхүүжилтээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд гэмт хэрэг, зөрчилд холбогдогч, хохирогч хүүхдэд үзүүлэх кейс менежментийг сайжруулах, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, эрчимжүүлэх Ментор хөтөлбөрт дүүргийн Хүүхдийн эрхийн	70

						хууль зүйн хороо хамрагдаж хамтран ажилласан.	
1.7.7	Хүүхдийг номтой нөхөрлүүлэхэд чиглэсэн соёл, олон нийтийн ажлыг хуваарийн дагуу тогтмол зохион байгуулах	1.0 Орон нутгийн төсөв	Үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тоо	350	500	Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 96 сурагчдад “Сайн жаал” сургалтыг амжилттай зохион байгууллаа. “Үлгэрийн ертөнцөөр аялцгаая” зорилтын хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 61, 149 дүгээр сургуулийн 70 сурагчдад монгол ардын үлгэр домог, туульсын тухай танилцуулсан. Дүүргийн Хүүхэд хөгжлийн цогцолборын 3 давхарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан булан байгуулж ажилласан. Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдлэх, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх зорилгоор уламжлал болгон дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хүүхэд хөгжлийн цогцолбортой хамтран “Номын баяр” арга хэмжээг Б.Явуухулангийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнд 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг урьж оролцуулан, танин мэдэхүйн тэмцээн уралдаанд оролцуулж, хүүхдийн үлгэрчилсэн тоглолт болон явуулын сангийн үйлчилгээг хүргэсэн. Дүүргийн Засаг даргын нэрэмжит “Уран уншлага”-ын уралдааныг дүүргийн төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулиудын дунд, ахлах ангийн хүүхдүүдийн дунд дүүргийн Хүүхэд хөгжлийн цогцолбортой хамтран зохион байгуулсан.	90

1.7.8	Уламжлалт “Сар шинийн баяр”, “Олон улсын ахмадын өдөр”-ийг тохиолдуулан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах	170.0 Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоогоор	1	2	Тайлант хугацаанд Сар шинийн баярыг тохиолдуулан 7231 харьяалалгүй ахмадад Нийгмийн халамжийн тухай хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд 72,310,000 төгрөгийн үнэ бүхий гарын бэлэг гардуулсан. Ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлж, дүүргийн ахмадуудад хүндэтгэл үзүүлэх Ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/269 дүгээр захирамжаар байгуулж, 15 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө, 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/253 дугаар тушаал, удирдамж, хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Дүүргийн 1-24 дүгээр хороодын 6000 орчим ахмад настнуудад хүндэтгэл үзүүлсэн бөгөөд дүүргийн Засаг даргын Тамгын газраас баталсан “Эрүүл агаарт-Эрхэм хүмүүс” нэгдсэн удирдамж, хөтөлбөрийн дагуу Засаг даргын Тамгын газрын нийт хэлтэс, албад, дүүргийн 1-24 дүгээр хороодын Ажлын алба, дүүргийн Ахмадын хороо, дүүргийн Соёлын төвтэй хамтран 2023 оны 09 дүгээр сарын 11-22-ны өдрүүдэд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ, дүүргийн Хайрхан хөгжлийн төвд өдөрлөг арга хэмжээг хуваарийн дагуу тус тус 1 өдөр зохион байгуулсан. Ахмадын баярыг угтан 2023 оныг “Үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Чингэлтэй дүүргийн ахмад настнуудын үндэсний уламжлалт ахуй болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, уламжлан хадгалах, олон нийтэд таниулж, ахмад настнуудын нийгмийн амьдралд	90
-------	---	-----------------------------	---	---	---	--	----

						оролцох оролцоог дэмжих зорилгоор “Туршлагаа солилцож хамтдаа хөгжье” ахмад настуудын бүтээлийн үзэсгэлэн худалдааг 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулсан. Энэ хүрээнд дүүргийн 1-24 дүгээр хороодын ахмад настууд өөрсдийн хийсэн бүтээлээ олон нийтэд танилцуулж, худалдан борлуулж хамтран ажилласан бөгөөд 3 ахмадыг мөнгөн шагналаар шагнасан.	
1.7.9	Чингэлтэй дүүргийн харьяатай 18 нас хүрч асрамж халамжийн төвөөс гарч буй залууст эргэн хяналт тавьж амьдарч буй нөхцөл байдалтай танилцах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлж түр болон байнгын ажлын байранд холбон зуучлах, МСҮТ болон холбогдох сургалтын төвүүдэд холбон зуучилж мэргэжил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх	2,0 Орон нутгийн төсөв	Хамрагдсан залуучуудын тоо	2	2	Дүүргийн харьяаллын 18 нас хүрч асрамж халамжийн төвөөс гарч буй залууст асрамж халамжийн дараах үйлчилгээг хүргэх чиглэлээр “Өнөр бүл төв”-тэй уулзалт зохион байгуулсан. Цаашид асрамжийн дараах үйлчилгээний чиглэлээр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Дүүргийн Асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхдийн үрчлэлтийн асуудалд хяналт тавих ажлын хэсгийг 10 удаа хуралдуулж, эрсдэлт нөхцөлд байгаа асрамж халамж шаардлагатай 100 хүүхдийн эрхийг хангаж, үрчлэлт, асрамж халамжийн 91 захирамж гаргуулсан.	90
1.8 ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ							
1.8 Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний үнэт зүйлээ дээдэлсэн агуулгыг баяжуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилготой “Соёлтой иргэн-2024” арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
1.8.1	“Соёлтой иргэн-2024” арга хэмжээг	-	Хэрэгжилтийн хувь	50%	60%	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 22	90

	хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах					дугаар тогтоолоор батлагдсан “Соёлтой иргэн-2024” арга хэмжээний хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх 4 зорилт 12 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгэм цахим бодлогын хорооны хурлаар хэлэлцүүлсэн. Дүүргийн Соёлын төвийн дэргэдэх ахмадын “Эгшиглэнт айзам аялгуу” чуулга, БНСУ-ын Улсан хотын “Досонг гагук урлагийн институт”-ийн хамтын ажиллагааны хүрээнд 2023 оны 1 дүгээр сарын 28-31-ний өдрүүдэд Ерөнхий боловсролын 50, 72 дугаар сургууль, Хан-Уул дүүргийн Соёлын ордонд тоглолт зохион байгуулж, 300 гаруй иргэдийг хамрууллаа.	
1.8.2	Соёл урлаг, спортын тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж, иргэдийн оролцоог ханган ажиллах	-	Хамрагдсан иргэдийн тоо	1000	1200	Дүүргийн 1-24 дүгээр хороодын ахмад настнуудыг нийгмийн олон талт үйл ажиллагаанд оролцуулах, авьяас, ур чадварыг сурталчлан таниулах, өвлүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын нэрэмжит “Ахмадын урлагийн наадам”-ыг ардын болон мэргэжлийн уран бүтээлчдийн ангилалд 12 төрлөөр 2023 оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгуулж 300 ахмад настныг хамруулсан. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн бие бялдрыг гимнастикийн дасгал хөдөлгөөнөөр хөгжүүлэх цэцэрлэгийн орчин дахь гимнастикийн сургалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор “Цэцэрлэгийн уран хөдөлгөөнт гимнастикийн аварга шалгаруулах тэмцээн”-ийг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр 18	90

						цэцэрлэгийн 330 оролцогчдын дунд зохион байгуулж явуулсан.“Чингэлтэй Фестиваль-2023” арга хэмжээг уламжлал болгон “Шинэ сэргэлт-Чингэлтэй” урианы дор үндэсний өв соёл,уламжлал, үнэт зүйлсийг соёл урлагаар дамжуулан иргэдэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Монгол орны үндэстэн, ястан бүрийн онцлог, түүх соёлыг агуулсан “Дээлтэй Монгол” наадам уламжлал болон Д.Сүхбаатарын талбайд 2023 оны 07 дугаар сарын 09-ны өдөр 17 жилдээ зохион байгуулагдсан. Тус наадамд дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын ажилтан, албан хаагчдын төлөөлөл, 1-24 дүгээр хорооны 1500 иргэн оролцсон. “Дээлтэй Монгол наадам 2023”-д байгууллагынхаа ажилтан албан хаагчид болон хороодын иргэдийг идэвхтэй оролцуулсан хороод, дэргэдэх хэлтэс албадыг шагнаж урамшуулсан юм. 1-р байрт 9 дүгээр хороо 2-р байрт 22 дугаар хороо 3-р байрт 7 дугаар хороо Хэлтэс, албадаас “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв” тус тус шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан. “Даншиг наадам-Хүрээ цам 2023” шашин соёлын наадам 2023 оны 08 дугаар сарын 05, 06-ны өдөр Хүй долоон худагт зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд оролцох бэлтгэл ажлыг	
--	--	--	--	--	--	---	--

						хангаж, 2 өдөр гэрт иргэдийг хүлээн авсан. 2023 оны 08 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Тэрэлж Тайж хайрхны бэлд зохион байгуулагдсан “Нүүдэлчин” Дэлхийн соёлын фестивалд дүүргийн соёлын биет болон биет бус өв тээгч иргэд оролцсон.	
1.8.3	“Хотын соёл” цуврал контент бий болгож цахим нөлөөллийн аяныг хэрэгжүүлнэ.	-	Арга хэмжээний тоо	2	3	Дүүргийн иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Нийтийн бүжгийн сургалт”-ыг “Хайрхан хөгжлийн төв-2”-д долоо хоног бүрийн лхагва гаригт 20 дугаар хороотой хамтран тогтмол зохион байгуулж байна. Чингэлтэй дүүргийн Соёлын төвийн “Эгшиглэнт айзам аялгуу” чуулгын ахмад уран бүтээлчдийн бүтээлийг таниулан сурталчлах, өвлүүлэн үлдээх зорилгоор МУАЖ, УГЗ, Д.Мяасүрэнгийн хөгжим “Буурал аав”, МАД “Хайлуур мөрөн”, Hong Chul Kim-ийн ая “Snow flower”, МАД Данаабал, “Усны тунгалаг гол” дуунуудад видео бичлэгийг бэлтгэн Соёлын төвийн фэйсбүүк хуудсаар дамжуулан 500 гаруй иргэдэд хүргэсэн.	70
1.9 ЖЕНДЭР							
1.9 Жендерийн эрх тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, Жендерийн салбар хорооны үйл ажиллагааг эрчимжүүлнэ.							
1.9.1	Жендерийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ажилтан албан хаагчдыг жендерийн боловсрол олгох	-	Сургалтад хамрагдсан албан хаагчдын хувь	30%	40%	Жендерийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, 2023 оны төлөвлөгөөг боловсруулан харьяа хэлтэс, албадад хүргүүлж хэрэгжилтийг ханган ажилласан. Жендерийн үндэсний хорооноос Шейвцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын хүн амын сангийн “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй	90

	сургалтад хамруулах					тэмцэх нь” төслийн дэмжлэгтэйгээр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээний “Харилцан хүндэтгэе” нэг сарын аяныг зохион байгуулж, нийт 152 албан хаагчийг хамруулсан. Дүүргийн цахим пэйж хуудсаар дамжуулан шторк бэлтгэн 2264 тандалт, 153 лайк 67 шэйртэй олон нийтэд мэдээлж ажилласан. - Өсвөр насны хүүхдүүдэд хорт зуршил болон эрсдэлт зан үйл, жендерийн ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр 2023 онд 14 удаагийн сургалтыг 357 сурагчдыг хамруулан зохион байгууллаа. Мөн 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр “Чингэлтэй хөвгүүд сайн сайханд манлайлна” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Ерөнхий боловсролын 9-11 дүгээр ангийн 76 эрэгтэй сурагчдыг хамрууллаа.	
1.9.2	Эрэгтэйчүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх жишиг төвийг байгуулах	120,0 сая ОУБ-н санхүү- жилт /НҮБ/	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	200	400	НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд “Эрэгтэйчүүдэд зориулсан төрөлжсөн сэтгэл зүйн болон холбон зуучлах үйлчилгээг үзүүлэх нэг цэгийн төвийг нээн ажиллуулж байна. Тус төв нь судалгаа шинжилгээний ажил, сургалт зөвлөгөөг ганцаарчлан өгөх зорилготой 3 сэтгэл зүйч, 1 зохицуулагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.	90

ХОЁР: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1 САНХҮҮ, ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТ: Монгол улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана.

2.1.1	Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулж, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ил, тод нээлттэй байдлыг ханган, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ.	Дүүргийн татварын болон татварын бус орлого 171,465,5 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Улс, нийслэл, орон нутгийн сарын дундаж биелэлт 92,1%, өссөн дүнгээрээ дундаж биелэлт 12,8 тэрбум байна.	Орлогын төлөвлөгөө 100-аас дээш хувиар биелсэн байх.	Монгол улсын Төсвийн тухай хуулийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 23 дугаар зүйл буюу Төсвийн орлогын бүрдэлд өөрчлөлт орж, тус өөрчлөлтийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж ажиллаж байна. Чингэлтэй дүүргийн 2023 оны төсвийн орлого 171 465.5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс дүүргийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/233, мөн 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/324 дүгээр захирамжаар тус тус төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай хуваарийг баталсан. Орон нутгийн жилийн эцсийн төсвийн орлогын төлөвлөгөө 174 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 149,3 тэрбум төгрөг төвлөрүүлэн ХБГ орлогын төлөвлөгөөг 85.8 хувийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй ажилласан.	90
2.1.2	Халдварт цар тахлын эрсдэл нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг хангах ажлуудад зарцуулах төсвийн санхүүжилтэд хяналт тавина.	Дүүргийн 500.0 сая төгрөгийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	2023 оны төсвийн хуваарьт Засаг даргын нөөц хөрөнгө 500.0 сая төгрөг төсөвлөгдсөнөөс 251,8 сая буюу 50.4 хувийн төсөв зарцуулагдсан	Батлагдсан төсвийн санхүүжилт, зарцуулалт ад хяналт тавьж ажиллах	Халдварт цар тахал, байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээтэй холбоотой дүүргийн Засаг даргын 2023 оны захирамжийн дагуу Засаг даргын нөөц сан 357 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.	90

2.1.3	Төсвийг төлөвлөх, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад төсвийн тогтвортой, иж бүрэн, үнэн зөв, ил тод, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, хариуцлагатай байх зарчмуудыг мөрдлөг болгон ажиллаж, төсөвт байгууллагын төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, урсгал зардалд дүн шинжилгээ хийж, төсвийн үр өгөөжийг сайжруулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	2022 онд үргүй зардлыг 0.8 хувиар багасгасан.	Төсвийн үр ашгийг нэмэгдүүлж, үргүй зардлыг бодитоор бууруулсан байх	Засаг даргын Тамгын газрын 2023 оны “2023 оны төсвийн хуваарийн саналыг ирүүлэх тухай” 4/46, 4/49 дүгээр албан бичгээр 13 орон нутгийн байгууллагуудаас тус тус санал авч, 2023 оны 01 дүгээр сард улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн Нийслэлийн зохицуулах зөвлөлийн “Тариф батлах тухай” 02, 04, 07, 08, 510, 516 дугаар тогтоолын дагуу нийт 57 төсөвт байгууллагуудын цахилгаан, дулааны зардлыг тооцон, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан төсвийг хуваарилав. Нийт 12 орон нутгийн байгууллага, 38 цэцэрлэг, 19 сургуулиас бүлэг хоорондын болон сар хоорондын төсөвт зохицуулалт хийх тухай 66 саналыг судлан, дүүргийн Засаг даргын 2023 оны А/58, А/118, А/183, А/233, А/285, А/324 дүгээр захирамжаар төсөвт өр авлага үүсгэхгүй, төсвийн зохистой удирдлага хэрэгжүүлэх үүднээс төсвийн хуваарьт өөрчлөлт орууллаа. Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээлгэх 92 хүсэлт ирүүлснийг судлан Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг нээсэн. 2023 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай дүүргийн Засаг даргын 2023 оны 1/2062 тоот албан бичгийг нийт 70 байгууллагад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. 2023 оны төсвийн жил дуусгавар болохтой холбогдуулан нийт	90
-------	---	---	----------------------------------	---	--	--	----

						70 байгууллагын төсвийн шууд захирагч нарт Засаг даргын Тамгын газрын 2023 оны 4/2782 тоот албан бичгээр төсөвт зохицуулалт хийх санал ирүүлэх тухай албан бичиг хүргүүлж өр төлбөр, авлага үүсгэхгүй байх үүднээс төсөвт бүлэг хоорондын шилжүүлэг хийсэн.	
2.1.4	Дүүргийн 2024 оны төсвийн орлого, зарлагын төсвийн төслийг боловсруулах, санал авах, судалгаа, тооцоо хийж, 2024 оны төсвийн төслийг хуулийн дагуу өргөн барьж, хэлэлцүүлэх, батлуулах зохион байгуулалтын арга хэмжээг авах	-	Хуулийн хугацаанд өргөн барьсан байх	2023 оны дүүргийн төсвийн төслийг хуулийн хугацаанд өргөн барьж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.	2024 оны төсвийн орлого, зарлагын төсвийн төслийг боловсруулсан Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан байх.	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны “Дүүргийн 2023 оны төсөв батлах тухай” 28 дугаар тогтоолоор баталсан төсвийг Төрийн хэмнэлтийн тухай хууль, Дүүргийн Засаг даргын 2022 оны “Төсвийн үр өгөөж, сахилга хариуцлагыг сайжруулах” тухай А/45 дугаар захирамжийн дагуу орон нутаг болон боловсролын байгууллагуудын 2023 төсвийн зарлага, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг, ОНХС, төсвийн орлогын сарын хуваарийг боловсруулан Засаг даргын 2023 оны А/26 дугаар захирамжаар батлуулан өдөр тутмын үндсэн баримтаар хяналт тавин ажилласан. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Дүүргийн 2023 оны төсөв батлах тухай” 28 дугаар тогтоолоор баталсан Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 он, 2022-2023 он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад өөрчлөлт оруулж, 2023 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 7 дугаар тогтоолоор баталсныг мөрдлөг болгон ажиллаж байна. Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны “Дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 12 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын 2023 оны 7	100

						дугаар сарын 31-ний өдрийн А/233 дугаар захирамжийн дагуу нийт байгууллагуудын зарлага, дүүргийн төсвийн орлого, нийслэлд төвлөрүүлэх шилжүүлэг, ОНХС-ийн хуваарийг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжийн дагуу 2023 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 4/1784, 4/1788, 4/1789, 4/1790 тоот албан бичгээр нийт 71 байгууллагаас төсвийн санал, тооцоо судалгааг авч нэгтгэн, 2023 оны 7 дугаар сарын 31-ний 1/1913 тоот албан бичгээр Нийслэлийн Санхүү, төрийн санд хүргүүлж, дүүргийн 2024 оны төсвийг хянуулсан. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус тавдугаар хуралдаанаар дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн баталсны дагуу дүүргийн Засаг даргын 2023 оны А/324 дугаар захирамжаар орлого болон нийт байгууллагуудын төсвийн зарлагын хуваарийн өөрчлөлт батлагдан, хэрэгжилтийг ханган ажилласан.	
2.1.5	Дүүргийн Орон нутгийн болон ТЗШ-ийн байгууллагуудын 2023 оны дүүргийн хагас жилийн нэгтгэсэн тайлан тэнцлийг хянан хүлээн авах, баталгаажуулах, нэгтгэх ажлыг	-	Батлагдсан заавар, журам дагуу УСНББОУС стандартад нийцүүлсэн байх	2021 онд “Зөрчилгүй” санал дүгнэлт гарсан.	Байгууллаг уудыг бүрэн хамруулж, хууль тогтоомж, заавар журмын хүрээнд 100% хүлээн авч	ЕБС, СӨБ болон орон нутгийн төсвийн байгууллагуудын тайлан балансыг улирал тутам хянаж, хүлээн авч байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу Чингэлтэй дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн 2022 оны жилийн эцсийн тайланг гаргаж, 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдөр аудитлагдсан байдлаар 2023 оны хагас жилийн тайланг 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдөр тус тус нийслэлийн	90

	хуулийн хугацаанд нь зохион байгуулах				баталгаажуулсан байх.	Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгүүлэн ажилласан.	
2.1.6	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжих ажлуудын санхүүжигдэх төсөл арга хэмжээний уялдааг ханган, санхүүжилтийг олгож, гүйцэтгэлийг хянан удирдлагыг мэдээллээр хангах	-ДТХО 19,626.3 сая, -ДТХО он дамжих 12,442.0 сая, -ДОНХС 1,901.4 сая, -ДОНХС он дамжих 523.0 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Төсөл арга хэмжээ 80 хувь, он дамжин хэрэгжих төсөл хөтөлбөр 90 хувийн хэрэгжилттэй байсан.	Төсөл арга хэмжээг 80% хэрэгжүүлсэн байх	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 16 дугаар тогтоолоор Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022-2023 он дамжин хэрэгжүүлэх 47 төсөл арга хэмжээ батлагдсан. Үүнээс: ✓ Хуулийн байгууллагад шалгагдаж байгаа 1 ✓ Гэрээ байгуулан ажил үргэлжилж байгаа 8 ✓ Бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн 37 ✓ Тендерийн шатандаа байгаа 1 төсөл арга хэмжээ байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний бүрэн хэрэгжиж хүлээлгэн өгсөн 37 төсөл арга хэмжээний санхүүжилт болох 2,839.30 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлэх 33 төсөл арга хэмжээ батлагдсан. Үүнээс: ✓ Тендерийн шатандаа байгаа 11 ✓ Гэрээ байгуулан ажил үргэлжилж байгаа 8 ✓ Бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн 6 ✓ Бэлтгэл ажлын шатандаа байгаа 8 төсөл арга хэмжээ байна. Дуусаж хүлээлгэн өгсөн нийт 6 төсөл арга хэмжээний санхүүжилт болох 3,319.94 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022-2023 он дамжин хэрэгжүүлэх 11 төсөл арга хэмжээ батлагдсан. Үүнээс:	90

						✓ Бүрэн дууссан хүлээлгэн өгсөн 11 Дуусаж хүлээлгэн өгсөн нийт 11 төсөл арга хэмжээний санхүүжилт болох 448,04 сая төгрөгийн санхүүжилтийн мэдэгдлийг бичиж санхүүжилтийг олгосон. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлэх 32 төсөл арга хэмжээ батлагдсан. Үүнээс: ✓ Гэрээ байгуулан ажил үргэлжилж байгаа 1 ✓ Бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн 20 ✓ Бэлтгэл ажлын шатандаа 6 ✓ Тендерийн шатандаа байгаа 5 төсөл арга хэмжээ байна. Дуусаж хүлээлгэн өгсөн нийт 20 төсөл арга хэмжээнээс 13 төсөл арга хэмжээний санхүүжилт болох 656,60 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	
2.1.7	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын улирал, жилийн санхүүгийн тайланг хянан хүлээн авах, е-балансын программаар баталгаажуулж, илгээх, дүн мэдээг нэгтгэх	-	Нийт байгууллагыг хамруулсан тоогоор	2021 онд 80.5 хувь хүртэлх санхүүгийн тайланг хүлээн авсан.	Нийт байгууллагуудыг 100-аас дээш хувиар хамруулсан байх	Дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг цахим санхүүгийн Е-баланс программаар дүүргийн хэмжээнд 80,6 хувьтай хүлээн авсан. Тайлан хүлээн авалтаар: Нийт тайлан ирүүлэх ёстой 12858 аж ахуйн нэгж, байгууллагаас: Тайлан баталгаажсан - 6498 буюу 50,5%, Тайлан баталгаажгаагүй -3865 буюу 30,1%, Тайлан огт гаргаж ирүүлээгүй-2495 буюу 19,4% байна. Сангийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тушаалын хавсралт журмын дагуу Дүүргийн төсөвтэй харьцдаг 88 аж ахуйн нэгж, байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Аудитын дүгнэлт болон анхан шатны	90

						баримтыг үндэслэн цахим санхүүгийн программд залруулсан. Дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагууд болон нийтийн сонирхлын аж ахуйн нэгж, байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг е-баланс цахим санхүүгийн программаар хүлээн авч, хянаж, баталгаажуулалт хийн ажиллаж байгаа ба тайлан нь алдаатай аудитын байгууллага хүлээн зөвшөөрөөгүй 702 тайланг е-баланс цахим санхүүгийн программ руу өдөр тутам орж, шалган засаж илгээсэн тайланг программ дээр баталгаажуулан холбогдох байгууллагууд руу холбогдон тайланг засуулан авч баталгаажуулж ажилласан. Татварын хяналт шалгалтаар орж татан буугдсан 27 аж ахуйн нэгж, байгууллагын тайланг хянаж, е-баланс программаас хасалт хийсэн. Е-баланс цахим санхүүгийн программд 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар 5370 аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлан ирүүлснийг баталгаажуулж ажилласан.	
2.1.8	Төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд төсвийн захирагч нарт мэдээлэл хүргэх, санхүү бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулах чиглэлээр сургалт	Дүүргийн 20 сая төгрөгийн төсөв	Сургалт, хамрагдсан хүний тоогоор	2022 онд 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор 140 нягтлан бодогчийг хамруулсан.	5 удаагийн сургалтад 250-аас дээш тооны албан хаагчийг хамруулсан байх	Төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төсөвт байгууллагуудын төсвийн шууд захирагч болон санхүү, бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулах 2023 оны нэгдсэн сургалтын төлөвлөгөөг батлуулан ажилласан. Төлөвлөгөөний дагуу 2023 оны 6 дугаар сарын 22-нд орон нутаг болон сургууль, цэцэрлэгийн нийт 67 ерөнхий нягтлан бодогчдыг сургалтад хамруулан ажилласан.	70

	семинарыг цахим болон танхим хэлбэрээр зохион байгуулах, мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх						
2.1.9	Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд www.shilendans.gov.mn сайт, дүүргийн цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан санхүү, төрийн сангийн үйл ажиллагааг иргэдэд мэдээлэх, төсөвт байгууллагуудын төсөв санхүүгийн мэдээг шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд мэдээлэхэд хяналт тавьж ажиллах	-	Цахим сайтад байршуулсан мэдээний тоо	2023 онд 87 мэдээг хуулийн хугацаанд мэдээлж ажилласан.	Цахим сайтад 87 мэдээг хуулийн хугацаанд байршуулсан байна.	2023 онд шилэн дансны сайт өөрчлөгдсөн бөгөөд https://gar.mof.gov.mn хаягаар бүртгүүлж, админ хэрэглэгчээр бүртгүүлэн, байгууллагын шилэн данс оруулах шаардлагатай хэрэглэгчдийн бүртгэл үүсгүүлэн нэмсэн. Нийт 7 ажилтныг мэдээ оруулах хэрэглэгчээр бүртгэсэн бөгөөд нийт 163 мэдээлэл оруулахаас цаг тухайд нь оруулсан 154 буюу 95 хувьтай байна.	100
2.1.10	Төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог төрийн сангийн үйл ажиллагааны журам, холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Төсөвт байгууллаг уудын төлбөр тооцоог санхүүгийн бүрдэл болсон	Хууль журмын хүрээнд төлбөр тооцоог эрсдэлгүй 100 хувь хийж	Төсвийн тухай, Банкны тухай, Татварын багц хууль, Сангийн сайдын 2014 оны 5, 55, 95, 2015 оны 7 дугаар тушаал, 2016 оны 431-р тушаал, 2021 оны 190-р тушаал ба Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журам, тэдгээртэй	90

	анхан шатны бүрдэл болсон баримтаар зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу хяналт тавин гүйцэтгэх			баримтаар 100 хувь хийж гүйцэтгэсэн .	ажилласан байна.	нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу төсөвт байгууллагуудын баталгаат гарын үсэг бүхий санхүүгийн бүрдэл болсон баримтаар төлбөр тооцооны мэргэжилтний системд бүртгэсэн төлбөр тооцооны гадаад, дотоод гүйлгээг төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн он, сар, өдөр, очих банкны код, байгууллагын нэр, дансны дугаар, эдийн засгийн ангилал, хөтөлбөр , зориулалт, мөнгөн дүнг хянаж тулган түргэн шуурхай, үнэн зөв шалган баталгаажуулж, төв төрийн санд дамжуулан ажилласан. 2023 оны жилийн эцсийн байдлаар зарлагын 331,6 тэрбум төгрөгийн нийт 34,198 ширхэг гүйлгээг үнэн зөв, алдаагүй шалган баталгаажуулж төв төрийн санд дамжуулан ажилласан.	
2.1.11	Татварын хэлтсээс ирүүлсэн иргэн аж ахуйн нэгжийн улсын тэмдэгтийн хураамжийн буцаалт, залруулгын гүйлгээг тухай бүрд нь хийж гүйцэтгэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Залруулгын гүйлгээг 100 хувь шилжүүлэн ажилласан.	Хүсэлтийг хүлээн авч шаардлагатай материалын бүрэн бүтэн, шаардлагад нийцсэн эсэхийг хянаж төлбөрийн хүсэлт бэлтгэн гүйлгээнд шилжүүлэх . Хүсэлтийг хүлээн авснаас	Татварын хэлтсээс ирүүлсэн улсын тэмдэгтийн хураамж буцаан авах нийт иргэн, аж ахуйн 2770 ширхэг 2,915.7 сая төгрөгийн гүйлгээг тус бүрд шалган интернэт банкаар данс эзэмшигчийн мэдээллийг нэр тус бүрээр тулгаж, татварын хэлтсээс ирүүлсэн жагсаалт хүсэлтийн дагуу Сангийн яамны төрийн сангийн газарт багцын гүйлгээ шилжүүлэх тухай 22 албан бичгийг төлөвлөж багцын гүйлгээг хугацаанд нь гаргаж ажилласан. Мөн www.erp.ulaanbaatar.mn цахим хуудасны e-doc системээр данс андуурсан 25 гүйлгээг хянан шалгаж гүйлгээг үүсгэж залруулга хийсэн.	100

					хойш 30 хоногийн дотор багтаан шийдвэрлэ -сэн байх		
2.2 ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ							
2.2 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих “Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.							
2.2.1	"Чингэлтэйд үйлдвэрлэв-2024" арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана.	60.0 Дүүргийн төсвийн хөрөнгө	Зохион байгуулсан ажлын тоо	5	5	Дүүргийн Засаг даргын 2023 оны “Үйлдвэрлэлийг дэмжих жил болгон зарлах тухай” А/01 дугаар захирамж батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын дэргэдэх 10 хэлтэс, 6 алба, дүүргийн 1-24 дүгээр хороо нийт 39 байгууллагаас ирүүлсэн 166 ажлын саналаас 41 саналыг төлөвлөгөөнд тусган батлуулсан. Төлөвлөгөөний дагуу биелэлтийг холбогдох хэлтэс, албадаас авч, нэгтгэн ажлын хэсэгт танилцуулан ажиллаж байгаа бөгөөд биелэлт 92,8% байна. Дүүргийн 1-24 дүгээр хорооны 1300 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг хамруулан уулзалт зохион байгуулсан ба тус уулзалтаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, дүүргийн ХөХҮХ, ЖДҮ-ийг дэмжих төвөөс үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 2023 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг танилцуулж, 28 үйлдвэр эрхлэгчдийн санал хүсэлтийг шийдвэрлэж ажилласан. Дотоодын 14, гадаадын 10 нийт 24 удаагийн үзэсгэлэн худалдаанд 409 үйлдвэрлэгч оролцож, 1,274,129,200 төгрөгийн бараа бүтээгдэхүүн борлуулан ажилласан.	100

						“Чингэлтэйд үйлдвэрлэв” Алтжин бөмбөгөр худалдааны цэгт 40 үйлдвэрлэгчийн 4543 ширхэг бараа бүтээгдэхүүн худалдаалж, 256,894,100 төгрөгийн борлуулалт; “Чингэлтэйд үйлдвэрлэв 3” худалдааны цэгт 70 үйлдвэрлэгчийн 21,000,000 төгрөгийн (хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бараа бүтээгдэхүүн 5,600,000 төгрөг) бүтээгдэхүүн тус тус борлуулагдсан. “Уран үйлчин-2023” уралдаан II үе шаттайгаар зохион байгуулагдаж 121 оёдолчин оролцож, Үндэсний хувцас, европ хувцас, хөдөлмөр хамгааллын хувцас гэсэн гурван төрөлд тус тус эхний 5 байрыг шалгаруулсан. Оёдлын салбар нь нэмүү өртгийг ихээр шингээдэг, ажлын байрыг бий болгодог учраас “Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн IV” зөвлөгөөнийг 295 иргэн аж, ахуйн нэгжийг хамруулан зохион байгуулсан. Зөвлөгөөн хэлэлцүүлгийн дүгнэлтээс дүүргийн ерөнхий боловсролын I-V ангийн сурагчдын дүрэмт хувцсыг кластераар хамтран нийлүүлэхийг иргэд, аж ахуй нэгжүүд санал, санаачилга гарган, дэмжиж, ажлын хэсэг байгуулан ажиллахаар шийдвэрлэсэн. Нийт 115 удаагийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулж давхардсан тоогоор 4057 үйлдвэр эрхлэгчийг хамруулж ажилласан. “Мэргэжил бүхэн сайхан” мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг Барилгын политехник коллеж, “Хөгжил” мэргэжлийн чиг баримжаа, боловсрол олгох төвтэй хамтран 10 дугаар сарын 25, 26-ны өдөр Ерөнхий боловсролын 61, 72 дугаар сургууль	
--	--	--	--	--	--	--	--

						дээр 9 болон 12 дугаар ангийн нийт 220 сурагчдыг хамруулан зохион байгуулсан.	
2.2.2	Нийслэл хотын залуусын дунд үндэсний өв соёл, түүх, ёс заншил агуулсан үндэсний бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэхэд уриалсан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн нийгэм дэх байр суурийг нэмэгдүүлэх, борлуултал эерэг нөлөө үзүүлэх ач холбогдол бүхий сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ болон контентын ажлыг хийж гүйцэтгэнэ.	15.0 Дүүргийн н төсвийн хөрөнгө	Зохион байгуулсан ажлын тоо	2	2	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн инновацлаг санааг шингээсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтын орлогыг дэмжих зорилготой сэтгүүлд оролцох 92 үйлдвэрлэгчдийн судалгааг гаргаж бүтээгдэхүүний зураг авалтыг хийж, 92 үйлдвэрлэгчийн зургийг хүлээн авч эх бэлтгэл, орчуулгын ажил хийгдэж, сэтгүүлийг 2023 оны 06 дугаар сард 4200 ширхэг хэвлүүлэн, үйлдвэрлэгч болон иргэдэд хүргэн ажилласан. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг харуулсан видео танилцуулга хийлгэх хүрээнд Юникфилм партнершип ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн инновац” төслийн хүрээнд 30 үйлдвэр эрхлэгчийг хамруулан уулзалт зохион байгуулж, санал солилцон 10 видео танилцуулга хийгдэж, Чингэлтэй дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн цахим хуудсаар 51000 иргэн, үйлдвэрлэгч нарт хүргэсэн.	100
2.2.3	Гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулж, хөгжүүлнэ	20.0 Дүүргийн н төсвийн хөрөнгө	Бизнес эрхлэгчдийг бойжуулсан тоо	10	10	Шилдэг стартап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, Bootcamp, Хурдасгуур хөтөлбөр зэрэг бизнес эрхлэлтийг дэмжих үе шаттай сургалтуудыг зохион байгуулсан. Гуравдугаар шатны шалгаруулалт буюу DEMO DAY арга хэмжээг 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж Чингэлтэй дүүргээс 5 баг оролцож шилдгээр “Ган	100

						Айро майнд", "Үүсэл" багууд шалгарч, баг тус бүр 10 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн батламж гардан авсан. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, аж ахуй нэгжүүдийг Бэст хөтөлбөрийн 3 сарын хугацаатай хурдасгуур Green Lab "Хүнсний бизнесийг хөгжүүлэх" I,II хөтөлбөрт 8 аж ахуйн нэгжийг хамруулсан. I хөтөлбөрт 3 аж ахуй нэгж, 1 иргэн хамрагдсанаас иргэн Ж.Нацагням амжилттай төгсөж, II шатанд иргэн Ж.Нацагням цааш үйлдвэрлэлээ өргөжүүлэхийн тулд "Өрнөх" ХХК-ийг байгуулан суралцаж төгссөн.	
2.3 Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийг дэмжинэ							
2.3.1	Зочид буудал, аялал жуулчлал, худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төрөлжсөн сургалтуудыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	3.0 Улс, Дүүргийн төсвийн хөрөнгө	Зохион байгуулсан ажлын тоо	2	2	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, малын гаралтай тосны үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Натурал Грасс Ланд" ХХК-тай хамтран малын гаралтай бүтээгдэхүүний хог хаягдал, өөх, өөхөн тосны хаягдлыг бууруулах зорилготой мэдээлэл олгох сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдөр дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 25 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан зохион байгуулж ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан аялал жуулчлал, хоол үйлдвэрлэл	100

						үйлчилгээний салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Монголын ресторан зоогийн газрын холбооноос 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр "Зоогийн газарт зориулсан технологийн шийдлүүд" сэдэвт сургалтад дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 15 аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулан ажилласан. Horeca institute байгууллагаас "HoReCa Mongolia conference 2023" зочлох үйлчилгээний 5 дугаар чуулга уулзалтын хөтөлбөр хөтөлбөрийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр зочлох үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нийт 3 аж ахуйн нэгжийг тус чуулга уулзалтад хамруулсан. Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй "Хариуцлагатай үйлчилгээг дэмжье" аяны хүрээнд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий нийт 266 ажилтанд хариуцлагатай үйлчилгээ үзүүлэх сургалтыг 2023 оны 08 дугаар сарын 30, 09 дүгээр сарын 01, 06, 08,30-ны өдрүүдэд "Боловсрол Ирээдүйн Хөгжлийн Гарц" ТББ, Монголын үндэсний хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо ТББ-тай хамтран зохион байгуулсан. Нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран "Зочид буудлын эрүүл ахуй, бэлгийн замын халдварт өвчин сэдэв"-ийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 17 аж ахуйн	
--	--	--	--	--	--	---	--

						нэгжийн эзэн, угтагч, зохион байгуулагч, хаалгач нарыг хамруулсан сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан.	
2.3.2	Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS4588:2008, Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд ерөнхий шаардлага MNS6043:2009 стандартыг хяналтын хуудасны дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй зочид буудлуудад хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулж, бүртгэл судалгааг сайжруулж, стандартын түвшинд ойртуулна.	3.0 Улс, Дүүргийн н төсвийн хөрөнгө	Зохион байгуулсан ажлын тоо	2	2	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242, дүүргийн Засаг даргын 2023 оны А/120 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт амралтын газар, зочид буудал, дэн буудал чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 23 иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль, тогтоомж, норм, дүрэм, стандартыг хангуулахаар Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Аялал, жуулчлалын газар, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, дүүргийн Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг хамтарсан хяналт, шалгалтыг 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс 08 дугаар сарын 11-ний өдөр хүртэлх хугацаанд хийж, үүрэг гүйцэтгэн ажилласан. Хяналт, шалгалтаар эрүүл ахуй хангаагүй, цэвэрлэгээ үйлчилгээ хийгээгүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, галын аюулгүй байдал алдагдсан зэрэг нийтлэг зөрчлийг газар дээр нь арилгуулан, ерөнхий шаардлага, стандартыг хангуулахад хугацаатай үүрэг, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	90

2.4 Иргэдийг чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүн, хүнсний ногоогоор хангах нөхцөлийг бүрдүүлэн, газар тариалангийн бүс нутгийн аймаг, сум, тариалалт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжинэ.

2.4.1	Шинэ ургацын төмс, хүнсний ногоо, худалдан борлуулах, мод үр үрслэгээний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, тариаланч иргэдийг дэмжин ажиллана.	2.0 Дүүргийн төсвийн хөрөнгө	Зохион байгуулсан ажлын тоо	2	2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн “Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулах тухай” А/194 дүгээр тушаалын дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/233 дугаар тушаалаар дүүргийн нутаг дэвсгэрт нийт 5 байршилд Сэлэнгэ, Дархан, Өмнөговь, Ховд аймгийн 40 гаруй ногоочдыг хамруулан 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хооронд зохион байгуулж, нийт 1,330,750,000 төгрөгийн төмс, хүнсний ногоо борлуулсан. Үзэсгэлэн худалдаанд оролцох иргэн, аж ахуйн нэгжүүдэд тавигдах шаардлагыг танилцуулах, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах заавар зөвлөмж өгөх, холбогдох хууль тогтоомж, стандартыг танилцуулах сургалтыг 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, санамж бичиг байгуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны "Мод, бут, сөөгийн суулгац, үр үрслэгээний үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай" А/122 дугаар тушаалын дагуу дүүргийн 4 дүгээр хороо,	100
-------	---	---------------------------------	-----------------------------	---	---	---	-----

						Барилгачдын талбайд 5 болон 10 дугаар сард 2 удаагийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж нийт 54 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан, 60 гаруй нэр төрлийн 56,000 ширхэг мод, бутны үрслэгээ худалдаалж, 360 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.	
2.4.2	Ногоо тариалах хүсэлтэй иргэдийг бүлэг үүсгэх замаар төмс, хүнсний ногоо тариалуулж, худаг усжуулалт болон ногоо хадгалах бололцоогоор хангаж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн ажлын байр бий болгоно.	10.0 Дүүргийн н төсвийн хөрөнгө	Зохион байгуулсан ажлын тоо	2	2	Халамжаас Хөдөлмөрт зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/658 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар Агро паркт зорилтот бүлгийн өрх толгойлсон иргэдийн судалгааг авч, тус иргэдийг хүнсний ногоо тариалах арга барилд сургаж, түр ажлын байр бий болгох замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэн, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “Хүнсний ногоо тариалах арга хэмжээ” төслийг хэрэгжүүлэн ажиллахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар “Нэг өрх-Нэг ажлын байр” нийслэлийн дэд хөтөлбөр болон Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлөөс баталсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд “Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээ”-г зохион байгуулж, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Тарвагатайн аманд байрлах 7га газарт “UB Агро парк” 1 бүлгийн 15 хүний бүрэлдэхүүнтэй 7 бүлэг 105 иргэнийг хамруулан төмс, хүнсний ногоо тариалуулж хамрагдсан иргэд хураасан ургацаа өрхийн хэрэгцээндээ ашиглах болон зарж борлуулан орлогоо нэмэгдүүлэх боломжтой нөхцөлөөр хангасан.	90

						Төмс, хүнсний ногоо тариалах хүсэлтэй зорилтот бүлгийн иргэдийг дэмжин дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнд 50 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэй 8 сая төгрөг, 3 ахмад настанд тус бүр 5 сая төгрөг, өрх толгойлсон ээжид 1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж зээл тусламжид хамруулан ажилласан.	
2.4.3	Нийслэлийн хүн амын ихээр үйлчлүүлдэг томоохон цэгүүдээс (зах, худалдааны төв, супермаркет) өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнийн судалгааг хийж, үр дүнг боловсруулан, танилцуулан тархаана.	-	Судалгааны давтамж	52	52	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр “Хүнс, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжид хяналт хийх тухай” удирдамж батлагдсан. Удирдамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд “дэлгүүрийн лангуун дээрх барааны үнийг бичихгүй байгаагаас хэрэглэгч үнэн зөв, бодит мэдээлэл хийгээд чөлөөтэй сонголт хийх нөхцөлөөр хангагдахгүй хохирч байна” гэх гомдол, мэдээллийг олноор ирүүлсэн уг гомдол, мэдээллийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хүнс худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 19 иргэн, аж ахуйн нэгжид түүвэрчилсэн хяналт хийж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулж, уг зөрчлийг гаргахгүй байхад чиглэсэн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт худалдааны төвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 8 аж ахуйн нэгжээс гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөц болон үнийн судалгааг долоо хонон бүрийн Баасан гарагт нийт 52 удаагийн судалгааг авч,	90

						Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.	
2.4.4	Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд дүүргийн өмчлөлд байгаа халуун усны газруудын үйл ажиллагаа, ашиглалтыг сайжруулах замаар хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх, ахуйн үйлчилгээний төвийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын ажил хэрэгжүүлнэ.	5.0 Дүүргийн төсвийн хөрөнгө	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	50%	70%	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 3/234 дүгээр албан бичгээр дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэл, дүүргийн хөрөнгөөр баригдсан нийтийн халуун усны газруудын өмчийн мэдээллийг гарган ирүүлэх хүсэлт илгээсний дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 3/197 дугаартай албан бичгээр дүүргийн нутаг дэвсгэрт 6 байршилд нийт 499,842,927.10 төгрөгийн өртөг бүхий нийтийн халуун ус, ахуйн үйлчилгээний төвийн барилгууд бүртгэлтэй байгаа талаар мэдээллийг ирүүлсэн. Дүүргийн өмчид бүртгэлтэй 8, 10, 14, 17, 20 дугаар хороодын нутаг дэвсгэрт байрлах нийтийн халуун усны барилгуудын ашиглалтыг сайжруулах талаар тухайн хороодын Засаг дарга нараас санал авч, ирүүлсэн саналын дагуу засвар үйлчилгээ хийж ашиглалтыг сайжруулах чиглэлээр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан ажилласан. Дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах халуун усны барилгын ашиглалтыг сайжруулан 60,0 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийж оёдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангасан хэдий ч цэвдэгтэй, хүйтэн байдаг, бохирын шугам хөлдсөн гэх шалтгаанаар үйл ажиллагаа явуулах боломжгүй байгаа	70

						тул дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-т засвар хийхэд шаардагдах төсвийг гарган ирүүлэх тухай албан бичиг хүргүүлэн ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 418 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2023 оны А/120 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийтийн халуун ус, сауны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 15 иргэн, аж ахуйн нэгжид “Үйлчилгээний байгууллагын гадна стандартад тавигдах шаардлага”, “Халуун усны үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS 5163:2002 стандарт”-г танилцуулах сургалтыг дүүргийн Засаг даргын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс Нийслэлийн Хотын стандарт хяналтын газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан.	
2.5 Авто үйлчилгээний салбарт тавих стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэж, хяналт шалгалтыг сайжруулах замаар тохирлын үнэлгээнд бүрэн хамруулж, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх, хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулах ажлыг зохион байгуулна.							
2.5.1	Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн аж ахуй нэгжид холбогдох дүрэм, журам мөрдөгдөж байгаа эсэхэд хяналт,	1.25 Дүүргийн төсвийн хөрөнгө	Зохион байгуулсан ажлын тоо	2	2	Дүүргийн 6,14,17,18,19,24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 28 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад “Онлайн бизнес төвд” бүртгүүлсэн, стандарт, журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд дүүргийн Замын цагдаагийн хэлтэстэй хамтран хяналт хийж, илэрсэн	90

	шалгалт зохион байгуулж сургалтад хамруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.				арилгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Дараах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв: • “Онлайн бизнес төв” системд бүртгүүлэх зааварчилгаа • Тохирлын үнэлгээнд хамрагдахад бүрдүүлэх бичиг баримт • Ангилал тогтоолгох тухай Орчны 50 метрийн цэвэрлэгээ үйлчилгээ хийх тухай зөвлөгөө өгч ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэд, аж ахуй нэгжүүдэд Монгол улсад мөрдөгдөж байгаа “Авто тээврийн тухай хууль” болон дүрэм журам, стандартууд болон авто тээврийн салбарын “Хог хаягдлыг бууруулах менежментийг сайжруулах, хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг таниулах” сэдвээр 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр сургалт зохион байгуулсан. Сургалтад авто засвар, дугуй засвар, авто угаалга, авто тос тосолгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 28 иргэн, аж ахуйн нэгж хамрагдав. Нийслэлийн Засаг даргын “Хяналт шалгалт хийх тухай” А/1267, А/1292 дугаартай захирамж, дүүргийн Засаг даргын 2023 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/333 дугаартай захирамж болон тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагуудын удирдлагууд баталсан “Авто үйлчилгээ, хоёрдогч	
--	--	--	--	--	---	--

						түүхий эд худалдан авах цэг, барилгын материалын худалдаа, үйлчилгээ эрхэлж буй үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх удирдамж"-ийн хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 16-нөөс 11 дүгээр сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд дүүргийн 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт авто үйлчилгээ, хоёрдогч түүхий эд худалдан авах цэг, барилгын материалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 48, шалгалтын явцад шинээр нэмж бүртгэгдсэн 65, нийт 113 үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн. Хяналт, шалгалтаар Авто тээврийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиудын хэрэгжилт болон холбогдох журам, улсын стандартуудын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулан ажилласан.	
2.6 Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хүнс, худалдаа үйлчилгээ, барилга, эрүүл мэнд, боловсролын салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэнэ.							
2.6.1	Худалдаа, нийтийн хоолны салбарт тавигдах стандартын хэрэгжилтийг хангуулж, хяналт шалгалт, мэргэжил арга зүйн удирдлагаар байгууллагуудыг хангаж ажиллана.	2.0 Дүүргийн төсвийн хөрөнгө	Зохион байгуулсан ажлын тоо	3	3	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Сургалт зохион байгуулах тухай” А/120 тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс хамтран “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр дүүргийн 1-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэл,	90

						үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 97 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан зохион байгуулав. Сургалтад Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, дүүргийн Татварын хэлтэс, дүүргийн Цагдаагийн газар, Монголын хоол зүйн шим судлалын нийгэмлэгээс холбогдох чиглэлээр мэдээлэл хүргэсэн. Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242, дүүргийн Засаг даргын 2023 оны А/120 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт зах, худалдааны төв чиглэлээр 5, хүнсний үйлдвэрийн чиглэлээр 27 нийт 31 иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль, тогтоомж, норм, дүрэм, стандартыг хангуулахаар Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Аялал, жуулчлалын газар, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, дүүргийн Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг хамтарсан хяналт, шалгалтыг 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд хийж, үүрэг гүйцэтгэн ажилласан. Хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 200 иргэн, аж ахуйн нэгжид иргэдийн эрүүл, аюулгүй , ая тухтай орчныг бүрдүүлэхэд	
--	--	--	--	--	--	---	--

						хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах тухай хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дотоод хяналт шалгалтыг сайжруулах талаар 6/182 дугаартай 19 заалт бүхий зөвлөмж, шингэрүүлсэн шатдаг хий хэрэглэгч нийтийн хоолны газруудад 01/144 дугаартай 9 заалт бүхий зөвлөмжүүдийг хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллав. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны “Арга хэмжээ зохион байгуулах тухай” А/239 дугаар тушаалын хэрэгжилтийн хангах хүрээнд хүүхдийг гэмт, хэрэг зөрчлийн хохирогч болох эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор “Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ, хуулийн хэрэгжилт”, “Мансууруулах бодис сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэсэн этгээдийн шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх тухай”, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, Нийслэлийн мэдээ, мэдээллийн Ulaanbaatar.mn цахим хаягт Согтууруулах ундаа хупдалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлт илгээх тухай сэдэвт сургалтыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад	
--	--	--	--	--	--	--	--

						дүүргийн нутаг дэвсгэрт хүнс худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 273 аж ахуйн нэгж хамрагдсан. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны “Арга хэмжээ зохион байгуулах тухай” А/239 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд хүүхдийг гэмт хэрэг зөрчлийн хохирогч болох эрсдлийг бууруулах, урьчдлан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор дүүргийн 10-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд дүүргийн Цагдаагийн газрын Хоёрдугаар хэлтэстэй хамтран 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 18:00-02:00 цаг хүртэл шөнийн хяналт, шалгалтыг зохион байгуулсан. Тус хяналт шалгалтад хамрагдсан хүнсний дэлгүүр, баар/караоке, зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 150 аж ахуйн нэгжид насанд хүрээгүй хүүхдэд архи, согтууруулах ундаагаар үйлчлэхгүй, үйлчлүүлэгч 21 нас хүрсэн эсэхийг шалгах зорилгоор баримт бичгийг заавал шалгах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөрчлийг арилгуулан ажиллав.	
3 БАРИЛГА , ХОТ БАЙГУУЛАЛТ							
3.1 Сууц өмчлөгчдийн холбоод, нийтийн аж ахуйн чиглэлийн үйл ажиллагааны чанар болон тогтолцоог боловсронгуй болгож, олон жилийн насжилттай орон сууцны барилгуудын дулаан алдагдлыг бууруулах ажлыг зохион байгуулна.							
3.1.1	Арга хэмжээ 2.1. Сууц өмчлөгчдийн холбоод, нийтийн аж ахуйн чиглэлийн	0.01	Аргазүйн зөвлөгөө СӨХ-д өгсөн	2022 оны үзлэг шалгалтаар	Дүүргийн 50 СӨХ-дод түвшин тогтоох	2023 оны 12 дугаар сард Монголын сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлтэй хамтран дүүргийн 1-6, 9, 10, 15 дугаар хорооны 106 сууц өмчлөгчдийн	90

	үйл ажиллагааны чанар болон тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор түвшин тогтоох шалгалт зохион байгуулж үнэлгээ өгч ажиллана		тоон үзүүлэлтээр	хангалттай үнэлэгдсэн.	үзлэг шалгалт явуулна	холбооны үйл ажиллагаанд түвшин тогтоох үзлэг шалгалтыг зохион байгуулсан.	
3.1.3	Арга хэмжээ 2.2. Олон жилийн насжилттай орон сууцны барилгуудын дулаан алдагдлыг бууруулна	2.000.0	Орон сууцны байруудын дээвэр, фасад засварын ажлын тоогоор	Дээвэр-13 Фасад-7	Дээвэр засвар-23 фасад засвар-10	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Гега тера тех” ХХК 2022-2023 онд 1, 2, 4, 5, 6 дугаар хороонд 7 байрны дээвэр засвар, 9 байрны фасад засвар хийгдэж ашиглалтад оруулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 12 байрны дээвэр, 3 байрны фасад засварын ажил хийж гүйцэтгэхээр “Интел хаитек” ХХК болон “Буяаннэмэх интер” ХК-ийн түншлэл шалгарсан. 2023 онд 8 байрны дээвэр засвар 1 байрны фасад засварын ажил хийж гүйцэтгэхээс 1 байрны фасад 4 байрны дээвэр засварын ажил хийж гүйцэтгэсэн байна. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 700,0 сая төгрөгийн төсөв өртөгтэй 2022-2023 онд 4 дүгээр хороо 46 дугаар байр “Шинэ өлгийн зам” ХХК, 5 дугаар хороо 5 дугаар байр “Эс эй би эи” ХХК, 3 дугаар хороо 6 дугаар байр “Ирмүүн бар” ХХК фасад засвар хийгдэж ашиглалтад оруулсан. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2 дугаар хороо 26 дугаар байр фасад засварын ажил хийж гүйцэтгэхээр “Дархан нэгдэл” ХХК шалгарсан. Гүйцэтгэл 80 хувьтай.	90

						Дүүргийн 6 дугаар хороо 26 дугаар байр фасад засвар хийгдэхээр "Эс эй би эи" ХХК шалгарсан 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр нэгдсэн хурал хийж, 2024 оны 04 сард хийж гүйцэтгэхээр шийдвэрлэсэн.	
3.1.3	Арга хэмжээ 3.1. Орон сууцны барилгуудын ашиглалтын хугацаа дууссан гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.	50.0	Орон сууцны засварын ажлын тоогоор	Засварлах шаардлага тай 15 байр	ОСНААУГ-2	Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 1, 4 дүгээр хорооны 3 СӨХ өөрсдийн хуримтлалаар хэсэгчилсэн сантехникийн засвар үйлчилгээг хийж халаалт бүрэн авсан. Улс, нийслэл, дүүргийн 2023 оны төсөвт орон сууцны барилгуудад цахилгаан засварын ажил хийх төсөв суугдаагүй.	70
3.2 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлж нэгдсэн удирдлага-хяналтын системд холбож, “Жишиг гудамж”-уудын тоог гэр хороололд нэмэгдүүлнэ.							
3.2.1	Арга хэмжээ 4.1. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.	238.0	Хийгдсэн гэрэлтүүлгийн тоо	11785	111955	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд 7, 12, 16, 17 дугаар хороонд 125 гэрэлтүүлгийг "Тэнгэр цэгцрэн" ХХК хийж гүйцэтгэсэн. Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр "Соёндрийм" ХХК 2-6 дугаар хороонд 96 гэрэлтүүлгийн 100 ватт лед гэрэлтүүлэгчээр сольж шинэчилсэн. Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр "Соён Дрийм" ХХК 6, 7, 9, 10, 12, 13, 15-17, 19-24 дугаар хороонд 121 гэрэлтүүлгийг шинээр хийж гүйцэтгэсэн. Хороодоос албан бичгээр хүсэлт ирүүлсний дагуу 12, 13, 17, 19, 24 дугаар хороонд 46 гэрэлтүүлгийг шинээр хийж гүйцэтгэсэн.	90

3.2.2	Арга хэмжээ 4.2. “Жишиг гудамж”-уудын тоог гэр хороололд нэмэгдүүлнэ.	200,0	Хийгдэх жишиг гудамжны тоо	18	22	Гэр хорооллын болон орон сууц, нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай, бичил цэцэрлэг, явган болон дугуйн зам барих чиглэлийн дагуу 5 км дугуйн зам байгуулахаар судалгааг гарган 11 дүгээр хороо Нуурын 14, 15 дугаар гудамжинд 1000м2 явган зам, 541м2 асфальт гүйлтийн зам, 2143м2 бетонон явган зам тус тус хийж гүйцэтгээд байна. Дүүргийн хэмжээнд 16 байршилд 8000 м2 явган замын ажил хийж гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгөөр 19 дүгээр Тахилтын аманд 4,0 тэрбумаар тохижилтын ажил хийж гүйцэтгэхээр зураг төсвийг “Сивил дизайн” ХХК хийж гүйцэтгэн тендер зарлан гүйцэтгэгчээр “Жавхлан хүслэн” ХХК шалгарч газар шорооны ажил 80%, гэрэлтүүлгийн суурь шон тавигдсан, шат хийгдсэн. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 13, 16, 19 дүгээр хороодод 5 байршилд бичил цэцэрлэг, тохижилтын ажлыг “Люкс даймонд” ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. 6 дугаар хороо 62 дугаар байрын хойд талын тохижилтын ажлыг Хот тохижилтын газраас хийж гүйцэтгэн 75м2 явган замын ажил хийж гүйцэтгэсэн. Өрхийн тохижилтын ажлыг дэмжиж жишиг болгох үүднээс 3 хорооны 750м2 талбайд зүлэг суурилуулах ажлыг “Тэцэ” ХХК-тай хамтран 4 өрхөд хар шороо асгах, суурь бэлдэх, зүлэгжүүлэлт суурилуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. “Манай	70
-------	---	-------	----------------------------	----	----	---	----

						хороо-Миний гудамж” аяны хүрээнд шилдэг тохижилттой өрхөөр 15 дугаар хорооны иргэн н.Мөнхцэцэг, шилдэг хог тээврийн байгууллагаар Чингэлтэй дүүргийн “Тохижилт Үйлчилгээ” ХХК, шилдэг хороогоор 11 дүгээр хороо тус тус шалгарч мөнгөн шагналаар шагнуулсан.	
3.3 Үерийн далан суваг, борооны ус болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх, сэргээн засварлах, гэр хороодын гуу жалга бүхий газруудад явган зам, шат, гүүр барьж иргэдийн амьдрах орчныг сайжруулна.							
3.3.1	Арга хэмжээ 5.1. Үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээг шинээр барьж, өргөтгөн шинэчилж, сэргээн засварлана.	1,200.0	Өргөтгөн шинэчилсэн, сэргээн засварласан, шинээр барьсан борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний тоо хэмжээ	11,9 км	12,5км	Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажил” төсөл, арга хэмжээг “Вектор ус дриллинг” ХХК хэрэгжүүлж, 14 үзлэгийн худагтай 655 у/м хөрсний ус зайлуулах шугам, сүлжээний ажлыг хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувь дуусаж комисс ажилласан. Геодези, Усны барилга байгууламжийн газартай хамтран тус дүүргийн 19 дүгээр хороо, Сэтгүүлчдийн төгөл, автобусны буудал 170 у/м шугам, 10ш шүүрт худаг, 7ш үзлэгийн худаг, Зунжин, Номин супер маркетинг автобусны буудал 26 у/м шугам, 4 шүүрт худаг бүхий авто замын борооны ус болон хөрсний ус зайлуулах шугам угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Гүн нуурын арын жалга, Хайлаастын гудамжинд далан барих” төсөл, арга хэмжээг “Вектор ус дриллинг” ХХК хэрэгжүүлэн хоолой тавих, үерийн хамгаалалтын далангийн хавтан	70

						суурилуулах ажлууд хийгдсэн. Хавтан хоорондын бетон дүүргэлтийн ажил хийгдэж байна.	
3.3.2	Арга хэмжээ 5.2. Гэр хороодын гуу жалга бүхий газруудад шат, гүүрэн байгууламж барих, сэргээн засварлах	50,0	Хийгдэх гүүрэн байгууламжийн тоогоор	57 гүүрэн байгууламж, 21 шаттай	58 гүүрэн байгууламж, 22 шаттай	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Эко ногоон байгууламж” төсөл арга хэмжээний хүрээнд Согоот 59 дүгээр гудамжны гуу жалга бүхий газарт 8 /ум гүүрэн байгууламжийг “Гарден сити” ХХК хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Дэнжийн 1000-ын Цагаан байрны уулзвараас Хүчит шонхор захын уулзвар хүртэлх туслах замын өргөтгөл” төсөл, арга хэмжээг “Экспресс зам” ХХК хэрэгжүүлэн ажилласан. Уг төсөл арга хэмжээний хүрээнд Дэнжийн 1000-н 1 дүгээр суваг дээр байрлах 4 ширхэг явган хүний гүүрэн байгууламжийн засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 19 дүгээр хороо, Дээд салхит 2 дугаар гудамжны гуу жалга бүхий газарт "Гудамж сайжруулах" төсөл, арга хэмжээний хүрээнд 1 у/м явган шатыг “Тэгш буян зам” ХХК хийж гүйцэтгэсэн. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 18 дугаар хороо, Яргайт 43 дугаар гудамжны гуу жалга бүхий газарт “Гудамж сайжруулах” төсөл, арга хэмжээний хүрээнд 2 у/м явган шатыг “Ай Эм Ди” ХХК хийж гүйцэтгэсэн. Дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт 4м урттай явган шат хийх ажлыг дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК-иар гүйцэтгүүлснээр Ерөнхий	90

						боловсролын 39 дүгээр сургуулийн сурагчид болон дүүргийн Спорт хороогоор үйлчлүүлэгчдийн орчин нөхцөл сайжирсан.	
3.4 Эрчим хүчний хүчдэлийн уналттай болон цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг цахилгаанаар хангах ажлыг үе шаттай судалж, хэрэгжүүлнэ.							
3.4.1	Арга хэмжээ 5.3. Төмөр бетон гүүрний байгууламжийг шинээр барьж, өргөтгөж, шинэчилнэ	30,0	Замын байгууламжийн тоогоор	Төмөр бетон 13 ширхэг авто гүүрэн байгууламжтай	Төмөр бетон 14 ширхэг авто гүүрэн байгууламж	Дүүргийн 12 дугаар хороо, Булгийн 16 дугаар гудамжны жалга дээрх төмөр бетон гүүрний ажлыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10,6 метр урт, 7 метр өргөнтэй төмөр бетон гүүрэн байгууламжийн ажлыг “Тэнүүн хас сар” ХХК 2021 онд хийж гүйцэтгэн 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр улсын комисс ажиллан үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авсан. Дүүргийн 24 дүгээр хороо, Майхан толгой 2-т байрлах авто гүүрэн байгууламж нурснаас 200 гаруй айл өрхийн орц гарц хаагдсан байдалтай байгаа тул Нийслэлийн Замын хөгжлийн газарт 3/716 тоот албан бичиг хүргүүлсний дагуу Нийслэлийн Замын сангийн хөрөнгө оруулалтаар 10 метр өргөн, 4,8 метр урттай төмөр бетон гүүрэн байгууламжийг Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан.	90
3.5 Агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилго бүхий “Ногоон дүүрэг-2024” арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
3.5.1	Арга хэмжээ 8.2. Дүүргийн хэмжээний ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	-	Тарьж ургуулсан мод, бут, сөөгний тоо	2014-2022 онд 358745 ширхэг мод, бут, сөөг тарьж ургуулсан.	20000 ширхгээс доошгүй мод, бут, сөөг тарьж ургуулсан байна.	Хавар болон намрын мод тарилтыг 16 дугаар хороо “Хоймор хайрхан” амралтын газар, 19 дүгээр хороо Хайрхан хөгжлийн төвд мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар ногоон төлөвлөлтийн зураг төслийн дагуу 3 төрлийн 3000 мод (нарс, хайлаас, улиас) тарьсан.	100

						“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Ногоон хот-Иргэний оролцоо уриатай намрын мод тарих аяныг Дээд Салхитын аманд Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албад, 1-24 дүгээр хороод, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд болон “Тохижилт Үйлчилгээ” ХХК-н хамт олон хамтран 570 хүн 2300 нарс, хайлаас, голт бор, тус тус тарьж цэнэг усалгаа хийсэн. Дүүргийн 16 дугаар хороо Хайлаастайн аманд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд Хоймор хайрхны амралт ОНӨТҮГ-ын албан хаагчид нийт 450 албан хаагч 1600 хайлаас нарс тарьж цэнэг усалгаа хийсэн. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 13, 16, 19 дүгээр хороодод 5 байршилд бичил цэцэрлэг, тохижилтын ажлыг “Люкс даймонд” ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. 6 дугаар хороо 62 дугаар байрын хойд талын тохижилтын ажлыг Хот тохижилтын газраас хийж гүйцэтгэн 75м2 явган замын ажил хийж гүйцэтгэсэн. Өрхийн тохижилтын ажлыг дэмжиж жишиг болгох үүднээс 3 хорооны 750м2 талбайд зүлэг суурилуулах ажлыг “Тэцэ” ХХК-тай хамтран 4 өрхөд хар шороо асгах, суурь бэлдэх, зүлэгжүүлэлт суурилуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. “Манай хороо-Миний гудамж” аяны хүрээнд шилдэг тохижилттой өрхөөр 15 дугаар хорооны иргэн н.Мөнхцэцэг,	
--	--	--	--	--	--	---	--

						шилдэг хог тээврийн байгууллагаар Чингэлтэй дүүргийн “Тохижилт Үйлчилгээ” ХХК, шилдэг хороогоор 11 дүгээр хороо тус тус шалгарч мөнгөн шагналаар шагнуулсан.	
3.5.2	Арга хэмжээ 8.4. Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор Улс, Нийслэл, Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээг дэмжин ажиллана	Улс, нийслэл ийн төсөв	Гэр хорооллын айл өрхөд эко жорлон нэвтрүүлэх	1000 айл өрхийг төсөлд хамрагдуулах	Гэр хорооллын айл өрхөд эко жорлон нэвтрүүлснээр лаг хаягдлыг соруулах хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх	Улсын төсвийн хөрөнгөөр 2022-2023 он дамжин хэрэгжих 550 сая төгрөгийн төсөвтэй Дүүргийн 7, 17, 18, 19 дүгээр хорооны нийт 400 айл өрхийн нүхэн жорлонг шинэчлэх ажил 2022 оны 09 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд нийт 400 айлын нүхийг ухаж бэлтгэн кольцо суурилуулах, бүхээг хийх ажил удаашралтай байгаа тул Байгаль, орчин аялал жуулчлалын яаманд 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 2/2977 тоот албан бичгээр ажлыг эрчимжүүлэх талаар санал хүргүүлсэн болно. Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор Барилга хот байгуулалтын яамнаас Улсын төсвийн хөрөнгөөр 2023-2024 онд он дамжин нийт 4,4 тэрбум төгрөгөөр Ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоогүй гэр хорооллын айл өрхүүдийн нүхэн жорлонг сайжруулах айл өрхийн байшингийн дулаалга хийх цогц ажлыг хэрэгжүүлээд байна. Үүнд: Чингэлтэй дүүргийн 7 болон 12-19 дүгээр хорооны нийт 150 айл өрхийн хамрагдан 2023 оны 08 дугаар бүрэн хэрэгжиж дуусан комисс хүлээд аваад байна.	90
3.6 Дүүргийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, цэцэрлэгт хүрээлэн, ойжуулалт, ногоон байгууламжийг бүтээн байгуулна.							
3.6.1	Арга хэмжээ Нийтийн эзэмшлийн ногоон	700.0	Нийтийн эзэмшлийн ногоон	141666 ширхэг мод, бут,	Суурь түвшингийн 10-с	Дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Ж.Самбуугийн гудамж, 1 дүгээр хороо, Жуулчны гудамж зэрэг	100

	байгууламжийг нэмэгдүүлнэ.		байгууламжийг нэмэгдүүлсэн хувь	сөөг тарьж ургуулсан.	доошгүй хувьд нэмэгдүүлнэ.	байршлуудад 15000 ширхэг хайлаас мод, дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Тусгаар тогтнолын талбайд 4000 ширхэг нэг наст цэцгийг тарьсан. Дүүргийн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалт, цэнэг усалгааг Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК хариуцан ажиллаж нийт 72857м2 талбайн цэвэрлэгээ арчилгааг өдөр тутамдаа хийж, 138 рейсээр 1380 тонн ус тээвэрлэн хаврын цэнэг усалгаа, мод бутны ургалт сайжруулах зорилгоор 863 ширхэг мод, бутны тогоо, 220 у/м ургамлан хашлаганд шуудуу гаргах, 233 ширхэг модыг шохойдох ажлыг хийж гүйцэтгэсэн. Хавар, намрын мод тарилтын хүрээнд 19 дүгээр хороо Дээд Салхитын аманд Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, 1-24 дүгээр хороод, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд болон “Тохижилт Үйлчилгээ” ХХК-ийн хамт олон хамтран 950 хүн 600 нарс, 3500 хайлаас, голт бор, тус тус тарьж цэнэг усалгаа хийсэн. Дүүргийн 16 дугаар хороо Хайлаастайн аманд Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгүүд Хоймор хайрхны амралт ОНӨТҮГ-ын албан хаагчид нийт 450 албан хаагч 1600 хайлаас нарс тарьж цэнэг усалгаа хийсэн.	
3.6.2	Цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, ногоон байгууламж,	60,000.0	Цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгийн	2017-2022 онд нөхөн сэргээлт ойжуулалт	Суурь түшингийн 10-с доошгүй	Цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 5 дугаар хороо Тусгаар тогтнолын талбайд нэг наст ургамал	90

	ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.		ногоон байгууламж, нөхөн сэргээлт, ойжуулалтыг нэмэгдүүлсэн хувь	аар 119514 ширхэг мод, бут, сөөг, бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнд 51324 ширхэг мод, бут, сөөг тарьж ургуулсан.	хувьд нэмэгдүүлн э.	буюу Хун цэцэг-4,000 ширхэг, 4 дүгээр хороо хороо Самбуугийн гудамжинд Хун цэцэг-60 ширхэг, 1 дүгээр хороо Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэнд Олон наст цэцэг тарихаар төлөвлөн ажиллаж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд болон он дамжин 5, 8, 12, 13, 14, 16, 17, 18, 19 дүгээр хороодод нийт 1,3 тэрбум төгрөгөөр 12 бичил цэцэрлэгүүдэд засвар шинэчлэлтийн ажил хийгдэж дууссан. Дүүргийн 11 дүгээр хороо Нуурын 14, 15 дугаар гудамжинд 1000м2 явган зам, 541м2 асфальт гүйлтийн зам, 2143м2 бетонон явган зам тус тус хийж гүйцэтгээд байна. Дүүргийн хэмжээнд 16 байршилд 8000 м2 явган замын ажил хийж гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгөөр 19 дүгээр хороо Тахилтын аманд 4,0 тэрбумаар тохижилтын ажил хийж гүйцэтгэхээр зураг төсвийг “Сивил дизайн” ХХК хийж гүйцэтгэн тендер зарлан гүйцэтгэгчээр Жавхлан хүслэн ХХК шалгарч газар шорооны ажил 80%, гэрэлтүүлгийн суурь шон тавигдсан, шат хийгдсэн. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2 дугаар хороо БХ 30 болон 28 дугаар байрны тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 15 дугаар хороо 72 дугаар сургуулийн хойд талд 150м2 тохижилтын ажлыг “Анте” ХХК хийж гүйцэтгэсэн. Мөн 6 дугаар хороо 62 дугаар байрын хойд талын тохижилтын ажлыг Хот	
--	--	--	--	---	---------------------------	---	--

						тохижилтын газраас хийж гүйцэтгэн 75м2 явган замын ажил хийж гүйцэтгэсэн. Өрхийн тохижилтын ажлыг дэмжиж жишиг болгох үүднээс 3 хорооны 750м2 талбайд зүлэг суурилуулах ажлыг “Тэцэ” ХХК-тай хамтран 4 өрхөд хар шороо асгах, суурь бэлдэх, зүлэгжүүлэлт суурилуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	
ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО БЭХЖҮҮЛЭХ /БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД/							
3.1 МЭРГЭШСЭН, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА							
3.1 Төрийн албаны үйл ажиллагаа, бүтээмж, чанарын удирдлагын нэгдсэн систем, хяналт хариуцлагын тогтолцоог шинэ шатанд гаргаж, төрийн албан хаагчийн ажиллах орчин нийгмийн баталгааг хангах зорилготой “Хүний нөөц, нийгмийн баталгаа 2024” арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.							
3.1.1	Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг болон Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг Дүүргийн цахим хуудсанд байршуулах	-	Мэдээний тоо	13	15	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах ажлын хүрээнд дүүргийн http://www.chingeltei.gov.mn/ цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал” цэсэд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээ, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороо, 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, байгууллагын 2023 онд зохион байгуулагдах сургалтын нэгдсэн төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын “Журам шинэчлэн батлах тухай” 301 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин	90

						үнэлэх журмыг байршуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн нярав, жолооч, хорооны зохион байгуулагч, нийгмийн ажилтны нээлттэй ажлын байрны зарын энэ онд нийт 11 удаа дүүргийн сайтад байршуулсан.	
3.1.2	Хүний нөөцийг хөгжүүлж, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	1064	1300	Ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор 2023 онд дараах сургалтуудад дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг хамруулсан. Үүнд: 1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан “Төрийн албанд анх томилогдсон албан хаагчдад зориулсан 40 цагийн чиглүүлэх багц сургалт”-д нийт 4 албан хаагчийг хамруулсан. 2. Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо нь НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй “Хариуцлагатай сонгогч” сургалтад Засаг даргын Тамгын газрын нийт 3 албан хаагчийг 2023 оны 03 дугаар сард хамруулсан. 3. Удирдлагын академийн “Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалт”-д Засаг даргын Тамгын газрын 1 албан хаагчийг 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай хамруулсан. 4. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй” сургалтад дүүргийн Засаг даргын	100

						Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн нийт 2 албан хаагчийг хамруулсан. 5. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайлангийн дэд системд хандах” сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн нийт 3 албан хаагчийг хамруулсан. 6. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Эдийн засаг хөгжлийн яамнаас 2023 оны 05 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулсан “Үр дүнд суурилсан удирдлага” сэдэвт сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийт 7 албан хаагчийг хамруулан ажилласан. 7. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс дүүргийн хороодын албан хаагчдыг чадавхжуулах сургалтад 2023 оны 05 сарын 22-ны өдрөөс 06 сарын 16-ны өдрүүдэд дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарыг үе шаттайгаар хамруулан ажилласан. 8. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2023 оны 07 сарын 01-ний өдрөөс 08 сарын 11-ний өдрүүдэд зохион байгуулсан “MS Excel программын хэрэглээ” анхан болон дунд шатны сургалтад Иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлт, тогтоол шийдвэрийн	
--	--	--	--	--	--	---	--

						биелэлт хариуцсан мэргэжилтнийг хамруулсан. 9. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 08 дугаар сарын 28, 30-ны өдрүүдэд зохион байгуулсан “Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” сэдэвт сургалтад Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын нийт 30 албан хаагчийг хамруулсан. 10. Нийслэлийн Улаан загалмайн зөвлөлөөс Төр-Улаан загалмайн хамтын ажиллагааг уялдуулах, туршлага солилцох сургалтад дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дарга, Улаан загалмайн хороон дарга, дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга нарыг тус тус хамруулсан. 11. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын “Харилцан суралцах арга зүй” сургалтад Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, хороодын зохион байгуулагч нарыг хамруулан ажилласан. 12. 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр “Үр дүнд суурилсан төрийн захиргааны асуудлууд” сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн дарга, Засаг даргын дэргэдэх харьяа хэлтэс, албадын дарга нарыг хамруулан ажилласан.	
--	--	--	--	--	--	---	--

3.1.3	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, “Хүний нөөц, нийгмийн баталгаа 2024” арга хэмжээнд хамрагдуулан ажиллах	-	Батлагдсан хөтөлбөрт хамрагдсан албан хаагчдын тоогоор	18	20	2023 оны байдлаар “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээ, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу гэр бүлийн гишүүний болон өөрийн эмчилгээний зардалд 8 албан хаагчид 14,549,927 төгрөг, гэр бүл, төрөл садны хүн нас барахад 7 албан хаагчид 11,550,000 төгрөг, амаржсан 9 албан хаагчид 8,967,522 төгрөг, шинээр гэр бүл болсон 5 албан хаагчид 5,240,912 төгрөг, сургалтын зардалд 2 албан хаагчид 5,356,000 төгрөгийг тус тус олгосон байна.	100
3.1.4	Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, харилцаа хандлагыг сайжруулан ажиллах	-	Ёс зүйн зөрчлийн буурсан тоон мэдээний дүнгээр	20	15	Албан хаагчдын цагийн бүртгэлийг цаг бүртгэлийн системээс татан авч, удирдлагад танилцуулан ажиллаж байгаа бөгөөд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Дотоод журмын 12.2 дахь хэсгийг үндэслэн ажлаас хоцорсон 1 минутыг 100 төгрөгөөр тооцож, 60 минутаас дээш хоцорсон тохиолдолд 1 минутыг 500 төгрөгөөр тооцон цалингаас суутгах арга хэмжээг авч ажиллаж байна. 2023 оны онд ёс зүйн зөрчилтэй холбоотой 4 өргөдөл, гомдол ирсэн ба холбогдох албан хаагчид сонсох ажиллагаа явуулахаар мэдэгдэх хуудас хүргүүлж, хариу тайлбарыг авч сонсох ажиллагааг хийсэн. Хорооны 1 албан хаагчид “Сануулах” сахилгын шийтгэл ногдуулж, 2 Засаг даргад Зөвлөмж хүргүүлэн ажилласан. Ёс зүйн болон сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	90

3.2 Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, дүүргийн хөгжлийн талаарх үр ашигтай санал, санаачилгыг дэмжиж ажиллана.

3.2.1	Нийслэл, дүүргийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг, даалгаврыг холбогдох хэлтэс, албадад хүргүүлэн хэрэгжилтийг тухай бүр тооцон ажиллах	-	Үйл ажиллагаа-ны хэрэгжилт хувиар	85%	85%	Тайлангийн хугацаанд 35 удаагийн Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн 262 үүрэг даалгаврын хэрэгжилтэд тухай бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох газарт хүргүүлэн ажилласан.	100
3.2.2	Дүүргийн Засаг даргын Тамгын газар 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	80%	90%	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүлсэн.	100
3.2.3	Байгууллагын архивын 2022 оны цаасан болон тусгай төрлийн баримтыг archivedoc системд шилжүүлнэ.	-	Баримтын хуудасны тоогоор	2231 хуудас	2231 хуудас	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2.6 хэсэгт заасны дагуу дүүргийн Засаг даргын - “А”Захирамж 5 хадгаламжийн нэгжийн 408 баримтын 1029 хуудас, - “Б” Захирамж 1 хадгаламжийн нэгжийн 192 баримтын 247 хуудас, Тамгын газрын даргын - “А”Тушаал 4 хадгаламжийн нэгжийн 365 баримтын 807 хуудас, - “Б” Тушаал 3 хадгаламжийн нэгжийн 369 баримт, 559 хуудас	100

						Нийт 13 хадгаламжийн нэгжийн 1334 баримт, 2642 хуудас баримтыг дугаарлаж, скайнердаж, дотоод товёг, ашиглалтын хуудас, баталгааны хуудас, хавтаслаж, нүүр бичилт хийн нягтлан шалгаж https://arch.ulaanbaatar.mn/ программын “Archive eDoc” системд тодорхойлон бичилт хийж цахимжуулж тусгай төрлийн баримт үүсгэн DVD-д хуулж нийслэлийн Архивын газарт акт үйлдэн хүлээлгэн өгсөн.	
3.2.4	Баримтыг нягтлан шалгах комиссын хурал зохион байгуулах.	-	БНШК-ын хурал зохион байгуулсан тоогоор	1 удаа зохион байгуулна	2 удаа зохион байгуулах	Байгууллагын “Баримт нягтлан шалгах комисс”-ын хуралд асуудал хэлэлцүүлж, хэрэгжилтийг хангаж ажилласан.	100
3.2.5	Засаг даргын Тамгын газар ирсэн, явсан албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг улирал, хагас, бүтэн жилээр гарган тайлагнаж, удирдлагыг мэдээллээр хангаж, шийдвэрлэж хугацаа дууссан, зөрчил тооцогдсон албан бичгийн мэдээг тогтмол гаргаж танилцуулах	-	Засаг даргын Тамгын газрын хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийг ашиглалт сайжирч, удирдлагад тайланг танилцуулсан тоогоор	4	4	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газарт Edoc.ub.gov.mn нэгдсэн системээр нийт ирсэн 6554 албан бичиг бүртгэж. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас нийт 2765 албан бичиг явсан. Стандартын зөрчлийг тухай бүр арилгаж үлдсэн хувийг хадгаламжийн нэгж үүсгэж ажилласан.	100
3.2.6	Засаг даргын Тамгын газрын нэгдсэн систем дэх Албан бичгийн шийдвэрлэлт	-	Засаг даргын Тамгын	102	90	Хяналтын ажлын хүрээнд нийт 6554 албан бичгийн шийдвэрлэлттэй танилцаж, хянасан-5443, баталсан-5213, шийдвэрлэлт хангалтгүй-321 албан бичгийн шийдвэрлэлтийг цуцлан, 47 албан хаагчид зөрчил бүртгэн, Албан	90

	Системийн ашиглалт Дотоод зохион байгуулалт Стандартын хяналтыг өдөр тутам хийж хангалтгүй тохиолдолд зөрчил тооцон, бүртгэлцүүлж, заавар зөвлөгөө өгч, давтан зөрчил гаргасан алба хаагч нарт арга хэмжээ тооцох саналыг Архивын албан хэрэг хөтлөлтийн албан тушаалтанд санал гаргах, тайлагнаж ажиллах		газрын хэмжээнд албан хэрэг хөтлөлт стандартын дагуу хөтлөгдөж, албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил багасна			хаагчид тухай бүр ажлын байран дээр болон утсаар мэргэжил арга зүйн заавар өгч, шаардлага тавьж ажилласан.	
3.2.7	Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад нэгдсэн сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, байгууллагад хөтлөгдөж байгаа баримт бичиг стандартын дагуу үнэн зөв хөтлөгдөж, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн		Заавар, зөвлөгөө өгсөн байгууллага, албан хаагчийн тоо	Нийт давхардсан тоогоор 370 байгууллагын 557 албан хаагчдад 17 удаагийн давтамжтай мэргэжил арга зүйн сургалт зохион	Хөмрөг үүсгэгч байгууллага болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын 100 албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтийн	Баримт бичгийн стандарт, Албан хэрэг хөтлөлтийн журам, Албан бичгийн шийдвэрлэлт, анхаарах асуудлууд, Хэвлэмэл хуудасны нэршил, хаягийн бичвэр сургалтуудыг танхим, хэлбэрээр нийт байгууллагын 84 албан хаагчид 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, нэгдсэн арга зүйгээр хангаж ажилласан.	90

	стандартын мэдлэгтэй болсон			байгуулсан .	чиглэлээр мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөх		
3.2.8	Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтаар нөхөн бүрдүүлэлтийн ажлыг стандартын дагуу бүрдүүлж авч, байнга, түр, 70 жилийн данс бүртгэлийг эцэслэн гаргаж байгууллагын дэргэдэх БНШК-ын хурлаар оруулан хэлэлцүүлж батлуулсан байна.	-	Хадгаламжийн нэгжийн тоогоор	745 хадгаламж ийн нэгжээр баяжилт хийгдсэн.	745 хадгаламж ийн нэгжээр баяжилт хийнэ.	<u>Захирамжлалын цахим баримт:</u> 2013-2020 оны Захирамжлалын 78 хадгаламжийн нэгжийн 8,675 баримтын 17,121 хуудас цахим баримтын бүртгэл үйлдэн Нийслэлийн архивын газарт нийт 16 ширхэг CD болон DVD дээр хуулж хүлээлгэн өгсөн. <u>Зураг төслийн баримт:</u> 2009-2020 оны 166 хадгаламжийн нэгжийн 8093 хуудас Зураг төсөл техникийн баримтын бүртгэл үйлдэв. <u>Хууль, зүйн үндэслэл:</u> Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9 дэх заалтын хүрээнд, “нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын архивд 8 жил хадгалсны дараа харьяалах төрийн архивд шилжүүлнэ”, “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 13.9.5-д “Төрийн архивд баримт шилжүүлэхэд байнга, 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах баримтын жагсаалтыг төрийн Архивын дэргэдэх БНШАЗК- (баримт нягтлан шалгах арга зүйн комисс)-ын хурлаар хянуулж батлуулсан байна” гэж заасны дагуу нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК (баримт нягтлан шалгах арга зүйн комисс)-ын 04 дүгээр хурлаар данс, бүртгэл, жагсаалтыг	90

						хэлэлцүүлж 2008-2020 оны баримтад иж бүрэн нягтлан шалгалт, техник боловсруулалтын ажил хийсний үр дүнд дараах хадгаламжийн нэгжийн бүртгэлийг үйлдсэн. Мөн 2013-2020 оны Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлийг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байгууллагын дэргэдэх БНШК-ын 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцүүлж, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Нийслэлийн архивын газрын Сансарын фондруу зөөвөрлөн 1-728 дугаар бүхий хадгаламжийн нэгжийн 114237 (нэг зуун арван хоёр мянга дөрвөн мянга хоёр зуун гучин долоо) хуудас баримтыг хүлээлгэн өгсөн.	
3.2.9	Тоон гарын үсэг ашиглах, цахим албан хэрэг хөтлөлтийг Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтсийн дарга, хороодын Засаг дарга нарт хэрэглэж, хэвшүүлэх	-	Шинээр томилогдсон дарга нарын тоон гарын үсэг авсан тоо	4	4	Дүүргийн хэмжээнд нэгдсэн программ ашигладаг нийт 106 байгууллагын 120 эрх бүхий албан хаагчид тоон гарын үсэг ашиглан, тоон гарын үсгээр баталгаажсан баримт бичиг солилцож байна. Үндэсний дата төвтэй байгуулсан Тоон гарын үсгийн гэрчилгээний хугацаа дууссантай холбогдуулан Засаг даргын Тамгын газар 13, хороо 22, дэргэдэх хэлтэс, алба 20, сургууль 18, цэцэрлэг 37 нийт 110 албан тушаалтан шинээр Ньюкомпасс, “Тридум-кэй” ХХК-тай гэрээ байгуулан гэрчилгээ авсан.	90
3.2.10	Иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдол, санал хүсэлтийг хуулийн					Өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэхдээ иргэний асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх холбогдох баримт бичгийг хавсаргах талаар дүүргийн Засаг даргын дэргэдэх харьяа байгууллагууд, Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын дарга нарт анхааруулж, 2023 онд	90

	хугацаанд шийдвэрлэх, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах	тоон				давхардсан тоогоор нийт 100 гаруй байгууллагад албан бичиг хүргүүлж ажиллалаа. Мөн дүүргийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 3516 өргөдөл ирснээс 3418 өргөдлийг эцэслэн шийдвэрлэж, шийдвэрлэх шатанд буюу судлагдаж байгаа 98 өргөдөл байна. Үүнээс хариу өгсөн хэлбэр нь: Иргэнтэй биеэр уулзаж хариу хүргүүлсэн-411, Программ хангамж + Мессеж + Албан бичгээр хариу өгсөн-665, Программ хангамж + Мессежээр хариу өгсөн-501, Программ хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн-1844, Шийдвэрлэсэн байдал нь: Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл-2691, Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл-700, Бусад хэлбэрээр 27 өргөдлийн хариуг шийдвэрлэн ажилласан байна. Дүүргийн хэмжээнд 2023 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг дүгнэж үзэхэд: Санал 18-аар буюу 47 хувиар, Талархал 65-аар буюу 45 хувиар, Гомдол 216-аар буюу 23 хувиар тус тус өссөн. Мэдэгдэл 6-аар буюу 60 хувиар, Хүсэлт 786-өөр буюу 33 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Дүүргийн хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийж үзэхэд Талархал 45 хувиар өссөн нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тухай, Иргэний бүртгэлийн тухай, Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай зэрэг байна. Иргэдээс ирсэн гомдол 23 хувиар өмнөх оноос өссөн үзүүлэлт байна. Дүүргийн	
--	--	------	--	--	--	---	--

						өргөдөл гомдлын шийдвэрлэлийн дундаж хугацаа өнгөрсөн оныхоос 4 хоногоор буюу 12 хоног байснаас 8 хоног болон буурсан эерэг үзүүлэлттэй байна.	
3.2.11	Дээд байгууллагын ирүүлсэн тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэж дээд шатны байгууллагад хүргүүлэх	-	Биелэлтийн хувиар	91.3%	92%	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар 2021 онд батлагдсан дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй 9 арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн биелэлтийг гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж, ИТХ-ын хурлын хороодын хуралдаанд танилцуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 3/2731, Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 01-06, 09, 10, 13, 15, 17 дугаар тогтоолууд, Зөвлөлийн 2023 оны 05 дугаар тогтоол болон ээлжит 09 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг, чиглэлийн биелэлт, түүний явцын талаарх мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын дагуу боловсруулж Засаг даргын Тамгын газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ний өдрийн 3/2893 дугаарын албан бичгээр Тамгын газрын хэлтэс, албадын дарга нарт хүргүүлэн ажилласан. Дээрх албан албан бичгүүдийн хүрээнд ирүүлсэн биелэлт хэрэгжилтийг нэгтгэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст үнэлгээ хийлгэхээр хүргүүлээд байна.	90
3.2.12	Төрийн дээд одон медаль, Засгийн газар, яамд, дүүргийн Засаг	-	Шагнуулсан иргэдийн тоо	438	500	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн төрөл, түүнийг	100

	даргын шагналаар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, материалыг холбогдох байгууллагад уламжлах.					олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-ын дагуу дүүргийн нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгжээс Засгийн газрын болон яамдын шагналаар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжин тайлант хугацаанд ХХААХҮЯ-41, ЗТХЯ-2, СЯ-45, ЭМЯ-16, БХБЯ-1, НЗД-ын шагналд 26, ХНХЯ-9 албан хаагчийг дэмжин, холбогдох материалыг хүргүүлсэн. Үүнээс: Сангийн яам, Барилга хот байгуулалтын яам, Зам тээвэр хөгжлийн яамны шагналын материалуудыг тус байгууллагын шагналын программд бүртгэсэн.	
3.2.13	Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлыг зохион байгуулах	-	Зохион байгуулагдсан хурлын тоогоор	3	3	Дүүргийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааныг 2023 онд нийт 3 удаа зохион байгуулж, 7 асуудлыг хэлэлцсэн. Мөн дүүргийн Засаг даргын Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар захирамжаар шинэчлэн баталж, зөвлөлийн хуралдааны журмыг тодотгон нэмэлт өөрчлөлт оруулсан.	100
3.2.14	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын "Нэг цонхны үйлчилгээ"-ээр төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, үйлчилгээний тасралтгүй байдал, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж, иргэдэд мэдээ мэдээллийг хүргэнэ.	-	Иргэдэд үйлчилсэн тоогоор	10,000		Улсын бүртгэлийн чиглэлээр төрийн зорилт, чиг үүргийг хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай үйлчилгээг нийтэд хүргэх зорилго, үйл ажиллагааны хүрээнд Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэлийн үйлчилгээний 4 төвийг шинээр байгуулж, одоогийн байдлаар 2 төв, 4 цэг ("Чингэлтэй" төв, "Сэлбэ" Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төв, "5 буудал" цэг, "Дэнжийн 1000" цэг, "Төв шуудан" цэг, "Гадаадын хөрөнгө оруулалт" цэг)-ээр дамжуулан үйлчилгээг хүргэж байна.	90

						Төвүүд болон цэгүүдийг нэгдсэн бодлого, удирдлага зохицуулалтаар хангаж, үйл ажиллагааг хэвийн явуулах, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд тогтмол хяналт тавих, нөхцөл байдалд шинжилгээ хийх, үйл ажиллагааг улам сайжруулах, төрийн байгууллагуудтай уялдуулах, дэмжлэг үзүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 88451 иргэнд, үүнээс “Чингэлтэй” төв 67225, “Сэлбэ төв” 4130, “Дэнжийн 1000” цэг 7304, “5 буудал” цэг 8052, “Төв шуудан” 1740 иргэнд тус тус үйлчилгээ үзүүлсэн байна. Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр 16701 иргэн, хуулийн этгээдэд 11 төрлийн үйлчилгээг, үүнээс хэлтэс 14319, “Сэлбэ төв” 811, “Дэнжийн 1000” цэг 380, “5 буудал” цэг 1191 иргэнд тус тус үзүүлсэн байна. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 11 төрлийн үйлчилгээг 15143 хуулийн этгээдэд, үүнээс хэлтэс 14841, “Сэлбэ” төв 54, “Дэнжийн 1000” цэг 107, “5 буудал” цэг 141 бүртгэл хийж төрийн үйлчилгээг шуурхай, ил тод үзүүлж иргэд, хуулийн этгээдийн итгэлийг хүлээсэн.	
3.2.15	Дүүргийн Нэг цонхны үйлчилгээ болон 1-24 дүгээр хороодын Нэг цэгийн үйлчилгээгээр дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын “Нээлттэй хаалганы	-	Нэг цэгийн үйлчилгээний тоо	1	3	Дүүргийн 1-24 дүгээр хороодын нэг цэгийн үйлчилгээгээр нийт 54,650 иргэнд үйлчлүүлж 54,112 иргэний асуудлыг шийдвэрлэсэн. Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор 39 байгууллагын 440 төрлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй олгох Төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” цэгийг Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны цогцолбор байр, “Нэг цонхны	90

	өдөрлөг"-ийг зохион байгуулан ажиллах					үйлчилгээ", "Төв шуудан" зэрэг 3 газарт нээн үйлчилгээ үзүүлж байна.	
3.3 Засаг захиргааны анхан шатны нэгж хороог бэхжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.							
3.3.1	Нийслэлийн "Шилдэг хороо, Хэсгийн ахлагч нарын шилдэг баг" шалгаруулах болзолт уралдаан, "Манай хороо-Миний гудамж аян"-д 1-24 дүгээр хороодыг удирдлага арга зүйгээр ханган амжилттай оролцуулах	-	Аянд оролцож шалгарсан хороо, хэсгийн ахлагчийн багийн тоогоор	Шалгарсан 1 2 хэсгийн ахлагчийн баг	1 хороо 2 хэсгийн ахлагч баг шалгарсан байх	Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Нийслэлийн шилдэг хороо-шилдэг хэсгийн ахлагчийн шилдэг баг шалгаруулах болзолт уралдаан зарлах тухай" А/461 дүгээр захирамжийн хэрэгжилтийн хүрээнд 1-24 дүгээр хороод тус бүр ажлын төлөвлөгөө боловсруулан биелэлтийг ханган ажилласан. 2023 оны "Нийслэлийн шилдэг-Хэсгийн ахлагч нарын шилдэг баг" шалгаруулах болзолт уралдааны ✓ Тусгай байранд: Д.Уянга даргатай 11 дүгээр хороо ✓ Хэсгийн ахлагч нарын шилдэг баг тусгай байранд: Г.Энхтөгс ахлагчтай 13 дугаар хорооны Хэсгийн ахлагч нарын баг тус тус шалгарсан. ✓ Шилдэг зам талбайн цэвэрлэгээний байгууллага /тусгай байр/ "Найши трэйд" ХХК ✓ "Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ" ХХК шилдэг хог тээврийн байгууллага /тэргүүн байр/ ✓ "Шилдэг өрх-гэр хороо" гуравдугаар байрт 15-р хорооны иргэн Ц.Мөнхсайхан нар тус тус шалгарсан.	100
3.3.2	Дүүргийн 1-24 дүгээр хороодын 220 хэсгийн ахлагч	Цалин хөлс	Урамшуулал олгосон хэсгийн ахлагчийн тоо	196	220	Дүүргийн 1-24 дүгээр хороодын хэсгийн ахлагч нарын 1-11 дүгээр сарын урамшууллыг "Хэсгийн ахлагч нарын ажиллах журам", "Хөлсөөр ажиллах гэрээ"-ний шалгуур үзүүлэлтийн дагуу хороодын Засаг дарга нарын үнэлгээг	100

	нартай “Хөлсөөр ажиллах гэрээ”-г байгуулан, хорооны засаг даргын үнэлгээг үндэслэн хагас, бүтэн жилээр дүгнэж, урамшуулал олгуулах					харгалзан 218 хэсгийн ахлагч нарт урамшууллыг сар бүрийн 20-ны өдөр олгож ажилласан. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 86 дугаар тогтоол, “Хэсгийн ахлагч нарын ажиллах” журмыг үндэслэн Хэсгийн ахлагч нарын хөлсөөр ажиллах гэрээг шинэчлэн батлуулж, дүүргийн 1-24 дүгээр хороодын 218 хэсгийн ахлагч нартай хөлсөөр ажиллах гэрээг байгуулж, эхний хагас жилийн байдлаар хэсгийн ахлагч нарын ажлын үзүүлэлтийг харгалзан 213 хэсгийн ахлагчид 167,805,000 сая төгрөгийн урамшуулал олгосон. Хөлсөөр ажиллах гэрээний жилийн эцсийн тайлан мэдээг нэгтгэж, үнэлсэн ба 2023оны 12 дугаар сарын 20-нд урамшуулал, үр дүнг олгохоор ажиллаж байна.	
3.3.3	Дүүргийн 1-24 дүгээр хороодын 220 хэсгийн ахлагчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулан, мэдлэг ур чадварыг дээшлүүлж зөвлөмж өгөх, харилцан туршлага судлуулах ажлыг зохион байгуулах	-	Цахим систем нэвтэрсэн хэсгийн ахлагчийн тоогоор Үйлчилгээ үзүүлсэн тоо хувь			Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас 1-24 дүгээр хороодын хэсгийн ахлагч нарын бүтээлч ажлын тайланг танилцуулах, харилцан туршлага солилцох, Цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээллийг хэсгийн ахлагч нарт хүргэж нэгдсэн мэдээллээр хангах, чиглэлээр 1-24 дүгээр хороодын Хэсгийн ахлагч нарын нэгдсэн уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж, нийт 218 хэсгийн ахлагчийг хамруулсан. Уулзалтаар Хэсгийн ахлагч нар эрүүл мэндийн үзлэгт хамрагдах хүсэлт гаргасан тул дүүргийн Эрүүл мэндийн төвтөй хамтран 2023 оны 05 дугаар сард Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаагүй 190 хэсгийн	90

						ахлагчийг хуваарийн дагуу үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан.	
3.4 Нутгийн захиргааны байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангаж, цахим засаглалыг хөгжүүлнэ.							
3.4.1	Орчны тохижилт, бүтээн байгуулалт бусад ажил арга хэмжээнд хэвлэл мэдээллийн байгууллагуудыг зохион байгуулж, мэдээллээр хангаж, Нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээ мэдээллийг дүүргийн албан ёсны сайт /www.chingeltei.gov.mn/ цахим хуудас болон /Chingeltei district/ /Чингэлтэй дүүрэг/ фейсбүүк хуудаст байрлуулах		Мэдээ, мэдээлэл байршуулсан тоогоор	765	765	Засаг даргын Тамгын газрын хэлтэс албадын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх цаг үеийн мэдээлэл, өдөр тутмын мэдээ зөвлөмжийг Чингэлтэй дүүрэг /Chingeltei District фэйсбүүк пэйж хуудас, “дүүргийн онцгой комисс”-ын пэйж, Chingeltei.gov.mn вэб сайтад үнэн бодит мэдээллийг цаг алдалгүй хүргэн ажиллаж байна. 2023 оны бүтэн нэг жилд: “Чингэлтэй дүүрэг, Chingeltei District фэйсбүүк, пэйж цахим хуудсан дахь мэдээллийг тухай бүр шинэчлэн 959 удаагийн цагаан мэдээ оруулснаас 1,048,773 хандалт авсан байна. Жилийн эцсийн тайлан буюу 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл: Үүнээс: ХМОНХТ- 715 мэдээг бэлтгэж, нийслэлийн мэдээ- 193 хуваалцаж, бусад -51 мэдээ иргэдэд хүрчээ. Нийт мэдээлэлд 3137 эерэг сэтгэгдэл, 362 сөрөг сэтгэгдэл, 16689 удаа таалагдаж, мэдээг 10103 хуваалцсан байна.	90
3.4.2	Дүүргээс зохион байгуулж байгаа арга хэмжээг сурвалжлах, хэвлэл мэдээллээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж гэрэл зураг, дүрс бичлэг болон хувь хүний видео	-	Дүрс бичлэг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэж, архив үүсгэсэн байх	100% хүрч ажиллаж, архив үүсгэсэн	100% хүрч ажилласан байх	Дүүргээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны зураг авалт, видео дүрс бичлэгийг хийж 29 видео шторк пэйжид оруулж, 29 дүрс бичлэгийг архивлана 5 рийл бичлэг хийж нийт 9 бичлэгийн дүрсийг баримтжуулж ажиллалаа. Үүнд: Дүүргийн 30 жилийн ойн хүрээнд “Цэнгэлийн Өлгий Чингэлтэй” дууны дүрс клипний ажлыг жийж гүйцэтгэв. Мөн “Ердөө 90 минут” их цэвэрлэгээний дүрсийг авч ажилласан байна. “Амар	90

	нэвтрүүлэг, шторк бэлтгэн ажиллах.					байна уу” цагаан сарын үзэсгэлэн худалдааны нээлтийн үйл ажиллагааны дүрсийг авч архивлан ажиллав. Камерын хяналтын нэгдсэн төвийг ЦЕГ-ын удирдлагуудад үйл ажиллагаа танилцуулах үеийн дүрс бичлэг авч архивлаж ажилласан байна. 2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэгт татлага, дүүргийн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй барьсан авто гараашнуудын буулгалтын үеийн зураг бичлэг хийсэн байна. Дүүргийн 19 дүгээр хороо доод Салхитад үерийн аюултай байдал үүссэний дүрсийг авч архивлан ажилласан. Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ баг, Япон Улсын Яйзу хотын сагсан бөмбөгийн өсвөрийн шигшээ багийн тоглолтыг бичлэг хийж шууд лайваар дамжуулан хүргэн ажиллалаа. Мөн Яйзу хотын төлөөлөгчдөд зориулсан бэсрэг наадмын дүрс бичлэг, дүүргийн 400 багшид компьютер гардуулах үйл ажиллагааны бичлэгийг архивлан ажилласан. Засаг даргын 2020-2023 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг дүүргийн ахмадуудад танилцуулах ажлын видео бичлэг хийсэн байна. Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар дүүргийн төрийн албан хаагчдадаа хийсэн уулзалтын дүрс бичлэгийн архив болгон ажилласан байна. Чингэлтэй фестиваль-2023, Эртэч Чингэлтэй, хүүхдийн баяр, дуурайлган үзүүлэх дадлага сургуулийн дүрс бичлэгийг авч ажиллалаа.	
--	---------------------------------------	--	--	--	--	--	--

3.4.3	Дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1-24 дүгээр хороодын компьютерт, техник хэрэгслийн ашиглалт, найдвартай ажиллагаа, хортой кодын хамгаалалтын программаар ханган ажиллах, үзлэг хийж шаардлагатай тохиолдолд форматлах ажлыг зохион байгуулах	-	Хийгдсэн ажлын тоогоор	4	4	Засаг даргын Тамгын газар болон 1-24 дүгээр хороодын компьютер болон бусад техник хэрэгслийн гэмтлийг тухай бүрд тогтоон засварлан ажилласан. Тухайн ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газарт 27 ширхэг компьютер, 1-24 дүгээр хороодын 35 ширхэг компьютер, нийт 62 ширхэг компьютерыг форматлан интернэтийн лангийн оролтыг засварлаж, шаардлагатай программ хангамжийг суурилуулан ажилласан. Дүүргийн 1-24 дүгээр хороодын интернэтийн сүлжээний толгой төхөөрөмж болох 19 ширхэг рүүтерийг хороод тус бүрд шинээр суурилуулж ажилласан. Мөн хагас жилийн өмч бүртгэлийн ажлын хэсгээр 16 хороо, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах тасаг болон Архивын хэлтсийн албан хаагчдын үндсэн хөрөнгийн тооллогыг хийж гүйцэтгэсэн.	70
3.5 “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд							
3.5.1	Монгол Улсын Засгийн газар, Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Бүртгэж шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын тоо	-	100% шийдвэрлэж ажиллана	Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний сар болон улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Үнэлгээний дундаж 2023 оны жилийн эцсийн байдлаар 70 хувьтай байна.	100
3.5.2	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн	-	Жилд 1 удаа хяналт-шинжилгээ,	1	Хуулийн хугацаанд хяналт-	Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний	100

	хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.		үнэлгээ хийнэ.		шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна.	улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан. Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.	
3.5.3	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Жилд 1 удаа Хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	1	Хуулийн хугацаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна.	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Үнэлгээний дундаж 2023 оны жилийн эцсийн байдлаар 93.3 хувьтай байна.	90
3.5.4	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Жилд 1 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	1	Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна.	Монгол улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн 2021--2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан. Үнэлгээний дундаж 70 хувьтай байна.	90
3.5.5	Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт	-	Улиралд 1 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	4	Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ	Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай хууль, Монгол	90

	шинжилгээ, үнэлгээ хийнэ.				хийж, хэрэгжилтийг хангасан байна.	улсын Засгийн газрын 2011 оны 311, 2020 оны 206, 2021 оны 226, 2020 оны 246 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/52 дугаар захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам”, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/295 дугаар тушаалаар батлагдсан “Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Албан хэрэг хөтлөлтийн журам”, 2023 оны А/09 дүгээр тушаалын хавсралт “Хөдөлмөрийн дотоод журам”, батлагдсан удирдамж болон бусад холбогдох эрх зүйн актуудыг үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн 2023 оны ил тод байдлын төлөвлөгөөг гаргуулан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2011 оны 311, 2022 оны 246 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны тогтоолоор батлагдсан 9 хөтөлбөр, арга хэмжээний 2023 оны	
--	---------------------------	--	--	--	------------------------------------	---	--

						хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн хүрээнд доорх тайлангуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан. Үүнд: Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвд 2023 оны албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан. • Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилт; • Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэлээс өгсөн 9 үүрэг даалгаврын хэрэгжилт; • Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн хэрэгжилт; • Нийслэлийн Засаг даргын түүвэр захирамжийн хэрэгжилт; • Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд тус тус үнэлгээ хийн ажиллаж байна.	
3.5.6	Нийслэл, дүүргийн удирдах ажилтны шуурхайн зөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Тухай бүр Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	28	Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна.	Тайлангийн хугацаанд 35 удаагийн Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн 262 үүрэг даалгаврын хэрэгжилтэд тухай бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох газарт хүргүүлэн ажилласан.	100
3.5.7	Дүүргийн төр, захиргааны байгууллагад иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл,	-	Улиралд 1 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	4	Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ	Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад 2023 онд ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, зөрчлийн	90

	гомдлын шийдвэрлэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.				хийж, хэрэгжилтийг хангасан байна.	тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.	
3.5.8	Дүүргийн төр, захиргааны байгууллагад ирсэн албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Улиралд 1 удаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	1	Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна.	Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/111 дүгээр захирамжаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн “eDoc” систем ашиглах журам”-ыг тус тус үндэслэн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагад 2023 онд ирсэн албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагад 2023 онд ирсэн албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.	90
3.5.9	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Жилд 2 удаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	2	Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалыг үндэслэн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жил, бүтэн жилийн гүйцэтгэлийн	100

						төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан.	
3.5.10	Хяналт шалгалтын мөрөөр өгсөн зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээ авах.	-	Зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилтэд тавьсан хяналтын тоо	2	7	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөг журамд нийцүүлэн үнэлэхэд үнэлгээний дундаж 93.58 хувийн гүйцэтгэлтэй буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад 3 зөвлөмжийг хүргүүлсэн. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар болон 1-24 дүгээр хороодын албан хаагчдын 1 дүгээр сарын цаг ашиглалтад хяналт-шалгалт, үнэлгээ хийхэд 49.1 хувийн гүйцэтгэлтэй буюу “хэрэгжилт хангалтгүй”, гэж дүгнэгдсэн ба 10 заалттай зөвлөмжийг хүргүүлсэн. Албан хаагчдын 02 дугаар сарын цаг ашиглалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 60.7 хувийн гүйцэтгэлтэй буюу “хэрэгжих шатанд” гэж дүгнэгдсэн ба 10 заалттай зөвлөмжийг хүргүүлсэн. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны Ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 88.67 хувийн гүйцэтгэлтэй буюу “хэрэгжих шатанд” гэж дүгнэгдсэн ба 3 заалттай зөвлөмжийг хүргүүлсэн. Засаг даргын Тамгын газрын захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 31.5 хувийн гүйцэтгэлтэй буюу “Хэрэгжилт хангалтгүй” гэж дүгнэгдсэн ба 2 заалттай зөвлөмжийг хүргүүлсэн. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны	90

						өдрийн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн төлөвлөгөөг гарган удирдлагад танилцуулан ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 2023 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилтийн дундаж нь 70.2 буюу хэрэгжих шатанд гэж дүгнэгдсэн ба 7 зөвлөмжийг хүргүүлсэн. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 53.14 хувьтай үнэлэгдсэн ба 2 заалттай зөвлөмжийг хэлтэс, тасгийн дарга нарт албан бичгээр хүргүүлж ажилласан. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа 106 байгууллагад Edoc.ulaanbaatar.mn нэгдсэн системээр 2023 оны эхний хагас жилд ирсэн албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 9 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн. Засаг даргын дэргэдэх харьяа байгууллагууд болон Засаг даргын Тамгын газарт 2023 оны эхний хагас жилд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, зөрчлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилтийн дундаж 80.75 хувь буюу "хэрэгжих шатанд" гэж дүгнэгдсэн ба 7 заалттай зөвлөмжийг хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг	
--	--	--	--	--	--	---	--

						хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, илтгэх хуудсыг 2023 оны 02 дугаар 03-ны өдрийн 3/265 дугаартай албан бичгээр хэлтэс, тасгийн дарга нарт хүргүүлсэн. Цаашид хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнг нэмэгдүүлж, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулан төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам тайлагнаж ажиллахыг албан бичгээр хүргүүлэн ажилласан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөний 2023 оны улирлын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан.	
3.5.11	Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар холбогдох дүрэм журмын хүрээнд албан хэрэг хөтлөх, Архивын тухай хууль зааврын дагуу хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан холбогдох материалыг архивын хадгаламжийн нэгж болгох.	-	Хуулийн хугацаанд архивд шилжүүлсэн байна	1	Архивласан хадгаламжийн нэгжээр	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу хэлтсийн 2022 оны 6 хадгаламжийн нэгж 387 хуудас баримтыг Архивын хэлтэст хүлээлгэн өгч 2023 оны хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг гарган батлуулсан.	100

3.6 Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн үндэслэлийг хянах, иргэдэд сурталчлах, оролцоог дэмжсэн олон талт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах;							
3.6.1	1.1.3.Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаалын төслийн эрх зүйн үндэслэлийг хянах, санал өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;	-	Эрх зүйн актын баримт бичгийн хэрэгжилтийн хувиар	2023 оны 2-р улиралд эрх зүйн актын 206 төсөл хянагдсан.	Тухай бүр	Дүүргийн Засаг дарга, Тамгын газрын даргын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Засаг даргын А захирамж 335, Б захирамж 150, Тамгын газрын даргын А тушаал 330, Б тушаал 324 тус тус захирамжлалын баримт бичгийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай тэмдэглэлийн хамт “Санал авах хяналтын дагалдах хуудас” -аар холбогдох зохион байгуулалтын нэгжийн удирдлагад танилцуулан эрх зүйн актын төслийг шат дараатай чиг үүргээр албажуулж ажилласан.	90
3.6.2	Шинээр батлагдан гарсан хууль, эрх зүйн асуудлаар мэдээлэл хийх, сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах;	-	Сургалт, үйл ажиллагаа зохион байгуулсан тоогоор	2023 оны 2-р улиралд сургалт-2, үйл ажиллагаа-1	Тухай бүр	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ” -ний хүрээнд хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заагдсан бусад мэдээллийн хэрэгжилтийн тайланг холбогдох хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хуулиар хүлээсэн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах, иргэдэд хууль зүйн зөвлөгөө мэдээлэл шуурхай хүргэн ажиллах байнгын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд Тамгын газрын албан ёсны цахим хуудасны “Эрх зүйн хөтөч” мэдээллийн хуудсаар 12 удаагийн зурган мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэсэн. Дүүргийн Засаг даргын хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд удирдлага, зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн ажлын чиглэлийг дагуу	90

						дараах эрх зүйн актыг баталгаажуулсан байна. Үүнд: Газрын харилцааны чиглэлээр: Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай, бусдад шилжүүлэх тухай, эрхийг баталгаажуулах тухай, Зохион байгуулалтын чиглэлээр: Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах, Үнэлгээний хороо байгуулах, Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, үүрэг гүйцэтгүүлэх зэрэг удирдлага, зохион байгуулалтын шинжтэй 140 захирамжлалын баримт бичгийн төслийг хууль, эрх зүйн хүрээнд нийцүүлэн Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан хөтлөх журмын дагуу иргэд, олон нийтэд www.ublegal.mn цахим сан, Тамгын газрын info@chingelteigov.mn цахим хаягт байршуулсан ажилласан.	
3.7 “Иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хууль зүйн үндэслэлийг хянах, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх” зорилтын хүрээнд:							
3.7.1	Иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний төслийг хянах, дугаарлах, бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих;	-	Гэрээний хэрэгжилтийн хувиар	2023 оны 2-р улиралд Гэрээ-28	Тухай бүр	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүргийн хүрээнд иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичигт нийцүүлэн зохион байгуулж, иргэн, аж, ахуй нэгж, байгууллагатай байгуулсан гэрээг бүртгэн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Мөн Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй байгуулах байгуулах гэрээний төсөлд “Авилгаас урьдчилан сэргийлэх”	90

						асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд гэрээний төслийг хууль зүйн хүрээнд нийцүүлэн боловсруулахад арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, холбогдох хуулийн үндэслэл, заалтыг судлах, агуулга, найруулгыг хянах, бүртгэн дугаар олгох гэрээний хугацаа, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэсэн байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулан холбогдох хэлтэс, албатай хамтран ажилласан. Гэрээний төрлөөр ангилбал: 1.Хөлсөөр ажиллах гэрээ-13 3.Ажил гүйцэтгэх гэрээ-121 4.Хамтран ажиллах гэрээ-21 5.Худалдах, худалдан авах гэрээ-25 6.Түрээсийн гэрээ-6 7.Бусдын өмчлөлд хөрөнгө эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ-5 нийт 200 гэрээний төсөл хянагдаж, баталгаажсан байна. Үүнээс хугацаандаа хэрэгжиж дууссан 144 гэрээ, хэрэгжиж байгаа 56 гэрээ байна.	
3.8 Төрийн үйлчилгээг түргэн шуурхай холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуг хүргүүлэн ажиллах зорилтын хүрээнд:							
3.8.1	Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд жагсаал, цуглаан бусад арга хэмжээ зохион байгуулахаар ирүүлсэн хүсэлтийг судлан шийдвэрлэх;	-	Ирүүлсэн хүсэлт, мэдэгдлийн тоогоор	2023 оны 2-р улиралд Жагсаалт, цуглаан хийх хүсэлт-5	Тухай бүр	Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Тусгаар тогтнолын талбай”, “Барилгачдын талбай”, “Хэлмэгдэгсдийн хөшөө”, “Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэн” “Аргальтай хөшөө” зэрэг газруудад өдөрлөг, арга хэмжээ, жагсаал, цуглаан, уулзалт арга хэмжээ зохион байгуулах нийт 27 хүсэлт /мэдэгдэл/-ийг хуулийн хүрээнд судлан үзэж, холбогдох байгууллагуудын	90

						саналыг харгалзан хууль зүйн үндэслэл бүхий хариуг албан бичгээр хүргүүлсэн.	
3.9 ГАДААД ХАРИЛЦАА							
3.9 Дэлхийн улс орнуудын Нийслэл, дүүрэг болон хотуудтай хамтын ажиллагаа тогтоох, аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төлөвлөгөө боловсруулан ажиллана.							
3.9.1	Дүүрэгтэй хамтын ажиллагаа бүхий гадаадын улс, хот, дүүрэг, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинээр хамтын ажиллагаа тогтоох	-	Зохион байгуулагдах ажлын тоогоор	15	17	Чингэлтэй дүүрэг 2023 оныг “Үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан дүүргийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг багасгах бүтээгдэхүүн үйлдвэрлэл бий болгох чиглэлээр хамтран ажиллах тухай саналыг гадаадын хамтын ажиллагаа бүхий 1 хот, 9 дүүрэг, 5 элчин сайдын яам, 2 олон улсын байгууллагад хүргүүлсэн. Үүний үр дүнд дүүргийн Жижиг дунд, үйлдвэрлэл эрхлэгчид Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 2 удаа, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Улаан-Үд хотод 1, Турк улсад 1, Япон улсад 1 удаа очиж, бараа бүтээгдэхүүнээ сурталчилж, үзэсгэлэн яармагт оролцсон байна. Түүнчлэн 2023 оны 11 дүгээр сарын 02-08-ны өдрүүдэд дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн дарга Т.Уламбаяр АНУ-ын Чикаго хотод зохион байгуулагдсан 8 дахь удаагийн “Монголын өдрүүд-2023” үзэсгэлэн худалдаа, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны уулзалт, үйл ажиллагаанд оролцсон. Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчон хотын Ёнсу дүүрэгтэй байгуулсан хамтын ажиллагааны Санамж бичгийг шинэчлэн байгуулах ажлын хүрээнд 2023 оны 12 дугаар сарын 26-30-ны	90

						өдрүүдэд хүлээн авах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотын Пендик дүүрэгтэй 2023 онд хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр холбогдох мэргэжилтэн, албан хаагчдыг харилцан солилцож, туршлага судлуулахаар харилцан тохиролцсон. Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчон хотын Ёнсү дүүргийн Засаг дарга И Жэ Ху хоёр дүүргийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй айлчлалын багийг “Ёнсү Нинходэ соёлын фестивал”-д оролцуулахаар урьсан бөгөөд Засаг даргаар ахлуулсан томилолтын баг 2023 оны 10 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд албан томилолтоор ажилласан. Мөн хамтын ажиллагаатай Япон улсын Шизүока мужийн Яйзү хотын дарга Накано Хиромичигийн урилгаар 2023 оны 10 дугаар сарын 08-11-ний өдрүүдэд Засаг даргаар ахлуулсан бүрэлдэхүүн тус хотод туршлага судлан ажилласан.	
3.9.2	Гадаадын хот, дүүрэг, олон улсын байгууллага, дотоодын аймаг, сумд, компанийн Чингэлтэй дүүрэгт айлчлал хийх, зочлох төлөөлөгчдийг хүлээн авах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан	-	Батлуулсан хөтөлбөр, төлөвлөгөө Бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хангасан байдал	3 удаагийн айлчлалыг хүлээн авсан	Бэлтгэл ажлыг хангаж гадаадын зочид төлөөлөгчдийг бүр хүлээн авсан байна.	2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 17-ны өдрүүдэд Япон улсын Шизүока мужийн Яйзү хотын чөлөөт бөхийн холбооны дэд тэргүүн, чөлөөт бөхийн багш нар Чингэлтэй дүүрэгт ажилласан бөгөөд дүүргийн Биеийн тамир, спортын хорооны чөлөөт бөхийн багш, дасгалжуулагч болон сурагчдад онол, практикийн сургалт явуулсан. 2023 оны 05 дугаар сарын 15-21-ний өдрүүдэд мөн Яйзү хотын татварын хэлтсийн мэргэжилтэн, ОУ-ын харилцааны мэргэжилтэн нар дүүргийн Засаг даргын	90

	батлуулах, бэлтгэл ажил болон зохион байгуулалтыг хангах					Тамгын газар болон харьяа хэлтэс албатай танилцах, туршлага судалж ажилласан. 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 05-ны өдрүүдэд мөн Яйзү хотын дарга, ИТХ-ын дарга тэргүүтэй төлөөлөгчдийн дүүрэгт ажиллах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, албан уулзалтыг зохион байгуулсан. Яйзү хотын сагсан бөмбөг, нийтийн биеийн тамирын зочид төлөөлөгчид 2023 оны 08 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд дүүрэгт ажилласан. “Загвар сургуулиудад шүдний үзлэг хийх тогтолцоог нэвтрүүлэх төсөл”-ийн хүрээнд Япон улсын Ичикава хотын шүдний эмч нарын холбооны тэргүүн, Эрүүл хотуудыг дэмжигч ашгийн бус байгууллагын ерөнхийлөгч Чиба Мицүюки тэргүүтэй зочид төлөөлөгчдийн Засаг дарга, удирдлагуудтай уулзах уулзалтыг 2023 оны 09 дүгээр сарын 17-22-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж ажилласан.	
3.9.3	Дүүргийн төрийн албан хаагчдыг хариуцсан ажил үүргийн хүрээнд гадаад улсад мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамрагдах, туршлага судлах уулзалт, семинарт хамрагдахад бүхий л талаар дэмжиж ажиллах	-	Зохион байгуулагдсан сургалтын тоо Сургалтад хамрагдсан алба хаагчдын тоо	53 алба хаагчийг гадаад улсад туршлага судлах сургалтад хамруулсан	55-60 алба хаагчдыг гадаад улсад сургаалтад хамруулна	Япон Улсын Шизуока мужийн Яйзү хоттой байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 2023 оны 02 дугаар сарын 06-13-ны өдрүүдэд тус хоттой хамтран зохион байгуулсан ажилтан солилцооны хөтөлбөрт дүүргийн Боловсролын хэлтсийн Хүүхдийн хөгжил, хамгаалал, сурах бичиг, сургалтын орчин хариуцсан мэргэжилтэн Ш.Алтанхундагыг хамруулсан. Чингэлтэй дүүрэг болон Япон Улсын Шизуока мужийн Яйзү хот хоорондын боловсролын хамтын ажиллагааны хүрээнд тус хоттой хамтран Япон хэлний	90

						цахим сургалтыг зохион байгуулан, дүүргийн нийт 22 төрийн албан хаагчдыг хамруулсан. Японы эрүүл хотуудыг дэмжигч ашгийн бус байгууллага, Японы ОУ-ын Хамтын Ажиллагааны Байгууллага /Жайка/-тай хамтран хэрэгжүүлж буй “Загвар сургуулиудад шүдний үзлэг хийх тогтолцоог нэвтрүүлэх төсөл”-ийн хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 30-ны өдрүүдэд Засаг даргын Тамгын газрын дарга П.Баянбаатар, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Л.Баярмаа, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Б.Нацагдорж, Ерөнхий боловсролын 37 дугаар сургуулийн захирал З.Тунгалаг, 50 дугаар сургуулийн захирал Б.Амар, Эрүүл мэндийн төвийн шүдний эмч Х.Солонго, АШУИС-ийн Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхимийн профессор, төслийн зөвлөх Б.Оюунцэцэг нар Японы Токио хотод туршлага судлах уулзалт, семинарт хамрагдсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч И.Баатархүү тэргүүтэй нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нар 2023 оны 08 дугаар сарын 12-21-ний өдрүүдэд Нидерландын Хаант Улсын Гаагийн Академиас зохион байгуулсан “Засаглалыг бэхжүүлэх нь” сэдэвт семинарт оролцсон.	
3.9.4	Гадаадын харилцаа, хамтын ажиллагаатай хот, дүүрэгтэй	-	Зохион байгуулагдсан сургалтын тоо	Хамтарсан нөхөрсөг тэмцээнийг 1 удаа	Нөхөрсөг тэмцээн. Арга хэмжээнүү	Япон Улсын Шизуока мужийн Яйзү хоттой байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс 13-ны	90

	хамтарсан аливаа урлаг, спортын нөхөрсөг тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулах, Ерөнхий боловсролын сургуулиудын хичээл, сурлага, урлаг спортоор манлайлдаг тэргүүний сурагчдыг “Сурагч солилцоо”-ны хөтөлбөрт хамруулах		Хөтөлбөрт хамрагдсан сурагдын тоо	зохион байгуулсан	дийг зохион байгуулж сурагчдыг сурагч солилцооны хөтөлбөрт хамруулна	өдрүүдэд тус хоттой хамтран зохион байгуулсан ажилтан солилцооны хөтөлбөрт дүүргийн Боловсролын хэлтсийн Хүүхдийн хөгжил, хамгаалал, сурах бичиг, сургалтын орчин хариуцсан мэргэжилтэн Ш.Алтанхундагыг хамруулсан. Яйзү хотын Чөлөөт бөхийн холбооны дэд тэргүүн, чөлөөт бөхийн багш нар Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны багш, хүүхдүүдэд чөлөөт бөхийн онол, практикийн сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 12-17-ны өдрүүдэд явуулсан. Мөн Яйзү хотын Татварын хэлтсийн мэргэжилтэн болон ОУ-ын харилцааны мэргэжилтэн нар 2023 оны 05 дугаар сарын 15-21-ний өдрүүдэд төрийн албан хаагчдын харилцан туршлага солилцох ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс албад болон Ерөнхий боловсролын 149, 37, 23-р сургууль, 224, 280 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаатай тус тус танилцаж, туршлага солилцож ажилласан.	
3.10 ТӨРИЙН БАТЛАН ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ							
3.10 “Дайчилгаа удирдах бүлэг, хэсгийн дайчилгааны бэлэн байдлыг хангах болон орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулж, хэрэгжилтийг хангах, томилгоот бүрэлдэхүүний дадлага, чадварыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд							
3.10.1	Дайчилгааны даалгавраар оногдуулан бүртгэгдсэн хүн, техникийн тодотголыг явуулах	-	Дадлага сургалтад бүрэн хамруулна.	100 хувьтай хэрэгжсэн	Томилгоот бүрэлдэхүүний мэдлэг дадлага дээшилнэ.	Цэргийн штабыг бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх төлөвлөгөө, Зэвсэгт хүчний анги, байгууллагуудыг бие бүрэлдэхүүн, техникийг нөхөн хангах төлөвлөгөө орон нутгийн цэргийг байгуулах бэлтгэлийг хангах төлөвлөгөөг тус тус тодотгосон. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2020, 2021 оны удирдамж, нийслэлийн Засаг даргын 2023 оны Н/04 дүгээр	90

						захирамж, дүүргийн Засаг даргын Тамгын даргын А/86 дугаар тушаалаар Зэвсэгт хүчний Жанжин штаб, нэгтгэл, анги салбарт, оногдуулан бүртгэсэн хүн, техникт тодотголыг 04 дүгээр сард хийж Цэргийн штабын бэлэн байдал дээшилсэн. Зэвсэгт хүчний Жанжин штаб, нэгтгэл, анги салбарт, оногдуулан бүртгэсэн хүн, техникт тодотголыг төлөвлөгөөний дагуу явуулж байна.	
3.10.2	Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүн болон дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах, техник материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх	-	Дадлага сургалтад бүрэн хамруулна.	100% хэрэгжсэн	Сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө ний дагуу сургалтууд явагдана.	Орон нутгийн цэргийн отрядын хүн техникийг 2021 оны цэргийн бүртгэл, НЗДТГ-ын цэргийн штабаас авсан авто техникийн 2023 оны бүртгэлээс оногдуулсан бүртгэсэн. 2023 оны Зэвсэгт хүчний Жанжин штабын Ерөнхий арга хэмжээний төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан Стратегийн команд штабын сургуульд Цэргийн штабын дарга, дайчилгааны офицер хамрагдсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын оногдуулан бүртгэгдсэн Орон нутгийн Цэргийн Отряд, Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний томилгоонд чанар байдлын судалгааг гарган бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг төлөвлөгөөний дагуу 11 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан.	90
3.10.3	Цэргийн бүртгэлийг зохион байгуулж, бүртгэлд хамрагдаагүй завсардсан иргэдийн судалгааг	9.5 сая	Дайчилгааны бэлэн байдлын түвшин дээшилнэ	100 хувьтай хэрэгжсэн	Цэргийн албаны тухай хуулийн хэрэгжилт хангагдаж,	Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны “Цэргийн бүртгэл явуулах тухай” А/331 дүгээр журмыг удирдлага болгон нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1521, дүүргийн Засаг даргын А/371	90

	мэдээллийн санд оруулан, баяжилт хийх				дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн чанар нэмэгдэнэ.	дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 04-20-ны өдрүүдэд цэргийн бүртгэлийн ажлыг E-Mongolia цахим портал, Засаг захиргааны анхан шатны нэгж болох хорооны Засаг даргын ажлын байранд зохион байгуулан явууллаа. Дүүргийн Засаг даргын захирамжаар цэргийн бүртгэлийн ажлын хэсгийг байгуулж, цэргийн бүртгэлийн бэлтгэлийг хангах 16 ажил бүхий төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% биелүүлсэн. 2023 оны 01 дүгээр сарын 03-ний өдөр дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон бүртгэлийн ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавин ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, 1-19, 20, 24 дүгээр хороодын Засаг дарга, зохион байгуулагч нартай цэргийн бүртгэлийг хэрхэн зохион байгуулах, иргэд хэрхэн E-Mongolia цахим порталаар бүртгүүлэх талаар сургалт, семинарыг зохион байгуулсан. Мөн 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр дүүргийн Цэргийн штабын мэдээллийн сангийн программ болон хороодын мэдээллийн санд вирусийн эсрэг программыг бүрэн суулган, цэргийн бүртгэл явуулах тухай зөвлөмж, хороодын Засаг дарга нарын үүрэг, удирдамж, цэргийн бүртгэлийн ажлыг зохион байгуулж, хяналт тавин ажиллах ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, анкет, маягт, сурталчилгааны материал, зурагт хуудас, ариутгал халдваргүйжүүлэлтийн материалуудыг	
--	---------------------------------------	--	--	--	--	---	--

						тарааж өгч, цар тахлын үеийн зааварчилгаагаар ханган ажиллаа Цэргийн бүртгэлийг цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia болон Засаг захиргааны анхан шатны нэгж хорооны Засаг даргын ажлын байранд зохион байгуулж иргэдэд хүрэх зурагт хуудас болон гарын авлага маягтууд, төрийн батлан хамгаалах үйлчилгээний мэдээллийн самбар, дүүргийн 1-19, 20, 24 дүгээр хорооны цэргийн бүртгэл хийгдэж буй хаяг, мэдээллийг нэг загварт оруулан ажиллалаа.	
3.10.4	3.10.4.1 Халагдсан дайчдыг ажлын байр, сургалтад зуучлах, хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдын нөхцөл байдалтай танилцан, дүүрэгт хэрэгжиж байгаа бодлого, шийдвэрийг танилцуулж, алба хаагч нарт хүндэтгэл үзүүлэх	1 сая	Амьжиргааны түвшин доогуур хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрт үзүүлэх халамж үйлчилгээг сайжруулна	100 хувьтай хэрэгжсэн.	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн байна	2022 оны 1, 2 дугаар ээлжээр цэргийн жинхэнэ албанд татагдан алба хааж байгаа тус дүүргийн 13, 16 дугаар хорооны Амьжиргааны түвшин доогуур 2 хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрт хүнсний дэмжлэг болон сургуулийн насны 2 хүүхдэд хичээлийн хэрэгслийн хамт гардуулсан. Цэргийн алба хаагаад ирсэн 2 иргэнийг мэргэжил олгох сургалтад хамруулж, 3 иргэнийг байнгын ажлын байранд зуучлан, 14 иргэнд эд материалын тусламж, 1 иргэнийг Онцгой байдлын байгууллагад гал сөнөөгчөөр оруулахаар бүртгүүлж, 9 иргэнд ажлын байр болон мэргэжил олгох сургалт, дамжааны талаар зөвлөгөө өгч ажилласан. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ойг угтаж дүүргээс хугацаат цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчний 014, 032 дугаар ангид алба хааж байгаа цэрэг, дайчдаа ойн баярын мэндийг хүргэж, дүүргийн Засаг даргын мэндчилгээ, талархал, гарын бэлгийг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр дүүргийн Засаг даргын	90

						Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Н.Энхбат, тоо бүртгэлийн ахлах офицер дэд хурандаа Б.Цэдэн нар ангийн байрлалд нь очиж гардуулсан. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/232 дугаар тушаалын дагуу Цэргийн штабын тоо бүртгэлийн ахлах офицер дэд хурандаа Б.Цэдэн, Дайчилгааны офицер дэд хурандаа Э.Амарбат, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Б.Нацагдорж, Хууль эрх зүйн хэлтсийн дарга Г.Хурцбаяр, Аж ахуйн тасгийн дарга Б.Мөнх-Ирээдүй нар 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс 27-ны өдрүүдэд Орхон аймагт байрлах Зэвсэгт хүчний 110, 186 дугаар анги, Сэлэнгэ аймагт байрлах Хилийн 0101, 0243 дагаар ангиудад дүүргээс 2022 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан цэргийн жинхэнэ алба хааж байгаа дайчдын цэргийн албаны нөхцөл байдалтай танилцах, батлан хамгаалах хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулсан.	
3.10.5	3.10.5.1 2023 оны 1, 2 дугаар ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагын ажлыг зохион байгуулах	90.000.000	Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд	Жил бүр хийгддэг.	Хуулийн хэрэгжилт хангагдана.	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/371, дүүргийн Засаг даргын 2023 оны А/126 дугаар захирамжуудыг үндэслэн 2023 оны нэгдүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны цэрэг татлагыг 2023 оны 05 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд зохион байгуулж явууллаа.Цэрэг татлагын бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөө гаргаж, цэрэг татлагын товчооны даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд нийт 33 ажил төлөвлөснөөс гүйцэтгэл 100 хувь	90

						биелсэн. Дээд байгууллагаас өгсөн тоон даалгаврыг бүрэн биелүүлсэн. 2023 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу цэргийн жинхэнэ албаны татлагын ажлыг 2023 оны 10 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, дээд штабаас өгсөн тоон даалгаврыг 100% биелүүлсэн. Мөн тус дүүргээс 2022 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан хугацаа дуусган халагдсан дайчдыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын ёслол, хүндэтгэлийн танхимд зохион байгуулсан.	
3.10.6	3.10.6.1. Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг иргэд, байгууллага аж ахуйн нэгжид сурталчилж, хяналт тавина.	280 мянга	Дүүргийн нутаг дэвсгэрт батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж, төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилт хангагдана	6 байгууллага аж ахуйн нэгж хамрагдсан	Иргэдийн батлан хамгаалах хууль тогтоомжийн мэдлэг дээшилнэ.	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн Цахим хөгжил, харилцаа холбооны яам, нийслэлийн Ерөнхий боловсролын 50 дугаар сургууль, дүүргийн 5 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс, төрийн бус Мобиком корпорац, Хүрд ХК гэсэн нийт 6 байгууллага, аж ахуйн нэгжид Батлан хамгаалах хууль тогтоомж, цэргийн үүргийн биелэлтийн хэрэгжилтийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын баталсан хяналт шалгалтын 2023 оны төлөвлөгөө, дүүргийн Засаг даргын 2023 оны А/22 дугаар захирамж, удирдамжийн дагуу зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Тус шалгалтад төлөвлөгөөний дагуу нийслэлийн ерөнхий боловсролын 50 дүгээр сургуулийн 13, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн 16, Цахим	90

						хөгжил, харилцаа холбооны яамны 23, Мобиком корпорацын 178 ажилтан албан хаагчдыг, Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны 50 зөрчилтэй иргэдийг бүрэн хамруулж, батлан хамгаалах хуулийн дагуу цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөр орлуулан хаах болзол шаардлага хангасан 75 иргэнд мөнгөн төлбөр тогтоож, ажлын байранд нь төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүргэлээ.	
3.10.7	3.10.7.1. Дүүргийн Засаг даргын нэрэмжит “Дөл” цэрэг-спортын цогцолбор тэмцээнийг зохион байгуулж явуулах	-	Хүүхэд залуучуудад цэрэг эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх, эрүүлжилтийг дэмжих	2022 онд 100%-тай хэрэгжсэн	Дүүргийн ерөнхий боловсролын ахлах ангийн сургуулиудын сурагчдыг бүрэн хамруулах	Цэрэг-спортын “Дөл” тэмцээний 2 дугаар шатны шалгаруулалтад оролцох Ерөнхий боловсролын 13 ахлах сургуулийн дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан, эмч нар, дүүргийн ЭМТ-ийн өсвөр үе хариуцсан эмч нарын бүрэлдэхүүнтэй техникийн зөвлөгөөнийг 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж тэмцээнд оролцох сурагчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулах, хуваарь, тэмцээнд оролцуулахад эцэг эхийн зөвшөөрлийн бичиг зэрэг бусад шаардлагатай зүйлсийн талаар мэдээлэл хийж, сургуулийн баг тамирчдын бэлтгэл ажлыг хангуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Тэмцээний нээлтийн арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Хайрхан хөгжлийн төв “УТҮГ”-ын хөл бөмбөгийн талбайд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Баянбаатар, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт, Төлөвлөлт, сургалтын офицер хошууч Ц.Энхтайван болон бусад албан тушаалтнууд	100

						оролцсон. Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг батлагдсан удирдамж, зааврын дагуу 14 төрлийн тэмцээнийг бага онооны системээр дүгнэж амжилттай зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл-2023” цогцолбор тэмцээнд оролцож тэргүүлсэн шилдгүүдэд шагнал гардуулах ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр дүүргийн “Тусгаар тогтнол”-ын талбайд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Чингэлтэй дүүргийн Засаг дарга бөгөөд Батлан хамгаалах товчооны дарга Н.Батсүмбэрэл, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт, Төлөвлөлт, сургалтын офицер хошууч Ц.Энхтайван, Засаг даргын орлогч Д.Отгонбаатар нар болон дүүргийн хэлтэс, албадын дарга нар дүүргийн ЕБС-иудын захирлууд, цэрэг спортын дөл тэмцээний 2-р шатны шалгаруулалтад хурд хүч авхаалж самбаагаа сорин уралдсан 13 сургуулийн баг тамирчид оролцлоо. Цэрэг-спортын “Дөл-2023” тэмцээнд тэргүүн байрт шалгарсан Ш.Оюунсүрэн захиралтай 23 дугаар сургуулийн Элит-23 тасагт Аваргын цом, алтан медаль, өргөмжлөл, 2,500,000₮-ийн мөнгөн шагнал, дэд байрт шалгарсан Г.Цолмон захиралтай 57 дугаар сургуулийн тасагт мөнгөн медаль, өргөмжлөл, 2,000,000₮-ийн мөнгөн шагнал, гутгаар байрт шалгарсан Т.Нарантуяа захиралтай 24 дүгээр сургуулийн Хар сүлд тасагт хүрэл медаль, өргөмжлөл 1,500,000₮-ийн	
--	--	--	--	--	--	---	--

						мөнгөн шагналаар шагнасан. Мөн удирдамжийн дагуу төрөл тус бүрээр байр эзлүүлж төрлийн шагналыг гардуулсан. Үүнд: • Тэмцээний “Марш гүйлтийн тэмцээн” болон “Тэргүүний жагсаалын үзүүлэх тоглолт”-д тэргүүлсэн Ш.Оюунсүрэн захиралтай 23 дугаар сургуулийн “Элит-23” тасагт өргөмжлөл, тус бүр 200,000₮-ийн мөнгөн шагнал; • “Галын бэлтгэлийн нормативын тэмцээн” болон “Тэргүүний хамт олонч” тасгаар шалгарсан Т.Нарантуяа захиралтай 24 дүгээр сургуулийн “Хар сүлд” тасагт өргөмжлөл, тус бүр 200,000₮-ийн мөнгөн шагнал; • “Тэргүүний жагсаалын 16 тоот дасгалын үзүүлбэр” болон “Тэргүүний тактикч” тасгаар шалгарсан Л.Болор-Эрдэнэ захиралтай 5 дугаар сургуулийн тасагт өргөмжлөл, тус бүр 200,000₮-ийн мөнгөн шагнал; • “Тэргүүний тасгийн захирагч”-ийн төрөл болон “Тэргүүний спорт тасаг”-аар шалгарсан Б.Амар захиралтай 50 дугаар сургуулийн тасагт өргөмжлөл, тус бүр 200,000₮-ийн мөнгөн шагнал; • “Хүн эмнэлгийн нормативын төрөл” болон “Тэргүүний зохион байгуулалттай тасаг”-аар шалгарсан О.Бөхчулуун захиралтай 39 дүгээр сургуулийн	
--	--	--	--	--	--	---	--

						тасагт өргөмжлөл, тус бүр 200,000₮-ийн мөнгөн шагнал; “Тэргүүний байр зүйч” тасгаар шалгарсан Б.Өнөржаргал захиралтай 72 дугаар сургуулийн тасагт өргөмжлөл, 200,000₮-ийн мөнгөн шагнал; “Химийн нормативийн төрөл” амжилттай оролцсон Д.Нарантөгс захиралтай 17 дугаар сургуулийн тасагт өргөмжлөл, 200,000₮-ийн мөнгөн шагналаар тус тус шагнаж урамшууллаа.	
3.10.8	3.10.8.1. Цэргийн штабаас 2023 онд зохион байгуулах сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилт хангагдана.	100% хэрэгжсэн.	Албан тушаалтнуудын мэдлэг дадлага чадвар дээшилнэ.	Сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2023 оны дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нарын сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга хамрагдсан. Зэвсэгт хүчний Жанжин штабын 2023 оны Ерөнхий арга хэмжээний төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан Стратегийн команд штабын сургуульд Цэргийн штабын дарга, дайчилгааны офицер хамрагдсан. Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө, дүүргийн Засаг даргын 2023 оны А/122 дугаар захирамжийг тус тус үндэслэн Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн материаллаг баазыг түшиглэн 2023 оны 05 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулсан. Хорооны Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтаар хөтөлбөрийн дагуу нийт 18 цагийн сургалт явуулснаас батлан хамгаалах хууль тогтоомж,	90

						Зэвсэгт хүчний өнөөгийн байдал-10 цаг, цэргийн анхан шатны мэдлэг, дадлага олгох хичээлүүд-8 цагийн сургалтыг явуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх бригадын генерал, доктор Д.Баасандамба “Батлан хамгаалах бодлогын үндэс, Зэвсэгт хүчний өнөөгийн чиг хандлага”, “Кибер аюулгүй байдал” Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын сургалт бэлтгэлийн хэлтсийн дарга хурандаа Т.Тогмиддүүмий “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх үзэл баримтлал” зэрэг сэдвээр тус тус сургалт явуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын оногдуулан бүртгэгдсэн Орон нутгийн Цэргийн Отряд, Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний томилгоонд чанар байдлын судалгааг гарган бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг төлөвлөгөөний дагуу 11 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан.	
3.10.9	“Бидний бахархал” арга хэмжээг зохион байгуулж, дүүргийн ЕБС-иудын сурагчдад сурталчилгааны ажил зохион байгуулах	9.5 сая	Хүүхэд залуучуудад эх орноороо бахархах эх оронч үзлийг төлөвшүүлнэ	100 хувьтай хэрэгжсэн.	Хүүхэд залуучуудад эх орноороо бахархах эх оронч үзлийг төлөвшүүлнэ	Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд зохион байгуулсан “Эх орноо дууль” сэдэвт уран уншлагын тэмцээнийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Боловсролын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс хамтран 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Тус тэмцээнд шалгарсан сурагчдын шагналыг Нийслэлийн	90

						Онцгой байдлын газрын гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, соёл урлаг, соён гэгээрүүлэх зөвлөлийн дарга хурандаа Г.Нэргүй, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Н.Энхбат нар болон холбогдох албаны хүмүүс сурагчдад баяр хүргэж, гардуулан өгсөн. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын 50, 72 дугаар сургуульд “Эх орончдын хүндэтгэлийн булан”-г байгуулж, хүлээлгэн өгсөн. Тус арга хэмжээнд дүүргийн Засаг даргын орлогч Д.Отгонбаатар, Цэргийн штабын дарга хурандаа Н.Энхбат, Нийслэлийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн захирал Б.Амар, ерөнхий боловсролын 72 дугаар сургуулийн захирал Б.Өнөржаргал болон дүүргийн хэлтэс, албадын дарга нар, Цэргийн штабын офицер, ахлагч нар оролцсон. Дүүргийн ерөнхий боловсролын сурагчидтай 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр “Монгол цэргийн түүхэн хэлхээ ба эх оронч төлөвшил” сэдэвт хүүхэд, залуучуудын төлөөллийн тойрон аялал, уулзалт зохион байгууллаа. Тойрон аяллыг Зэвсэгт хүчний 084 дүгээр анги, Монгол цэргийн музей, Зэвсэгт хүчний 032 дугаар анги, Зэвсэгт хүчний 014 дүгээр анги гэсэн маршруттайгаар зохион байгуулсан. Тойрон аялалын үеэр Зэвсэгт хүчний 084 дүгээр анги “Гардан тулааны үзүүлэх тоглолт”, “Шүхрээр буух үзүүлбэр, дадлага, сургууль”, Зэвсэгт хүчний 032	
--	--	--	--	--	--	---	--

						дугаар анги “Жагсаалын үзүүлэх тоглолт”-уудыг сонирхуулсан. Монгол Улсад генерал цол бий болсны 79 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөний, дүүрэгт оршин суудаг генералуудад хүндэтгэл үзүүлэх ажиллагааг 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Чингэлтэй дүүргийн эрхэм генералууд арга хэмжээний хүндэт зочид Чингэлтэй дүүргийн 1-р хорооны оршин суугч Монгол Улсын гавьяат хуульч, хошууч генерал С.Дамдинсүрэн, дүүргийн 3-р хорооны оршин суугч Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж.Болдбаатар, Онцгой байдлын Ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн нарт хүндэтгэл үзүүлсэн.Тус арга хэмжээнд дүүргийн Засаг дарга бөгөөд батлан хамгаалах товчооны дарга С.Батсүмбэрэл, дүүргийн Засаг даргын орлогч Д.Отгонбаатар, дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл-2023” тэмцээнд амжилттай оролцсон ерөнхий боловсролын 5, 23, 24, 50 дугаар сургуулийн тасгийн сурагчид, бусад албан тушаалтнууд оролцсон.	
3.10.10	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэнийг журмын дагуу элсүүлж, бэлтгэл, болон тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтыг зохион	-	Сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилт хангагдана.	100% хэрэгжсэн	Хуулийн хэрэгжилт хангагдана.	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, 29.2 дахь хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, 33 дугаар зүйлийн 33.6, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, 2021 оны 220 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн	90

	байгуулж, алба хаах хугацааг тооцож бүртгэл мэдээллийг хөтлөх					2023 оны 44 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2023 оны А/469 дүгээр захирамжийн дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлт гаргасан 8 иргэнийг хуулийн дагуу элсүүлж, сургалт зохион байгуулж явуулах дүүргийн Засаг даргын 2023 оны А/161 дүгээр захирамжийн дагуу 2023 оны 06 дугаар сарын сарын 02-15-ны өдрүүдэд 14 хоногийн хугацаатай Хилийн 0267 дугаар ангид цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл сургалтад, хамруулж хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх мэдлэг дадлагыг олгосон. Цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтыг Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан дүүргүүд бүсчилсэн хэлбэрээр Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Онцгой байдлын гал унтраах, аврах 10-р ангийн материаллаг баазыг түшиглэн 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд 14 хоногийн хугацаатай Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/211 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын хөтөлбөр, мэдээний маягт батлах тухай” сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. Сургалтын явцад 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Нийслэлийн Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвтэй хамтран дадлагын сургалтыг зохион байгуулсан. Мөн дүйцүүлэх алба хааж байгаа алба хаагчдын хугацааг тооцож, бүртгэл мэдээллийг тогтмол хөтлөн ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	---	--

3.10.11	3.10.9.1. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана	100 хувьтай хэрэгжсэн	Албан тушаалтнуудын төрийн болон албаны тухай хууль тогтоомжийн мэдлэг дээшилнэ.	2023 оны Цэргийн бүртгэлийн бэлтгэл ажлын хүрээнд 1-24 дүгээр хорооны зохион байгуулагч нарт Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон хорооны цэргийн бүртгэлийн мэдээллийн сан, бүртгэлийн тэмдгийн ашиглалт, хадгалалт, хүний хувийн мэдээлэл алдахаас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хүргэж, төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг Маягт №2 дагуу гаргуулсан. 2023 онд хөтлөгдөх хэргийн нэрийн жагсаалтыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 2023 оны 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Маш нууц, нууц, албан хэрэг, данс бүртгэлийн ангиллыг боловсруулан Цэргийн штабын даргаар хянуулан батлуулсан.Төрийн болон албаны нууцын тухай хууль, Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/10 дугаар тушаалаар төрийн болон албаны нууцын 2 дугаар түвшний нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтнуудаар төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг батлагдсан маягтын дагуу гаргуулж ажилласан.	100
3.10.12	3.10.10.1. Тамгын газар, хорооны ажлын алба болон холбогдох албан тушаалтнуудтай	-	Монгол Улсын Батлан хамгаалахын Төрийн болон албаны	100% хэрэгжсэн	Албан тушаалтнуудын мэдээллийн аюулгүй	Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсэг, хороодын зохион байгуулагч, бусад албан хаагчидтай нууц материалын хадгалалт хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлын талаар	90

	нууц материалын хадгалалт хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулах, хяналт тавих		нууцыг хамгаалах журмын дагуу		байдал, нууц хадгалалт хамгаалалтын талаарх мэдлэг, чадвар дээшилнэ.	дүүргийн Засаг даргын Тамгын газрын цэргийн штабын бие бүрэлдэхүүн сургалт, семинар зохион байгуулсан.	
3.10.13	3.10.11.1. Архивын хадгаламжийн нэгж үүсгэж, архивд шилжүүлэх	1.000.000	Зааврын дагуу	100% хэрэгжсэн	Маш нууц, нууц материал алдагдаж үрэгдэхээс сэргийлсэн	Баримт хүлээн авах хуваарь, архивын хөмрөгийн бүрдүүлэлтийн төлөвлөгөө, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 онд үүссэн 52 баримтаар хадгаламжийн нэгж үүсгүүлэн хүлээн авсан. Байнга болон түр хадгалах баримтын бүртгэлийг нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 2023 оны 02 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгт авсан. Нууц албан хэрэг данс бүртгэлийн ангиллаар үүссэн хадгаламжийн нэгжүүдийг архивлан бүртгэх ерөнхий бүртгэлд бүртгэн 2022 оны ангиллыг хаасан.	100
ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
НОГООН ХӨГЖИЛ							
4.1 Агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилго бүхий “Ногоон дүүрэг-2024” арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
4.1.1	Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд 7-19 дүгээр хороодын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, борлуулалтын үйл ажиллагааг жигдрүүлнэ.	-	Стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр айл өрхүүдийг хангасан борлуулалтын цэгийн тоо	2022 онд стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр айл өрхүүдийг хангах 90 борлуулалт	Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэгийг нэмэгдүүлэх	Дүүргийн хэмжээнд 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийт шахмал түлш борлуулах 94 борлуулалтын цэг ажиллаж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр журам, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/1561 дугаар захирамжийг тус тус үндэслэн агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг зохион байгуулсан. “Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын	90

				ын цэг ажилласан.		тооллогын мэдээллийн сан"-д (envpol.mne.gov.mn) 2023 онд 18776 эх үүсвэрийн мэдээллийг бүртгээд байна. "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах" ажлын төлөвлөгөөний дагуу галлагааны улирал эхэлж байгаатай холбогдуулан дүүргийн 7-24 дүгээр хорооны угаарын хийн хордлогод өртөх эрсдэлтэй айл өрх, иргэдэд сайжруулсан шахмал түлшийг зөв хэрэглэх, угаарын хийнээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, угаарын хий мэдрэгчийн хэрэглээ бүхий зөвлөмж зэрэг нийт 9893 ширхэг гарын авлагыг тарааж ажилласан.	
4.1.2	Арга хэмжээ 8.3. "Гэр хорооллын ариун цэврийн байгууламж, цэвэрлэх байгууламжийн лаг хаягдлыг байгальд халгүй аргаар шатааж устгах төсөл /Лагийн үйлдвэр/ хэрэгжүүлнэ	1,1 тэрбум	Лагийн үйлдвэр барьж байгуулснаар цахилгаан дулаан хангамжийг үйлдвэрлэх	Хэрэгжиж байгаа ажлын явц 50 хувь	2 дугар улиралд үйлдвэрийн ажил 100 хувь хэрэгжиж дууссан байна.	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт Улсын төсвийн хөрөнгөөр Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас хэрэгжиж байгаа түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Гэр хорооллын ариун цэврийн байгууламж, цэвэрлэх байгууламжийн лаг хаягдлыг байгальд халгүй аргаар шатааж устгах туршилтын төсөл"-ийн гүйцэтгэгчээр "Мөнгөн болдог" ХХК шалгаран зураг төслийн дагуу хийж гүйцэтгэж байгаа бөгөөд захиалагчийн хяналтыг Барилгын хөгжлийн төвөөр хянуулан ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар ажлын явц 50 хувьтай хэрэгжиж байгаа ба суурь бетон цутгалтын ажил бүрэн хийгдэж, лаг хаягдлын бассейны нүхийг ухаж дуусган сэндвичийн барилгын арматур төмрийг бүрэн босгон боловч тухайн төсөл цаашид үргэлжлэх талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тодруулан ажиллаж байна.	70

4.2 Дүүргийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, цэцэрлэгт хүрээлэн, ойжуулалт, ногоон байгууламжийг бүтээн байгуулна.

4.2.1	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	700.0	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн хувь	141666 ширхэг мод, бут, сөөг тарьж ургуулсан.	Суурь түшингийн 10-с доошгүй хувьд нэмэгдүүлнэ.	Дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Ж.Самбуугийн гудамж, 1 дүгээр хороо, Жуулчны гудамж зэрэг байршлуудад 15000 ширхэг хайлаас мод, дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Тусгаар тогтнолын талбайд 4000 ширхэг нэг наст цэцгийг тарьсан. Мөн дүүргийн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалт, цэнэг усалгааг Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК хариуцан ажиллаж нийт 72857м2 талбайн цэвэрлэгээ арчилгааг өдөр тутамдаа хийж, 138 рейсээр 1380 тонн ус тээвэрлэн хаврын цэнэг усалгаа, мод бутны ургалт сайжруулах зорилгоор 863 ширхэг мод, бутны тогоо, 220 у/м ургамлан хашлаганд шуудуу гаргах, 233 ширхэг модыг шохойдох ажлыг хийж гүйцэтгэсэн. Хавар, намрын мод тарилтын хүрээнд 19 дүгээр хороо Дээд салхитын аманд Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албад, 1-24 дүгээр хороод, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд болон Тохижилт Үйлчилгээний хамт олон хамтран 950 хүн 600 нарс, 3500 хайлаас, голт бор, тус тус тарьж цэнэг усалгаа хийсэн. 16 дугаар хороо Хайлаастын аманд Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгүүд Хоймор хайрхны амралт ОНӨТҮГ-ын албан хаагчид нийт 450	90
-------	---	-------	--	---	---	---	----

						албан хаагч 1600 хайлаас нарс тарьж цэнэг усалгаа хийсэн..	
4.2.2	Цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, ногоон байгууламж, ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.	60,000.0	Цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгийн ногоон байгууламж, нөхөн сэргээлт, ойжуулалтыг нэмэгдүүлсэн хувь	2017-2022 онд нөхөн сэргээлт ойжуулалт аар 119514 ширхэг мод, бут, сөөг, бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнд 51324 ширхэг мод, бут, сөөг тарьж ургуулсан.	Суурь түшингийн 10-с доошгүй хувьд нэмэгдүүлнэ.	Цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 5 дугаар хороо Тусгаар тогтнолын талбайд нэг наст ургамал буюу Хун цэцэг-4,000 ширхэг, 4 дүгээр хороо хороо Самбуугийн гудамжинд Хун цэцэг-60 ширхэг, 1 дүгээр хороо Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэнд Олон наст цэцэг тарихаар төлөвлөн ажиллаж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд болон он дамжин 5, 8, 12, 13, 14, 16, 17, 18, 19 дүгээр хороодод нийт 1,3 тэрбум төгрөгөөр 12 бичил цэцэрлэгүүдэд засвар шинэчлэлтийн ажил хийгдэж дууссан. 11 дүгээр хороо Нуурын 14, 15 дугаар гудамжинд 1000м2 явган зам, 541м2 асфальт гүйлтийн зам, 2143м2 бетонон явган зам тус тус хийж гүйцэтгээд байна. Дүүргийн хэмжээнд 16 байршилд 8000 м2 явган замын ажил хийж гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгөөр Тахилтын аманд 4 тэрбумаар тохижилтын ажил хийж гүйцэтгэхээр зураг төсвийг “Сивил дизайн” ХХК хийж гүйцэтгэн тендер зарлан гүйцэтгэгчээр Жавхлан хүслэн ХХК шалгарч газар шорооны ажил 80%, гэрэлтүүлгийн суурь шон тавигдсан, шат хийгдсэн. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2 дугаар хороо БХ 30 болон 28 дугаар байрны тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 15 дугаар хороо 72 дугаар сургуулийн хойд	90

						талд 150м2 тохижилтын ажлыг Антек ХХК хийж гүйцэтгэсэн. Мөн 6 дугаар хороо 62 дугаар байрын хойд талын тохижилтын ажлыг Хот тохижилтын газраас хийж гүйцэтгэн 75м2 явган замын ажил хийж гүйцэтгэсэн. Өрхийн тохижилтын ажлыг дэмжиж жишиг болгох үүднээс 3 хорооны 750м2 талбайд зүлэг суурилуулах ажлыг “Тэцэ” ХХК-тай хамтран 4 өрхөд хар шороо асгах, суурь бэлдэх, зүлэгжүүлэлт суурилуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	
4.3 Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, ангилах, боловсруулах, худалдан авах цогц менежментийг үе шаттай хэрэгжүүлж, өндөр хөгжилтэй орнуудын хогны менежментээс туршлага судлан хэрэгжүүлнэ.							
4.3.1	Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, ангилах, боловсруулах зорилгоор арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.	11.000.	Тээвэрлэсэн хог хаягдал тонн, рейс, цэвэрлэсэн талбайн м2	29,667 рейс 176,033 тонн хог хаягдал	Хог хаягдлын хэмжээг бууруулна.	Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК, Найши трейд ХХК байгууллагууд нь байшин хороолол, гэр хороолол, зуслангийн бүсийн айл өрх аж ахуй нэгж байгууллагуудын хог хаягдал, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ арчилгаа, бичил цэцэрлэгүүдийн цэвэрлэгээ, үйлчилгээ, гудамж талбайд байршуулсан хөшөө, хогийн сав, хайс, сандал, саравчийн тоос шороо арчиж цэвэрлэх мөн гэр хороолол айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын орчны цэвэрлэгээ, далан суваг, гуу жалганы түүвэр цэвэрлэгээ хийх, цэвэрлэгээнээс гарсан хог хаягдал болон ахуйн хог хаягдлыг ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэн ажилладаг. Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК, Найши трейд ХХК-иуд жилийн эцсийн байдлаар 452,2 тонн хог хаягдлыг тээвэрлэн ажиллалаа.	90

						Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн менежмент (УБАХХЦТМ) төсөл нь 2019 оны 4-р сараас эхлэн манай дүүрэгт маш амжилттайгаар хэрэгжээд байна. дүүргийн 7,12-р хороонд хэрэгжүүлж байгаа бөгөөд хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах зориулалттай хашаанд суурилуулах хогийн савыг нийт 500 айлд, үүсмэл хог байнга төвлөрдөг, үүсмэл хог үүсдэг цэгүүдэд нарны эрчим хүчээр ажилладаг зөөврийн зориулалттай камерыг нийт 16 байршилд тус тус суурилуулаад байна. Мөн 7 болон 12 дугаар хороонд оршин суугч иргэдийн хог ангилан ялгах дадал хэвшлийг бий болгох, дахин боловсруулах боломжтой дахиварыг иргэдээс худалдан авах, иргэд хог хаягдлын талаар мэдлэг олгох сургалт, сурталчилгаа явуулах зорилгоор "Recycle shop" цэгийг хороо тус бүрд нэгийг байгуулаад байна.Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-ууд иргэдийн бүлгийг өөрсдийн хөрөнгөөр тогтмол ажиллуулж байна. Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК 7-16 дугаар хороо буюу 2 дугаар бүсэд 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 2 бүлэг, “Найши трейд” ХХК 3 дугаар бүс болох 17-19 дүгээр хороонд 13 хүний бүрэлдэхүүнтэй 2 бүлгийг тогтмол ажиллуулан хэвшээд байна. Чингэлтэй дүүргийн гэр хорооллын 7-19 хороонд хоёр компанийн нийт иргэдийн бүлгийн 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй иргэдийн	
--	--	--	--	--	--	---	--

						бүлэг 7 хоногт 2-3 удаагийн давтамжтайгаар түүвэр цэвэрлэгээг хийж гүйцэтгээд байна. Цэвэрлэгээний явцад гэр хорооллын гуу жалга, далан сувгийн үүсмэл хог хаягдал, шарилж болон цас цэвэрлэгээг тогтмол цэвэрлэн ажиллаж байна. Цэвэрлэгээний явцад жилийн эцсийн байдлаар нийт 95232 м2 талбайн 452,2 тонн үүсмэл хог хаягдлыг цуглуулан цэвэрлэж ачилт хийн ажиллаж байна.	
ТАВ. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
5.1 “Дүүргийн хэмжээнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төлөвлөх, тайлагнах” ажлын хүрээнд:							
5.1.1	Улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, албад, хороодоос авч нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн саналын тоо	1	1	Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлал”-ын дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгах “Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж”-ийн нийт 23 саналыг дүүргийн хэлтэс, албадаас авч нэгтгэн Нийслэлийн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн ба www.pimis.publicinvestment.gov.mn цахим системд саналыг оруулан, үнэлгээг журмын дагуу хийж ажилласан.Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “Санал ирүүлэх тухай” 2023 оны 01/3566 тоот албан бичгийн дагуу Улс, нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд тусгах шинээр хэрэгжүүлэх их засвар, тоног төхөөрөмж, зураг төсөв болон шилжих барилга байгууламж, их засвар тоног төхөөрөмж, зураг төсвийн саналаа төсөл, арга хэмжээ бүрээр	90

						гаргаж НЗДТГ-т 2023 оны 06 дугаар сарын 06 дугаар сарын 23-ны өдрийн 3/1649 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан. Дүүргийн, ДОНХС-ын 2024 оны төсвийн саналд тусгах саналыг нэгтгэн ДИТХ-аар хэлэлцүүлэхээр бэлтгэн ажиллаж байна.	
5.1.2	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний санал авах ажлыг олон нийтийн оролцоог ханган зохион байгуулах, холбогдох тооцоо судалгааг хийж төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг боловсруулна.	-	Санал өгсөн иргэдийн тоо	60%	70%	Дүүргийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах ажлыг зохион байгуулах тухай” А/130 дугаар захирамжаар “Ажлын хэсэг” байгуулагдаж, Ажлын хэсэг болон дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг дарга нарт захирамжийг хүргүүлсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал асуулгыг дүүргийн 1-24 дүгээр хороонд зохион байгуулан өдөр бүр саналын явцын тайланг авч, “Чингэлтэй дүүрэг/Chingeltei District” facebook цахим хуудсаар болон хороодын цахим хаягаар иргэд олон нийтийг мэдээ, мэдээллээр хангаж, мөн гар утасны аппликейшн ашиглаж чадахгүй өндөр настан болон эмзэг бүлгийн иргэдээс цаасаар санал авахаар төлөвлөн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/140 дүгээр тушаалаар нийт 22,000 саналын хуудас хэвлүүлэн хороодод тарааж цаасаар санал авсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх төсөл, арга хэмжээнд дүүргийн 1-24 дүгээр хороодын иргэд цахимаар нийт 4491, цаасаар 96974, нийт 101581 санал	90

						өгсөн. ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний иргэдээс ирүүлсэн саналын дагуу 2023 оны 11 дүгээр сарын 15-28-ны өдрүүдэд газар дээр нь очиж ажиллан урьдчилсан жагсаалтыг боловсруулан ДИТХ-д өргөн барьсан.	
5.1.3	Арга хэмжээ №1.3. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл бүхий төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хүргүүлсэн байна.	-	Төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг дүүргийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлсэн саналын тоо	24	24	ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний иргэдээс ирүүлсэн саналын дагуу 2023 оны 11 дүгээр сарын 15-29-ны өдрүүдэд газар дээр нь очиж ажиллан урьдчилсан жагсаалтыг боловсруулан ДИТХ-д өргөн барихад бэлэн болсон.	90
5.1.4	Дүүрэгт улс, нийслэл, дүүргийн төсвийн болон нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлийг хянах.	-	Төсөл, арга хэмжээнд хяналт тавьсан тоо	10	2	Дүүрэгт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд он дамжин хэрэгжиж байгаа 146,923.1 сая төгрөгийн нийт 43 төсөл, арга хэмжээ, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих 300.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ, 2022-2023 онд он дамжин хэрэгжиж байгаа 39,632.78 сая төгрөгийн нийт 10 төсөл арга хэмжээ, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжих 1,200.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ, 2022-2023 онд он дамжих хэрэгжиж байгаа 865,00 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ байна.	70

						• Бэлтгэл ажил хийгдэж байгаа 4 төсөл арга хэмжээ: • Тендерийн шатандаа байгаа 7 төсөл арга хэмжээ: • Гэрээ байгуулах шатандаа байгаа 0 арга хэмжээ: • Гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа 24 төсөл арга хэмжээ: Ажил 100 хувь дууссан 24 төсөл арга хэмжээ тус тус байна. Дүүргийн нутаг дэвсгэрт хийгдэж байгаа авто зам, барилга байгууламжийн ажилд хяналт тавих ажлын хүрээнд нийт 26 гүйцэтгэгч компанид “Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай” 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 7/1698 тоот албан бичгийг хүргүүлэн, хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний явцын дэлгэрэнгүй тайланг авч ажилласан.	
5.2 “Дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн биелэлтийг гаргах” ажлын хүрээнд:							
5.2.1	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дүүрэгт хамааралтай заалтын биелэлтийг нэгтгэн боловсруулна.	-	Хүргүүлсэн биелэлтийн тоо	2	-	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дүүрэгт хамааралтай заалтын биелэлтийг сар бүрээр гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажилласан. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 4 зорилт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 60 хувьтай үнэлэгдсэн байна.	100
5.2.2	Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны	-	Хүргүүлсэн биелэлтийн тоо	2	-	Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дүүрэгт хамааралтай	70

	хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дүүрэгт хамааралтай заалтын биелэлтийг нэгтгэн боловсруулна.					заалтын 2023 оны 3 дугаар улирлын биелэлтийг нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийн дундаж үнэлгээ нь 73,09 хувьтай байна.	
5.2.3	Нийслэлийн Засаг дарга, дүүргийн Засаг даргын хооронд байгуулах хариуцлагын гэрээний биелэлтийг нэгтгэн боловсруулж НЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлнэ.	-	Батлуулах саналын тоо	1	-	Нийслэлийн Засаг дарга, дүүргийн Засаг даргын хооронд байгуулсан 2023 оны хариуцлагын гэрээний биелэлтийг нэгтгэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.	100
5.2.4	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөтөлбөрийн дүүрэгт хамааралтай заалтын биелэлтийг нэгтгэн боловсруулна.	-	Хүргүүлсэн биелэлтийн тоо	2	2	Монгол улсын Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн 2021-2023 оны жилийн эцсийн биелэлтийг нэгтгэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.	90
5.2.5	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний	-	Хүргүүлсэн биелэлтийн тоо	2	-	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны 3 дугаар улирлын биелэлтийг 71,25%-тай үнэлэгдсэн ба 2023 оны жилийн эцсийн	90

	төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн боловсруулна.					биелэлтийг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.	
5.2.6	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй 9 арга хэмжээний биелэлтийг нэгтгэнэ.	-	Хүрүүлсэн тайлангийн тоо	2	2	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй 9 арга хэмжээний 2023 оны биелэлтийг нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн ба “Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” арга хэмжээний биелэлт 90,04%, “Бүтээлч Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээний биелэлт 90,0%, “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээний биелэлт 90,0%, “Чадварлаг багш-2024” арга хэмжээний биелэлт 90,0%, “Гэр бүл-2024” арга хэмжээний биелэлт 86,0%, “Ногоон дүүрэг-2024” арга хэмжээний биелэлт 80,02%, “Эрүүл Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээний биелэлт 77,5%, “Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулах, гамшиг осол, гал түймрээс сэргийлэх-2024” арга хэмжээний биелэлт 85,0%-тай үнэлэгдэж, 9 арга хэмжээний биелэлтийн дундаж 85,95%-ийн хэрэгжилттэй байна.	100
5.3 “Үйлдвэрлэлийг дэмжих жил” зорилт арга хэмжээний хүрээнд:							
5.3.1	“Чингэлтэйд үйлдвэрлэв” байнгын худалдааны цэгийн борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах ажлыг зохион байгуулна.		Борлуулалтын орлогын дүнгээр	“Чингэлтэйд үйлдвэрлэв” байнгын худалдааны цэгийн борлуулалтын	Эхний хагас жилд: Борлуулалтын орлого 2% өссөн байх Жилийн эцэст:	“Чингэлтэйд үйлдвэрлэв” байнгын худалдааны цэгт Үндэсний ба европ хувцасны чиглэлээр 25, бэлэг дурсгалын чиглэлээр 15 үйлдвэр эрхлэгч үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 40 үйлдвэрлэгчийн 4543 ширхэг бараа бүтээгдэхүүн борлуулагдаж 256,894,100 төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.	90

				275,258,700 төгрөгийн борлуулалтын орлого хийгдсэн.	Борлуулалтын орлого 2 % өссөн байх		
5.3.2	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор үзэсгэлэн худалдааг төлөвлөн зохион байгуулах		Үзэсгэлэн худалдаанд оролцуулсан үйлдвэрлэгчдийн тоо	11 удаагийн үзэсгэлэн худалдаанд 165 үйлдвэрлэгч хамруулсан	14 удаагийн үзэсгэлэн худалдаанд 200 үйлдвэрлэгч хамруулсан.	Үйлдвэрлэлийг дэмжих жилийн хүрээнд жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг дотоод болон олон улсын зах зээлд таниулан сурталчлах, хэрэглэгч захиалагчтай холбон зуучлах, бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоодын 16, гадаадын 10, нийт 26 удаагийн үзэсгэлэн, арга хэмжээнд 542 үйлдвэр эрхлэгчийг оролцуулж 1,429,472,200 төгрөгийн борлуулалт хийсэн. Дотоодын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэр эрхлэгчдээ дэмжих зорилгоор сар шинийн өргөтгөсөн үзэсгэлэн худалдаа “Амар байна уу-2023” үйл ажиллагаа зохион байгуулагдсан бөгөөд 69 жижиг, дунд үйлдвэр, эрхлэгчдийг оролцуулан 693,311,700 төгрөгийн борлуулалтын орлого хийгдсэн. Тус үзэсгэлэн худалдааны хүрээнд байгууллагаас санаачлан үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг 01 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж төрийн албан хаагчид болон иргэд, үйлдвэр эрхлэгчдийг оролцуулсан. Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Нийслэлийн нээлттэй хаалганы өдөрлөг” үзэсгэлэн	90

						худалдаанд дүүргийн 9 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг оролцуулан 3,690,000 төгрөг, “Чингэлтэйн фестиваль” арга хэмжээний хүрээнд 05 сарын сарын 27-ны өдөр үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 17 үйлдвэрлэгчийг оролцуулан 3,069,000 төгрөг, Монгол улсад нисэх хүчин үүсч хөгжсөний 98 жилийн ойн баярыг тохиолдуулан Буянт-Ухаа Олон Улсын нисэх онгоцны буудалд 2023 оны 05 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд “AIR SHOW-2023” үйл ажиллагаа зохион байгуулагдсан ба 3 үйлдвэрлэгчийг оролцуулан 4,800,000 төгрөг, “Бүтээлч болгоё” үзэсгэлэн худалдаанд 22 үйлдвэрлэгчийг оролцуулан 51,416,500 төгрөг, Үндэсний Их баяр наадмын өдрүүдэд зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд 24,424,000 төгрөг, Төв цэнгэлдэх хүрээлэн үзэсгэлэн худалдаа 07 дугаар сарын 11,12-ны өдрүүдэд 29 иргэнийг оролцуулан 42,481,000 төгрөг, "Хантайшир-2023" баяр наадмын үзэсгэлэн худалдаа 2023 оны 08 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 7,950,000 төгрөг, "Даншиг наадам-Хүрээ цам 2023" наадмын үзэсгэлэн худалдаанд 28 үйлдвэрлэгч оролцуулан 15,800,000 төгрөг, НҮҮДЭЛЧИН” дэлхийн соёлын фестиваль 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс 20-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 22 үйлдвэр эрхлэгчийг оролцуулан 29,108,000 төгрөг, “Хичээлийн шинэ жил” үзэсгэлэн худалдаанд 28 үйлдвэрлэгч оролцуулан 10,311,000 төгрөг, “Морьт харваа”	
--	--	--	--	--	--	---	--

					үзэсгэлэн арга хэмжээнд 3 үйлдвэрлэгийг оролцуулан 3,310,000 төгрөг, “Мишээл Экспо” олон улсын үзэсгэлэн худалдааны төв, “Арьс шир, Ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн холбоо” ТББ хамтран “Арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн-2023” үзэсгэлэн худалдааг 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс 23-ны өдрийн хооронд зохион байгуулж 12 үйлдвэрлэл эрхлэгч 15 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцон 35,125,000 төгрөг, Тусгаар тогтнолын талбайд 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 03-ны өдөр зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд 5 үйлдвэрлэгчийг оролцуулан 4,280,000 төгрөг, “Мишээл Экспо” олон улсын үзэсгэлэн худалдааны төвөөс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Өвлийн гоёл-2023” үзэсгэлэн худалдааг 2023 оны 11 дүгээр сарын 09-12-ны өдрийн хооронд зохион байгуулагдаж 28 үйлдвэр эрхлэгч 15 нэр төрлийн бүтээгдэхүүнээр, оролцож нийт 66,130,000 төгрөг, “Мишээл экспо” ОУХТөвд зохион байгуулагдсан “Чингэлтэйд үйлдвэрлэв-2023” үзэсгэлэн худалдаанд 123 үйлдвэрлэгч оролцож 152,557,000 төгрөгийн борлуулалтын орлого тус тус хийгдсэн. Гадаад үзэсгэлэн, худалдаа: ОХУ-ын Эрхүү хотод Олон улсын үзэсгэлэн худалдаа 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 27-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 4 үйлдвэр эрхлэгчийг /Шүүдэр брэнд, Цэ брэнд, Бат-Эрдэнэ, Тосон гэр брэнд/-ийг дэмжлэг үзүүлэн	
--	--	--	--	--	--	--

						оролцуулсан бөгөөд 4,000,000 төгрөг, БНХАУ-ын Фужао хотын үзэсгэлэн худалдаа 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 21-ний өдрүүдэд зохион байгуулагдаж 10 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг оролцуулан 33,690,000 төгрөгийн борлуулалт, 2 үйлдвэр эрхлэгч хамтын ажиллагааны гэрээ байгуулж, ОХУ-ын Улаан-үүд хотод Бүгд найрамдах Буриад улс байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд орос, монгол улсын хамтарсан үзэсгэлэн худалдаа 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 27-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 3 үйлдвэр эрхлэгчийг /"Гэгээн шүүдэр" брэнд, "Цэ" брэнд, "Ганга" кашмер брэнд/ оролцуулан 10,000,000 төгрөг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод зохион байгуулагдсан "Олон Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын чуулга уулзалт" арга хэмжээнд 20 үйлдвэрлэгчийг оролцуулан 56,650,000 төгрөг борлуулалт, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод зохион байгуулагдах "Монгол хятадын IV экспо" үзэсгэлэн арга хэмжээнд 24 үйлдвэрлэгчийг оролцуулж 126,500,000 төгрөг, Оросын холбооны улсын Улан-Удэ хотноо Буриад улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Олон улсын Универсал "Орос-Монгол үзэсгэлэн яармаг-2023" энэ оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс 21-ний өдрүүдэд зохион байгуулагдаж 6 үйлдвэрлэгч оролцож 29,855,000 төгрөг, Япон улсад зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд 199 ширхэг бараа бүтээгдэхүүнээр 12 үйлдвэрлэгчийг оролцуулан 3,014,000 төгрөг, Монгол	
--	--	--	--	--	--	--	--

						Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Бүгд Найрамдах Франц Улсад зохион байгуулагдсан “Чингис Хаан–Монголчууд дэлхийг өөрчилсөн нь” Олон улсын үзэсгэлэнд 3 үйлдвэр эрхлэгч гар урлал, арьсан эдлэлийн чиглэлээр оролцон 250 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүн танилцуулж 18,000,000 төгрөгийн борлуулалт, Америкийн нэгдсэн улсын Чикаго хотод зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд 15 үйлдвэрлэгчийг тус тус оролцуулсан.	
5.3.3	“Нөхөрлөл, хоршоо”, “Инноваци, гарааны бизнес-Старт апп”, “Кластер”-аар хөгжих чиглэлийн сургалт, үйл ажиллагааг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулах		Зохион байгуулсан сургалт, хамруулсан үйлдвэрлэгчдийн тоогоор	6 удаагийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 191 үйлдвэрлэгчийг хамруулсан байна.	4-5 удаагийн сургалт, үйл ажиллагаанд 220 үйлдвэрлэгч хамруулсан байна.	Чингэлтэй дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 31 дүгээр тогтоолоор батлагдсан “Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” арга хэмжээ, “Үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн хүрээнд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд нөхөрлөл, хоршоог өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, эрх зүйн зохицуулалтыг сурталчлах, тэдний саналыг сонсох, харилцан туршлага солилцох, мэдээлэл өгөх зорилгоор “Нөхөрлөл, хоршоог өргөжүүлэх” сэдэвт сургалтад 30 үйлдвэрлэгч, “Кластераар хөгжсөн үйлдвэрийн туршлага судлах” сэдэвт сургалтад 40 үйлдвэрлэгч, “Хүлэмжийн аж ахуй эрхлэх нь” сэдэвт сургалтад 45 үйлдвэрлэгч, 1-3 дугаар хороод, 10-12 дугаар хороодтой хамтран “Хамтын хөгжил” сэдэвт 2 удаагийн уулзалт сургалтад 120 үйлдвэрлэгч хамрагдаж, нийт 5 удаагийн сургалт, үйл ажиллагаанд 235 үйлдвэр эрхлэгчийг хамруулсан. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас “Даавуун хэвлэлийн машин”-ны худалдан авалтыг хийж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг ханган	90

						ажиллаж байгаа бөгөөд оёдлын салбарыг кластерт оруулж хөгжүүлэх, шинэ технологи шингэсэн үйлдвэрлэл бий болгох, дотооддоо даавуун хэвлэл хийх боломжийг бүрдүүлсэн.	
5.3.4	“Санхүү”, “Маркетинг”, “Брэнд хөгжүүлэлт”, “Төсөл бичих аргачлал” сэдвээр сургалт, үйл ажиллагааг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулах	-	Зохион байгуулсан сургалт, хамруулсан үйлдвэрлэгчдийн тоогоор	6 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 170 үйлдвэрлэгчийг хамруулсан.	4-5 удаагийн сургалт үйл ажиллагаанд 220 үйлдвэрлэгч хамруулсан байна.	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд мэдлэг, мэдээлэл өгөх зорилгоор Санхүү, маркетинг, брэнд хөгжүүлэлт” сэдэвт 1 удаагийн сургалтад 20 үйлдвэрлэгч, “Төсөл бичих аргачлал сэдэвт 2 удаагийн сургалтад 50 үйлдвэрлэгч, 4-6 дугаар хороод, 13, 14 дүгээр хороодын үйлдвэр эрхлэгч нарт “Хамтын хөгжил” сэдэвт 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, төсөл бичих аргачлал, санхүү маркетингийн чиглэлээр нийт 7 удаагийн сургалтад 230 үйлдвэр эрхлэгчийг хамруулсан.	90
5.3.5	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй”, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, татварын талаар сургалт, үйл ажиллагааг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулах	-	Зохион байгуулсан сургалт, хамруулсан үйлдвэрлэгчдийн тоогоор	2 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 90 үйлдвэрлэгчийг хамруулсан.	3-4 удаагийн сургалт үйл ажиллагаанд 120 үйлдвэрлэгч хамруулсан байна.	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй ба татвар, нийгмийн даатгал” сэдэвт сургалт, үйл ажиллагааг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан бөгөөд танхимаар 40 үйлдвэр эрхлэгч, цахимаар 20 үйлдвэр эрхлэгчийг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн даатгал, улсын бүртгэл”-ийн чиглэлээр мэдээлэл өгөх сургалтад 30 үйлдвэрлэл эрхлэгчийг, Улсын бүртгэлийн хэлтсээс иргэдэд тоон гарын үсэг олгох, бүртгэлтэй холбоотой мэдээлэл олгох сургалтад 80 үйлдвэрлэгчийг, нийгмийн даатгалын ач холбогдлын талаарх сургалтад 40 үйлдвэрлэгчийг тус тус хамруулсан.	90
5.3.6	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг		Зохион байгуулсан	17 удаагийн сургалтаар	Жилд 20 удаагийн сургалтаар	“Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” арга хэмжээ, “Үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн хүрээнд нийт 134 удаагийн сургалт,	90

	хөгжүүлэх, чадваржуулах, мэргэшүүлэх урт болон богино хугацааны багц сургалтуудыг бусад хамтран ажиллагч байгууллагуудтай үе шаттай зохион байгуулна.		сургалт, оролцуулсан үйлдвэрлэгчдийн тоогоор	давхардсан тоогоор 279 үйлдвэрлэгчийг хамруулсан байна.	давхардсан тоогоор 650 үйлдвэр эрхлэгчийг хамруулсан байна.	үйл ажиллагаанд 4917 үйлдвэрлэгчийг хамруулсан. Үүнд: Хүнсний давсаар бэлэг дурсгалын зүйл хийх “Давсан урлал” сургалтыг сургагч багш М.Уранболор зааж, 4 удаа зохион байгуулан 70 иргэн хамрагдан цаашид 6 иргэн гэрээр хийж худалдаалж эхэлсэн, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвтэй хамтран “Хамтдаа бүтээе” төслийн хүрээнд ноосон эдлэлээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх сургалтын танхим байгуулсан бөгөөд ноосоор эцсийн бүтээгдэхүүн хийх онол практик хосолсон урт хугацааны багц сургалтын хөтөлбөр боловсруулан С.Мөнхсоёл багшийн удирдлага дор зохион байгуулж 60 үйлдвэр, Технологи сургалтад-41, “Бизнесээ эхэл, Бизнесээ хөгжүүл” сертификат олгох 2 үе шаттай сургалтыг Д.Бямбасүрэн багш удирдан явуулж 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 14, 24-нөөс 28-ны өдрүүд, 10 дугаар сарын 16-ны өдрөөс 20-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан бөгөөд нийт 60 үйлдвэр эрхлэгч, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвтэй хамтран “Дижитал бизнес” сургалт, үйл ажиллагааг 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж үйлдвэр эрхлэгч өөрийн брэндийн вэйб бүтээх, хэрэглэгчийн судалгаа хийж дүгнэлт гаргаснаар хэрэглэгчээ зөв тодорхойлж борлуулалтаа нэмэгдүүлэх аргачлалд суралцаж харилцан санал солилцсон бөгөөд 25 үйлдвэрлэгч, “Хагас ухмал нүхэн зоорь байгуулах технологи” сургалтад 2 үйлдвэрлэгч, Хүүхдийн номын өргөөтэй хамтран жижиг, дунд	
--	---	--	--	---	---	---	--

						үйлдвэр эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах зорилгоор 3 үйлдвэр эрхлэгчийн ажлын байртай танилцах арга хэмжээг зохион байгуулж зөвлөх үйлчилгээг үзүүлж, 61 дүгээр сургуулийн төгсөх ангийн 30 сурагч, дүүргийн Залуучуудын холбоотой хамтран хөдөлмөрт бэлтгэх сургалтыг зохион байгуулж 23, 24 дүгээр сургуулийн 60 сурагч, “Хүүхэд хөгжлийн цогцолбор” УТҮГ-тай хамтран дүүргийн 5, 149 дүгээр сургуулийн 6, 7, 8, 9 дүгээр ангийн сурагчдын дунд чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөгжүүлэх хөдөлмөрт бэлтгэх зорилгоор хүнсний давсаар бэлэг дурсгалын зүйл хийх “Давсан урлал” сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтыг сургагч багш М.Уранболор удирдан явуулж 40 сурагчийг тус тус хамруулсан.	
5.3.7	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд төслийн болон зээлийн зөвлөгөө, мэдээлэл өгч, төсөлд хамруулах ажлыг зохион байгуулж ажиллана.	-	Зөвлөгөө мэдээлэл авсан, төсөлд хамруулсан үйлдвэрлэгчдийн тоо	730 үйлвэрлэгчдэд зөвлөгөөмэ дээлэл өгч 95 үйлдвэрлэгчийг зээлд холбон зуучилсан.	800 жижиг, дунд үйлдвэрлэгчид төслийн зөвлөгөө, мэдээлэл өгч, 110 үйлдвэрлэгчийг зээлд холбон зуучилна	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас хөнгөлөлттэй зээлийн мэдээллийг 30 үйлдвэр эрхлэгч, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн Хөдөлмөр эрхлэлтийн сангаас зарлагдсан “жижиг зээл”-ийн мэдээллийг 104 үйлдвэр эрхлэгчид ганцаарчилсан байдлаар хүргэсэн ба нийт давхардсан тоогоор 305 үйлдвэр эрхлэгчид төсөл, зээлийн талаарх зөвлөгөө мэдээллийг хүргэж ажилласан. Олон улсын болон банк санхүүгийн байгууллагаас зарлагдсан төсөл хөтөлбөр, зээл, буцалтгүй тусламжийн мэдээллийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид тухай бүр хүргэн ажилласан бөгөөд Жижиг, дунд үйлдвэрийн газраас зарлагдсан ЖДҮ-ийн зээлд 30 үйлдвэр эрхлэгчийг холбон	90

						зуучилснаас 2 үйлдвэр эрхлэгч 100,000,000 төгрөг, Нөмөр ББСБ, БЭЭТ-өөс зарлагдсан зээлд 25 үйлдвэрлэл эрхлэгчийг холбон зуучилснаас 25 үйлдвэр эрхлэгч 50,000,000 төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн “”жигжиг зээл”-ийн сургалтад 104 үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулснаас 20 үйлдвэрлэл эрхлэгч 700,000,000 төгрөг, нийт 159 үйлдвэрлэл эрхлэгчийг төсөл хөтөлбөр зээл, тусламжид холбон зуучилснаас 3 эх үүсвэрийн зээлд 47 үйлдвэрлэгч 850,000,000 төгрөгийн зээл тусламжийн дэмжлэгт хамрагдсан байна.	
5.4 Үйлдвэрлэл эрхлэгчдэд: төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах бодлогын зорилтын хүрээнд							
5.4.1	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх, 2023 оны шинэчлэгдсэн судалгаанд хамруулж, баяжилт хийж, цахим мэдээллийн сан үүсгэж ажиллана.	-	Шинэчлэгдсэн судалгаанд хамрагдсан үйлдвэр эрхлэгчдийн хувиар	826 үйлдвэрлэл эрхлэгчдийг шинэчилсэн судалгаанд 100% хамруулж ажилласан.	Цахим мэдээллийн нэгдсэн санд 100 хувь бүртгэж ажилласан байна.	Байгууллагад бүртгэлтэй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдээс 2023 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагаагаа зогсоосон болон бусад дүүрэгт шилжсэн шалтгаанаар 15 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг мэдээллийн сангаас хассаж, шинээр 73 үйлдвэр эрхлэгч бүртгүүлсэн байна. Мэдээллийн нэгдсэн санд оёдлын чиглэлээр 434 үйлдвэр эрхлэгч, гутлын чиглэлээр 83, модон эдлэл 106, төмөр хийц 33, арьсан чиглэлийн 34, сүлжмэлээр 50, эсгий эдлэлийн 29, бэлэг дурсгалын 13, бусад чиглэлийн 102, нийт 884 үйлдвэр эрхлэгч бүртгэлтэй байсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 912 үйлдвэрлэгч мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй байна.	100
5.4.2	Залуучуудын хөгжлийн сарын хүрээнд “Залуу үйлдвэрлэл эрхлэгчдийн	-	Зохион байгуулсан сургалтад хамрагдсан	-	1-2 удаагийн сургалт, үйл ажиллагаа	“Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” арга хэмжээ, “Үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Бишрэлт зочид буудлын сургалтын танхимд “Бизнес эрхлэгч	100

	туршлага солилцох, бизнесээ хөгжүүлэх” сургалт, өдөрлөг үйл ажиллагааг зохион байгуулна.		үйлдвэрлэгч-пдийн тоогоор		нд 20-30 үйлдвэрлэгч хамруулсан байна.	залуучууд” үйл ажиллагааг 18-35 насны залуу жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хамруулан зохион байгуулж 30 жижиг, дунд үйлдвэр эрхлэгч залуусыг хамруулж зохион байгуулсан.	
5.4.3	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг харуулсан контент бэлтгэн цахим сувгаар дамжуулан олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.	-	Хамрагдсан үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо, сурталчилсан байдал	50 үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагааг сурталчлан борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан.	15-20 үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагааг хуваарийн дагуу сурталчлан борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 31 дүгээр тогтоолоор батлагдсан “Чингэлтэйд үйлдвэрлэв” арга хэмжээ, “Үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн хүрээнд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтын орлогыг дэмжих зорилгоор “Сэтгүүл болон видео танилцуулга хийлгэх ажлын хэсэг байгуулах тухай” үйлдвэрлэл эрхлэгчдийн инновацлаг санааг шингээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг харуулсан видео танилцуулгыг “Юникфилм партнершип” ХХК-тай хамтран хийсэн бөгөөд “Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн инновац” төслийн хүрээнд 30 үйлдвэр эрхлэгчийг хамруулан уулзалт зохион байгуулж видео танилцуулгын зохиол, судалгаа 2 сарын турш хийгдэж иргэд, олон нийт, үйлдвэр эрхлэгчдэд байгууллагын цахим хуудас болох “Чингэлтэй дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв”-д тогтмол байршуулж сурталчлан ажилласан.	90
5.4.4	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах,		Сэтгүүлд хамруулсан үйлдвэрлэгч-дийн тоо, сурталчилсан байдлаар	-	50-100 үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагааг сурталчлах	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/11 даргын тушаалаар “Сэтгүүл болон видео танилцуулга	90

	борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор сэтгүүлийн эхийг бэлтгэж, хэвлүүлэх ажлыг зохион байгуулах				ажлыг зохион байгуулж, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.	хийлгэх ажлын хэсэг байгуулах тухай” ажлын хэсэг байгуулагдан үйлдвэрлэл эрхлэгчдийн инновацлаг санааг шингээсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтын орлогыг дэмжих зорилготой сэтгүүлийг бэлтгэн сэтгүүлд байрших 92 үйлдвэр эрхлэгчдийн судалгааг гаргаж холбогдох мэдээллийг боловсруулан орчуулгын ажлыг хийж, эх бэлтгэх, бүтээгдэхүүний зураг авалтыг ажлын байр, натур /байгал/-д тус тус зохион байгуулж 4200 ширхэг сэтгүүл, “Үнэн сонин”-д онцлох жилийн хүрээнд хийгдсэн томоохон ажлууд болон үйлдвэрлэгчдийг сурталчлах зорилгоор дэмжлэг үзүүлж хэвлүүлэн олон нийтэд танилцуулж иргэд, үйлдвэр эрхлэгчдэд хүргэх ажлыг тус тус зохион байгуулсан.	
5.4.5	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн, бүтээлийг сурталчлах зорилгоор эвинд, цогц арга хэмжээг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулна.		Зохион байгуулсан өдөрлөг, үзэсгэлэн худалдаанд хамруулсан үйлдвэрлэгчдийн тоогоор	-	Эвент, цогц арга хэмжээнд 80-150 үйлдвэрлэгчийг хамруулж сурталчлан, борлуулалтын орлогыг нэмэгдүүлж ажилласан байна.	Нийслэлийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хамруулан зохион байгуулсан “Бүтээлч болГОЁ” олон улсын үзэсгэлэн худалдаа, хөрөнгө оруулалтын цогц үйл ажиллагаа 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 20-ны өдрийг дуустал Сүхбаатарын талбайд 8 өдрийн турш зохион байгуулагдсан бөгөөд дүүргийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийнхээ бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчилснаар борлуулалтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Бүтээлч дүүрэг” өдөрлөг, үзэсгэлэн худалдаа, загварын үзүүлбэр,	90

						өв соёлыг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулсан.	
5.4.6	Дүүргийн бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн чиглэл тус бүрээс “Шилдгийн шилдэг бүтээгдэхүүн”-ийг шалгаруулах арга хэмжээг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулах	8.800.00 0	Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамруулсан үйлдвэрлэгчийн тоо	-	1-2/20-60	“Монголын Үндэсний уламжлалт уран хатгамалчдын холбоо” НҮТББ-тай хамтран 2023 оны 11 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд уран хатгамалчдын улсын 4 дүгээр уралдааныг зохион байгуулж үндэсний уламжлалт уран хатгамал, зүү ороосон, задгай буюу хөрөг хатгамал, мартагдаж буй соёлын өвийг сэргээж урласан хатгамал, эсгий ширмэл, зоос ширээний сүлжмэл, зээгт наамал гэсэн 7 төрлөөр 1,2,3 дугаар болон тусгай байр эзлүүлэн өргөмжилж, тэргүүн байранд шалгарсан 7 хүнд “МОНГОЛ УЛСЫН УРАН ХАТГАМАЛЧ” цол олгогдсон. Уралдаанд нийтдээ 150 иргэн оролцсон бөгөөд “Уран хатгамалчдын үндэсний анхдугаар чуулган” –д 21 аймаг 9 дүүргээс танхимаар-559, цахимаар 600 гаруй хүн оролцож, хуралдааны үйл ажиллагааг орон даяар нээлттэй цахимаар дамжуулж нийтдээ 1159 уран бүтээлээрээ оролцсон. Хатгамалчид цаашид хамтран ажиллах анхны стратегийг чуулганаар хэлэлцэн, чуулганаас гарах зөвлөмжийн төслүүдийг танилцуулан хэлэлцүүлж, төлөөлөгчдийн саналыг авч нэгтгэн үйл ажиллагаандаа тусган ажиллах 5 жилийн стратегийн төслийг гаргасан бодит үр дүн гарсан.	100
5.4.7	Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн дунд “Уран үйлчин” уралдааныг тусгай	-	Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамруулсан	-	50-100 оёдлын чиглэлээр үйл ажиллагаа	“Уран үйлчин-2023” оёдлын салбарын уралдааныг 3 үе шаттайгаар зохион байгуулсан ба 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр “Холидэй Инн” зочид буудлын Ballroom танхимд нээлтээ хийж	100

	удирдамжийн дагуу зохион байгуулах		үйлдвэрлэгчдийн тоо		явуулдаг үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулж ажилласан байна.	оёмол бүтээгдэхүүний оёдолчны онолын мэдлэг олгох сургалт, техникийн зөвлөгөөнөөр эхлүүлсэн. <i>Нэгдүгээр шалгаруулалт:</i> Нийслэлийн Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн хөгжлийн төвд 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр онолын шалгалтад 121 оёдолчин хамрагдсанаас 42 оёдолчин шалгаруулалтад тэнцсэн. <i>Хоёрдугаар шалгаруулалт:</i> 2023 оны 05 дугаар сарын 28-ны өдөр “Асралт баян хайрхан”ХХК, “Өнөр баян хайрхан” ХХК, “Гоо од” ХХК-ний үйлдвэрийн байранд ур чадварын уралдааныг зохион байгуулж 42 үйлдвэр эрхлэгч оролцсоноос үндэсний хувцас, европ хувцас, хөдөлмөр хамгааллын хувцас гэсэн 3 төрөл тус бүрд эхний таван байрыг шалгаруулж, “Мастер оёдолчин” цолны болзол хангасан 15 оёдолчин “Оёдлын салбарын нэгдсэн мэргэжлийн холбоо” ТББ-аас Монгол улсын “Мастер оёдолчин” цол авсан ба давхардсан тоогоор нийт 250 үйлдвэр эрхлэгчийг хамруулж ажилласан.	
5.4.8	Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэгчдийг “Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв”-үүдийн удирдлага, оюутнуудыг хамруулан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах		Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамруулсан үйлдвэрлэгчдийн тоо	-	1-2 удаагийн сургалт, үйл ажиллагаанд 30-60 үйлдвэрлэгчийг хамруулж ажилласан байна.	Чингэлтэй дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, ШУТИС-ийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн хөтөлбөрөөр урт болон богино хугацааны танхимын, онлайн сургалт, семинар зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, төсөл хөтөлбөрт хэрэгцээтэй байгаа мэдлэг мэдээллийг өгөх сургалтын батламж сертификат олгох зэргээр 2 жилийн хугацаанд хамтран ажиллах гэрээ, ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын Хөдөө аж ахуй, хувийн хэвшлийн	100

						хамтын ажиллагаа, ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын хэрэгжүүлж буй зарим төсөл хөтөлбөрт хамтран ажиллах, ЖДҮ эрхлэгчдийг бизнесийн олон талт сургалтад хамруулах, сайн дурын ажилтан томилон ажиллуулах болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх, дүүргийн тэргүүлэх чиглэлийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг Японы үйлдвэрт дадлагажиж сайн туршлагыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж болон Хүнс хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах талаар санал солилцон ажилласан. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Технологийн сургууль, Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж, “Их засаг” Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, “Энэрэл” Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран “Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч ба хүний нөөцийн асуудал, шийдэл” уулзалт, хэлэлцүүлгийг 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр “Бишрэлт” зочид буудлын хурлын танхимд зохион байгуулж хэлэлцүүлэгт 10 зочин илтгэгч, 80 оюутан залуус болон 30 үйлдвэр эрхлэгчдийг хамруулсан.	
--	--	--	--	--	--	---	--

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАЯРМАА

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

5 ЗОРИЛТ

- **ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО- 50 арга хэмжээ**
- **ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО-34 арга хэмжээ**
- **ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО БЭХЖҮҮЛЭХ-59 арга хэмжээ**
- **НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО-5 арга хэмжээ**
- **НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО-26 арга**

НИЙТ-174 арга хэмжээ

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, 174 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулан биелэлтийг хагас бүтэн жилээр нэгтгэн ажиллаж байна. Байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2023 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт 91.1 хувийн биелэлттэй байна.